DEZA
DDC
DSC
SDC
COSUDE

**АМГТХЭГ**
**Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газар**

# ТӨСӨЛ

Монголын хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх

# Тогтвортой бичил уурхай төслийн баримт бичиг

(2007-1 сарын 1-нээс 2010-12-сарын 31)
төслийн үндсэн шат

***Бичил уурхайн талаарх олон улсын хэмжээнд баримталж буй хэтийн төлөв:***
(Хариуцлагатай уул уурхайн ассоциаци, 2006-5 сар)

***Бичил уурхай нь үр ашигтай техник технологи хэрэглэн, нийгэм, хүрээлэн буй орчны хувьд тодорхой үүрэг хариуцлага хүлээсэн, албан ёсны, зохион байгуулалт бүхий ашгийн төлөө үйл ажиллагаа байна. Энэ салбарын үйл ажиллагаа байхаас гадна олон талт байдлыг хүндэтгэх, сайн засаглал, шударга хууль ёс, идэвхитэй оролцооны нөхцөл бүрдсэн орчинд хөгжиж дэвших бололцоотой, эрдэс баялаг, үнэт эдлэлийн улам бүр өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнд тулгуурлан орон нутгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах,ажлын байр бий болгоход өөрийн хувь нэмрээ оруулдаг байна.***

## Оршил

Монгол улс нь ашигт малтмалаар нэлээд баялаг орон. Ашигт малтмалын нөөц баялгийг оновчтой, зөв ашиглах арга замын талаар Монгол улсын Засгийн газар, үндэсний болон олон улсын компаниуд, иргэд хоорондын хэлэлцүүлэг, харилцан ярилцлага нэлээд эрчимтэй өрнөж байна. Сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол орны эдийн засаг зэс, алтны экспорт, татварын орлогоос ихээхэн ашиг олж байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах боллоо. 1999-2001 оны өвлийн зуднаар олон мянган малчид амьжиргааны эх үүсвэр болсон малаа алдсанаар ашигт малтмалыг албан бусаар олборлох салбар үүсэж, өнөөгийн байдлаар энд ажиллагсдын too 100,000-д хүрээд байна. Эдгээр хүмүүсийн нэлээд хэсэг нь малгүй болсон малчид, хөдөөгийн төв, суурин газрын ядуу иргэдээс бүрдэж байгаа юм. Түүнчлэн сургалтын төлбөрөө олох гэсэн оюутнууд, бага цалинтай төрийн албан хаагчид, ажилтнууд ч энэ ажиллагаанд оролцож байна.

Мянганы хөгжлийн зорилтод тулгуурлан Монголын Засгийн газраас боловсруулсан 2007-2021 оны хөгжлийн стратегид хувийн хэвшлийн салбарт түлхүү анхаарч, эдийн засгийн өсөлтийг бий болгох, түүгээр дамжуулан ядуурлыг бууруулах бодлогыг тусгаж хэрэгжүүлэх нь нэн тэргүүний асуудал болж байна.

Нийт хүн амын бараг тал хувийн амьжиргаа нь байгалийн өгөөжөөс хамаардаг тул тогтвортой хөгжлийн гол хүчин зүйлийн нэг нь байгалийн нөөцийн зөв менежментийг хэрэгжүүлэх явдал юм. Гэтэл албан бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Тухайлбал: усыг мөнгөн ус ба бусад хорт бодисоор бохирдуулах, бэлчээр нутгийг сүйтгэх, бут сөөг модлог ургамлыг түлшинд хэрэглэх зэргээр байгаль орчныг доройтуулсаар байна. Үүний зэрэгцээ малчид, орон нутгийн иргэд, албан ёсны уул уурхайн компаниудтай зөрчил үүсэж байгаа нь тийм ч гайхах зүйл биш болоод байна.

Бичил уурхай эрхлэгчид нь алтны борлуулалтаас жилд 100 сая ам. долларын орлого олж байгаа нь хөдөөгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах боломжтой гэж Засгийн газраас үзээд бичил уурхайг хөгжүүлэх талаар анхаарч байна. Швейцарийн хөгжлийн агентлаг болон Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ)-аас хамтран Бичил уурхайг дэмжих (БУД) төслийг 2005 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд АМГТХЭГ-ын бүрэлдэхүүнд Бичил уурхайн нэгж байгуулагдаж бичил уурхайтай холбогдох асуудлыг хариуцаж байна. Түүнчлэн Бичил уурхайн тухайн хуулийн төслийг Швейцарийн хөгжлийн агентлаг, АМГТХЭГ-ийн мэргэжилтнүүд хамтран боловсруулж Улсын их хурал (УИХ)-д өргөн бариад байна. Энэхүү хуулийн төсөлд бичил уурхай эрхлэгчдийг зохион байгуулалтанд оруулах, тэдний хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал, хүүхэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг зохицуулах тухай заалтууд орсоны дээр, уул уурхайн албан ёсны том үйлдвэр, компаниудтай харилцах харилцааг Ашигт малтмалын хуультай уялдуулан зохицуулах механизмыг тусгасан болно. БУД төсөл Баянхонгор аймгийн хоёр сумын бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас гарч буй өөрчлөлтүүдийг тогтоох үүднээс төсөл нь тус хоёр суманд байгаль орчны нөлөөллийн болон нийгэм, эдийн засгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж нийгэм, экологийн үндсэн суурь үзүүлэлтүүдийг тогтоосон.

БУД төслийн туршилтын шатыг амжилттай хэрэгжүүлснээр Швейцарийн хөгжлийн агентлаг, АМГТХЭГ төслийн үндсэн шатыг 2007-2010 онд хэрэгжүүлэх, дараагийн хоёр жилийг төгсгөлийн үе шат болгохоор төлөвлөж байна. 2006 оны 7 сард гадаадын байгууллагаас хийсэн төслийн үнэлгээ, оролцооны төлөвлөлт, төслийн үндэсний болон олон улсын хамтрагч талуудтай хийсэн уулзалт ярилцлагын үзэл баримтлалын дагуу төслийн үндсэн шатны зорилго нь бичил уурхайг хөдөөгийн тогтвортой хөгжлийг хангах эдийн засгийн гол дэд салбар болгон хөгжүүлэхэд бүх оролцогч талуудтай хамтран ажиллаж Монгол улсад хариуцлагатай бичил уурхайг дэмжин хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэгдэнэ. Төсөл нь а) бичил уурхайн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;

б) бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх; в) хариуцлагатай бичил уурхай ба бичил уурхай эрхлэгчдийн хөгжлийн асуудлууд; г) гарч буй зөрчлүүд, байгаль орчныг хамгаалах асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тогтооход туслах, холбогдох талуудтай хамтран ажиллах болно. Хөгжлийн чадавхи, жендер, засаглалын асуудлуудыг нэлээд нухацтай авч үзэж, асуудал бүрийн тухайн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт гаргуулдаг байна.

АМГТХЭГ, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран байгуулсан төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийг хэрэгжүүлэх болно. Төслийн үндсэн шатанд Швейцарийн хөгжлийн агентлаг төслийн үйл ажиллагааг удирдах зохицуулагчийг томилон ажиллуулах ба төгсгөлийн шатанд АМГТХЭГ-ийн бичил уурхайн нэгжийн удирдах ажилтан төслийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулна. Төслийн үйл ажиллагааг үндсэн 4 бүрэлдхүүн хэсэгт хуваан хэрэгжүүлэх бөгөөд хэсэг бүрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хариуцсан багийн удирдагчид байна. Үндэсний ба олон улсын зөвлөхүүд техникийн болон мэргэжлийн зөвөлгөө өгч, туслаж байх бөгөөд бичил уурхай эрхлэгчдийн дотоод сүлжээг бий болгож, олон улсын сүлжээнд холбох үүргийг гүйцэтгэнэ. Төслийн ашиг тусыг гол хүртэгчид нь бичил уурхай эрхлэгчид байхаас гадна тэд төслийн үйл ажиллагааг хянахад оролцоно.

Нийт 8 сая швейцари франкийн санхүүжилт бүхий энэ Тогтвортой бичил уурхайн төслийг хэрэгжүүлэхэд Швейцарийн хөгжлийн агентлаг 4,821,123 швейцари франк, АМГТХЭГ 281,767 швейцари франкийн хувь нэмэр оруулахаар төслийн санхүүжилт батлагдсан болно.

## Гарчиг

**ОРШИЛ** ........ **2**

**1 ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ** ........ **6**

*1.1.1 Монгол улсын хөгжлийн чиг хандлага* ........ *6*
*1.1.2 Монгол орны газар зүй, байгаль орчны нөхцөл байдал ба бичил уурхайн үйл ажиллагаа* ........ *7*
*1.1.3 Монгол орны нийгэм эдийн засгийн байдал ба бичил уурхай* ........ *8*
*1.1.4 Бодлого ба хууль эрх зүйн зохицуулалт* ........ *9*
*1.1.5 Швейцарийн хамтын ажиллагааны стратеги ба Швейцарийн хөгжлийн агентлагаас Монгол улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд* ........ *10*
*1.1.6 Донор, хандивлагчдын үзүүлж буй тусламж дэмжлэгтэй уялдуулах* ........ *11*
*1.1.7 Төслийн эхний ба туршилтын шатны үйл ажиллагааны хэрэгжилт* ........ *12*

**2 ҮНДЭСЛЭЛ** ........ **15**

2.1 Хөтөлбөрийн тодорхойлолт ........ 17
2.1 Хөтөлбөрийн тодорхойлолт ........ 17
2.2 Хариуцлагатай бичил уурхайг дэмжих Challenges to Support Responsible Artisanal Mining 17
2.3 Төслийн зорилго ба зорилтууд ........ 18
2.4 Хэрэгжилтийн стратегийн зарчмууд ........ 19
2.5 Гарах үр дүнгүүд ба хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги ........ 21
*2.5.1 Бүрэлдэхүүн хэсэг 1: Бодлого, эрх зүйн зохицуулалтын орчинг сайжруулах* ........ *21*
*2.5.2 Бүрэлдхүүн хэсэг 2: Бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох бэхжүүлэх* *25*
*2.5.3 Бүрэлдхүүн хэсэг 3: Орон нутгийн эдийн засгийн хөгжлийг сайжруулах ба хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх* ........ *28*
*2.5.4 Бүрэлдхүүн хэсэг 4: Нийгэм, байгаль орчны зөрчлийг бууруулах* ........ *31*
2.6 Төслийн хүлээгдэж буй үр нөлөө Expected Project Impacts ........ 33
*2.6.1 Бүрэлдхүүн хэсэг1: Бодлого, зохицуулалтын орчинг сайжруулах* ........ *34*
*2.6.2 Бүрэлдхүүн хэсэг 2: Бүтэц зохион байгуулалтыг сайжруулах бэхжүүлэх* ........ *34*
*2.6.3 Бүрэлдхүүн хэсэг 3: Орон нутгийн эдийн засаг ба хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх* ........ *34*
*2.6.4 Бүрэлдхүүн хэсэг 4: Нийгмийн ба байгаль орчинтой холбоотой гарч буй зөрчлийн бууруулах ажлыг сайжруулах* ........ *35*
2.7 Гол харилцагч, хамтрагч талууд ба төслөөс ашиг хүртэгчид ........ 35
*2.7.1 Бичил уурхай эрхлэгчид* ........ *35*
*2.7.2 Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ)* ........ *36*
*2.7.3 Аймаг, сумдын засаг захиргаа* ........ *36*
*2.7.4 Уул уурхайн албан ёсны компаниуд* ........ *36*
*2.7.5 Үйлдвэр худалдааны ба Байгаль орчны яам* ........ *36*
*2.7.6 Их сургуулиуд ба төрийн байгууллагууд* ........ *37*
*2.7.7 Олон улсын хамтрагч талууд* ........ *37*
*2.7.8 Хөтөлбөрөөс шууд бусаар ашиг хүртэгчид* ........ *37*
*2.7.9 Швейцарийн хөгжлийн агентлаг* ........ *37*
2.8 Үйл ажиллагааны зарчмууд ........ 38
2.9 Үйл ажиллагааны газар зүйн хамрах ........ 39
2.10 Хөтөлбөр хэрэгжих хугацаа ба гол чухал үечлэл ........ 40
2.11 Ерөнхий эрсдлүүд, таамаглал, эрсдлийг бууруулах стратеги ........ 40

**3 ТӨСЛИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА МЕНЕЖМЕНТ** ........ **43**

3.1 Гэрээ хэлэлцээр ........ 43
3.2 Төслийн менежмент ........ 43
*3.2.1 Төслийн төгсгөлийн стратеги* ........ *45*

**4 МОНИТОРИНГ БА ҮНЭЛГЭЭ** ........ **47**

*4.1.1 Хөтөлбөрийн үйл ажиллагаанд мониторинг хийх шалгуурууд* ........ *48*

**5 ХАМТРАГЧ ТАЛУУДЫН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР БА ТӨСЛИЙН ТӨСӨВ ХӨРӨНГӨ** ........ **49**

5.1 Үндэсний нөөц ба харилцагч, хамтрагч талуудын оруулах хувь нэмэр ........ 49
*5.1.1 Төрийн байгууллага* ........ *49*
*5.1.2 Хувийн салбар ба иргэний нийгэм* ........ *49*
*5.1.3 Швейцарийн хөгжлийн агентлаг ба бусад донорууд* ........ *50*

5.2 Хөтөлбөрийн төсөв ..... 50
5.3 Үндэсний ба олон улсын зөвлөхүүдийг урьж ажиллуулах ..... 52
*5.3.1 Олон улсын зөвлөхүүдийг ажиллуулах зорилго ..... 52*
*5.3.2 Бүрэдхүүн хэсэг бүрээр олон улсын зөвлөхүүдийн авч үзэх асуудлууд ..... 53*
5.4 Бичил уурхай салбарт хамтарч ажиллах гол байгууллагууд ба хамтран ажиллах боломжууд ..... 54
*5.4.1 ОУХБ/АЙПЕК-ийн “Хүүхдийн хүнд хөдөлмөрийг устгах үндэсний дэд хөтөлбөрийг дэмжих” төсөл ..... 54*
*5.4.2 НҮБ-ын хүн амын сангаас хэрэгжүүлж буй “Хот суурин газрын орчмын ба албан бус уурхай эрхлэгчдийн нийгэм эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах” ..... 55*
*5.4.3 Дэлхийн банк ..... 55*
*5.4.4 ХГУ-ын Гео-шинжлэх ухаан, эрдэс баялагийн хүрээлэн (BGR) ..... 55*
*5.4.5 Төрийн бус байгууллагууд ..... 55*
*5.4.6 Хувийн салбар ..... 56*

**6 АШИГЛАСАН МАТЕРИАЛ ..... 57**

**7 ТОВЧИЛСАН ҮГИЙН ТАЙЛБАР БА ЗАРИМ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ..... 57**

**8 ХАВСРАЛТУУД ..... 59**

8.1 Төслийн үйл ажиллагааны биелэлтийг хэмжих хүснэгт ..... 59
8.2 “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн гол хамтрагч харилцагч талуудад хийсэн дүн шинжилгээ ..... 61
8.3 “Тогтвортой бичил уурхай” төслийн баг ба төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь ..... 69
8.4 Донорууд ба тэдгээрийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслүүд, хамтын ажиллагааг хөгжүүлж болох салбарууд ..... 76

# 1 Хөтөлбөрийн тухай үндсэн мэдээлэл

Швейцари улсын Дэлхийн байгаль орчны хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгждэг Байгалийн нөөцийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхдээ Монгол улсын байгаль орчны салбарын өнөөгийн байдалд өгсөн үнэлэлт дүгнэлт нь тус орны бичил уурхайн[1] үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулахад хүргэсэн юм. Энэ салбар нь эдийн засгийн хувьд ирээдүйтэй, хүн амын нэлээд хэсэг, ихэнхидээ нийгмийн эмзэг давхрага ба ядуу хүмүүс хамрагддаг. Иймээс Швейцарийн хөгжлийн агентлаг Монгол улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрийнхээ нэгэн хэсгийг Швейцарийн Дэлхийн байгаль орчны хөтөлбөрөөр дамжуулан бичил уурхай эрхлэгчдэд чиглүүлэхээр шийдвэрлэж тус төслийн саналыг боловсруулан 2005 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Швейцарийн хөгжлийн агентлаг нь төслийг эхний ба туршилтын шаттайгаар нийт 8 жилийн хугацаанд 8 сая швейцари франкийн санхүүжилттэй хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төслийн эхний шатыг 1 жил 6 сарын хугацаатай хэрэгжүүлсэн бөгөөд үндсэн шатыг 4 жил, төгсгөлийн үеийг 2 жил байхаар төлөвлөж байна. Төслийн гол зорилго нь Монгол улсын хөдөөгийн иргэд түүний дотор алс хол нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих үүднээс бичил уурхай эрхлэх үйл ажиллагааг хөдөөгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулахад Монголын холбогдох талуудыг оролцуулж, тэднийг чадваржуулах, бэхжүүлэхэд чиглэнэ.

2005 оны 7 сараас үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй тус төслийн үйл ажиллагаанд гадаадын холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн үнэлгээний баг 2006 оны 6-7-р сард үнэлгээ хийсэн. Тус үнэлгээ нь төслийн үндсэн шатны үйл ажиллагааны ерөнхий цар хүрээ, бүтэц, төлөвлөлтийн загварын талаар зарим чиглэлийг гаргаж өгсөн. Үүний дагуу холбогдох талуудад танилцуулж, оролцооны төлөвлөлтийн зарчмаар хэд хэдэн уулзалт, ярилцлагыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

### *1.1.1 Монгол улсын хөгжлийн чиг хандлага*

Монгол улсын хөгжлийн хамгийн гол асуудалд ядуурал ба тэгш бус байдлыг бууруулах арилгах явдал орж байна. 1990 онд зах зээлийн тогтолцоонд шилжин орсноос хойш Монгол улсад ядуурал улам бүр өссөөр байна. 1995, 1998, 2002/2003 онуудад ядуурлын байдалд хийсэн судалгаанууд Монгол улсад 3 хүний нэг нь ядуу байна гэсэн үр дүнг гаргасан байна. Сүүлийн хэдэн жилийн байдлаар ядуурлын хэмжээ ердөө 4 % буюу 36 % -аас 32 % болж буурсан байна (Дэлхийн банк 2006). Гэхдээ энэ бууралт нь сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлтийн зөвхөн макро түвшинд гарсан үзүүлэлт байна. Ядуурал ялангуяа Монгол орны хөдөө орон нутагт өрх гэр бүлийн хэмжээнд маш их хэвээр байсаар байна. Нийт айл өрхийн 1/3 нь ядуу амьдарч байна. Эдгээр ядуу айл өрхийн ихэнхи нь хөдөө орон нутаг ба хот, төв суурингийн зах хэсгээр илүү төвлөрч байна.

Ядуурлын үндсэн шалтгаан нь ажилгүйдлийн улмаас орлогын эх үүсвэргүй байгаа байдал бөгөөд үүнээс гадна байгалийн гамшиг зэрэг гадаад хүчин зүйлс ч нөлөөлж байна. Үйлдвэрлэл ба уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэлт маш сул хөгжиж буй өнөөгийн нөхцөлд хөдөөгийн ядуу иргэдийн амьжиргаа байгалийн нөөцөөс хамааралтай болж байгаа нь тэдний амьжиргааг цаг уур, уур амьгалын хүчин зүйлээс шууд хараат болгож байна. Сүүлийн жилүүдэд тохиолдсон байгалийн гамшгийн үеэр бараг 11 сая толгой мал хорогдоод байна. Ядуурлын хэмжээ тус орны баруун бүс нутагт илүү өндөр (51 %) байгаа бөгөөд тус бүс нутагт Швейцарийн хөгжлийн агентлаг тусалж дэмжих үйл ажиллагааныхаа гол хэсгийг чиглүүлж байгаа билээ. 1999-2001 онуудад болсон зудын нөлөөгөөр хөдөөгийн ядуурал 41 %-д хүрсэн нь хот суурин газрын ядуурлын хэмжээ болох 32 %-аас давсан байна.

[1] Artisanal Mining means placer and underground mining operations that have limited capabilities to extract minerals from the aboveground and underground with hand tools or small scale technology. It will become formalized, organized and profitable economic entities using efficient technologies and having social and environmental responsibilities.

Улс орны хөгжлийн зорилго бол ядуурал, тэгш бус байдлыг бууруулах үүднээс нийгмийн эмзэг бүлэг ядуу хүмүүсийг дэмжин туслах, улмаар бүс нутгийн тэнцвэртэй хөгжилд хүрэхэд чиглэнэ. Энэ зорилго нь Монголын засгийн газраас Мянганы хөгжлийн зорилгыг хангах үйл ажиллагаанд илүү өргөнөөр тусгагдсан байна. Монгол улс одоогоор Мянганы хөгжлийн зорилгод үндэслэн 2007-2021 оны Үндэсний хөгжлийн стратегээ боловсруулж байна. Энэ стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэгт байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, үндэсний үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр бий болгох, боловсролын асуудал орж байна. Нийгмийн ядуу хэсэгт ажлын байр, орлогын эх үүсвэр бий болгох хувилбарт бичил уурхай эрхлэлт зүй ёсоор орж Үндэсний хөгжлийн стратегид тусгагдсан байна.

### *1.1.2 Монгол орны газар зүй, байгаль орчны нөхцөл байдал ба бичил уурхайн үйл ажиллагаа*

Монгол улс нь 1.6 сая х.д. км нутаг дэвсгэртэй, 2.5 сая хүн амтай бөгөөд хүн ам хамгийн сийрэг суурьшдаг орны нэг юм. Гэхдээ далайн түвшнээс дээш нэлээд өндөрт (дунджаар 1500 м) өргөгдсөн ба эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай, далайд гарах гарцгүй байдал нь тус орны байгаль орчныг улам бүр эмзэг болгож, байгалийн нөхөн сэргээлтийг удаашруулж байна. Иймээс Монгол орны хувьд байгаль орчинд ээлтэй менежмент, хамгааллын арга хэмжээ авах нь хамгийн чухал асуудлын нэг болоод байгаа билээ.

Эдийн засгийн гол салбарууд нь байгалийн нөөцөд түшиглэсэн учраас эдгээрээс үзүүлэх дарамт, сөрөг нөлөө нь байгаль орчинд илүү тусдаг. 1990 оноос хойш байгаль орчинтой зүй бус харьцаж, хурдан түргэн аргаар мөнгө олдог бизнесүүд нэлээд олон болсноор байгаль орчинд үзүүлэх дарамт эрчимтэй болж байна. Түүнчлэн хөдөө орон нутагт ажлын байр, орлогын эх үүсвэр хомс байгаа нь ялангуяа нийгмийн эмзэг хэсэг ядуу хүмүүсийг байгалийн нөөц баялаг (ойн нөөц, ан амьтан агнах, ургамал, самар, жимсийг их хэмжээгээр түүх, уул уурхайн олборлолт явуулах гм)-аа ямар ч хяналтгүйгээр ашиглахад хүргэж байна. Байгаль орчинд үзүүлэх эдгээр дарамт дээр дэлхийн уур амьсгалын дулаарал нэмэгдэж байна. 1960 оноос агаарын хэм +0.7-аар нэмэгдэж байгаа нь хур тунадас, ургамалжилт усны нөөц, тархцанд өөрчлөлт оруулж байна. Эдгээр хүний үйл ажиллагаа болон уур амьсгалын өөрчлөлт нь Монгол орны байгаль орчныг эвдрэл сүйрэлд ороход хүргэж байна. Өнөөгийн байдлаар нийт бэлчээрийн бараг 70 % нь талхагдалд орж, 1998 онд нутаг дэвсгэрийн 12 %-ийг эзлэж байсан ойн талбай 2002 онд 8 % болж бууран, цөлжилт газар авч байгаа нь ард иргэдийн амьжиргаанд аюул занал учруулж байна. Бэлчээр нутаг ба биологийн төрөл зүйлийн хомсдол, газрын доройтол, хөрсний бохирдол, усан хангамжийн дутагдалтай байдал нь байгаль орчны өнөөгийн тулгамдсан асуудлууд болж байна. Эдгээр нөхцөл байдлаас харахад байгалийн нөөцийг ***тогтвортой*** ашиглах менежментийн хэрэгцээ нэн тэргүүний асуудал болоод байгааг харуулж байна. Иймээс мал маллагаа, ашигт малтмалын олборлолт, мод бэлтгэл, газар тариалан, аялал жуулчлал, ан агнуур, эмийн ургамлын тариалалт болон бусад аж ахуйн үйл ажиллагаанд байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлж хэрэгжүүлэх нь урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, ***хөдөөгийн хөгжлийн стратегитэй уялдуулахад*** чухал ач холбогдолтой байна.

Төслийн туршилтын шатанд төслийн үйл ажиллагаа хэрэгжиж буй сумуудад хийлгэсэн Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний судалгаа (Адъяасүрэн ба бусад багийн гишүүд 2006)-гаар тус газар нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бичил уурхайн үйл ажиллагаатай холбож үзсэн байна. Үүнийг дагаад тухайн орон нутгийн хэмжээнд гарч буй хүндрэлтэй асуудлууд бол түлшний хэрэгцээ (тухайлбал тухайн орон нутгийн хүмүүс түлшиндээ мод, бут, сөөг, аргал ашигладаг), ус, хөрсийг мөнгөн ус, цианид зэрэг химийн хорт бодисоор бохирдуулж, газар нутгаа эмх замбраагүй ухаж нүх гарган, хог хаягдлаар бохирдуулж байгаль орчинг доройтуулж байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

### 1.1.3 Монгол орны нийгэм эдийн засгийн байдал ба бичил уурхай

Монгол орон ашигт малтмалын арвин нөөцтэй: одоогоор ашигт малтмалын 7000 гаруй илэрц, 80 гаруй орд тогтоогдсон байна. Эдийн засгийн хувьд хамгийн их ач холбогдолтой ашигт малтмалд өнгөт металл, алт, жонш орно. Эдгээр бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ тус орны хөрш хоёр оронд нэлээд их өндөр байгаа нь тус орны уул уурхайн салбарыг ялангуяа 1995 оноос хойш хурдацтай хөгжихөд хүргэсэн. Уул уурхайн салбар 1990-ээд оны 2-р хагасаас эхлэн эрчимтэй хөгжиж байна. 2005 онд уул уурхайн салбар нь ДНБ-ийн 21 % бүрдүүлж байгаа нь 1995 он (6.1 %)-той харьцуулахад нэлээд өссөн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний 73.0 %, экспортын орлогын 24% -ийг бүрдүүлж, гадаадын нийт хөрөнгө оруулалтын 1/3 –ийг эзэлж байна. Албан ёсоор ашигт малтмалын хайгуул хийж буй 130 компани байгаа бөгөөд үүнээс ч илүү тооны ашиглалтын лизенци бүхий компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна.

Бичил уурхай эрхлэгчдийн талаар Үндэсний статистикийн газраас гаргасан эдийн засгийн тооцоо/үнэлгээнээс харахад хүмүүс ядуурлаас гарах, амьжиргаагаа дээшлүүлэх үүднээс бичил уурхай эрхлэж байна гэж тогтоосон байна. Баянхонгор аймагт хийсэн судалгаагаар бичил уурхай эрхлэж буй өрхийн дундаж орлогыг тухайн аймгийн малчин өрхийн орлоготой харьцуулж үзэхэд 20-40%-аар илүү байна. Бичил уурхай эрхлэгчдийн орлого олох байдлыг малын зарим бүтээгдхүүн ноос, ноолуур (зөвхөн жилд нэг удаа хавар самнадаг)-ын бизнестэй харьцуулахад бараг байнгын хугацаанд байдаг гэж үзэж болно. Энэ нь тэдгээр хүмүүсийн өдөр тутмын амьдрал тухайлбал хоол хүнс, хувцас, холбоо харилцаа, унаа тээврийн нь хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй байна.

Ядуурлын эсрэг авах арга хэмжээнд нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх дараахи урт хугацааны зорилтуудыг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Малын ялангуяа ямааны тоо толгойг өсгөх:
- 170,000-аад мянган малчид байдаг бөгөөд нийт малын тоо толгой 2001 онд 24 сая гэж тоологдож байсан бол 2006 онд 34 сая болж өссөн байна. Хүн амын 45 орчим % нь мал маллаж, ДНБ-ийн 20 орчим хувийг бүрдүүлж байна. Малчдын хувьд орлого ялангуяа бэлэн мөнгө олох гол эх үүсвэр бол ноолуур байдаг. Жилд 90 сая ам. долларын түүхий/боловсруулаагүй ноолуур худалддаг ба малчин өрх орлогынхоо 50 орчим хувийг ноолуурын борлуулалтаар олж байна.
- Хүн амын шилжин суурьшил ба нүүдэл:
- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын хүн ам жил бүр 2-4 %-аар өсч байна. Монгол улсын хүн амын бараг хагас нь Улаанбаатар хотод амьдардаг. Улаанбаатар хот руу шилжин суурьшиж буй гол шалтгаан нь хүмүүс ихэвчлэн боловсролтой болох зорилгоор явж байхад зарим нэг хэсэг нь Солонгос, Япон зэрэг орнуудад эдийн засгийн боломжоо дээшлүүлэхээр явж байна.
- Байгалийн бүтээгдхүүн түүж ашиглах (мод, жимс, самар, эмийн ургамал, ан амьтан агнах)
- Эдгээр үйл ажиллагааг гол төлөв орлого олох үүднээс эрхлэх гэхдээ цөөн тооны хүмүүс эдгээр үйл ажиллагаанаас орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх болно.
- Бичил уурхай эрхлэлт:
- Бичил уурхайн үйл ажиллагаа анх 1995 оны орчим гэнэт үүсч, улмаар сүүлийн хэдхэн жилийн хугацаанд тус орны бараг бүх аймгуудын нутаг дэвсгэрт бий болсон байна. Одоогоор тус оронд 100,000 бичил уурхай эрхлэгчид байнгын ба түр хугацаагаар ажиллаж байгаа бөгөөд ийм үйл ажиллагаа эрхлэж буй хүмүүс нь ихэвчлэн малгүй эсвэл цөөн тооны мал бүхий ядуу хүмүүс ба ажилгүйчүүд байна. Хөрш орнуудын хувьд ашигт малтмалын сонирхол өндөр байгаа болохоор алтыг

албан бус зах зээлийн сувгуудаар худалдаж байна. Бичил уурхайгаар олборлосон алтны жилийн борлуулалт 100 сая ам доллар болж байна.

Иймээс бичил уурхай нь хөдөөгийн ядуурлыг бууруулах, бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх эдийн засгийн олон талт үйл ажиллагааг бий болгоход чухал үүрэгтэй гэдэг нь харагдаж байна. Ядууралтай тэмцэх, хөгжилд нөлөөлөх боломж, бичил уурхайн салбарт байгаа өнөөгийн нийгэм, байгаль орчны асуудлууд зэргэт үнэлэлт дүгнэлт өгсөний үндсэн дээр Швейцарийн хөгжлийн агентлаг ба АМГТХЭГ Бичил уурхайг дэмжих төслийн эхний ба туршилтын төслийг 2005 оны 7 сараас эхлэн 2006 оны 12 сар хүртэл хэрэгжүүлээд байна. Бичил уурхай нь нийгэм, эдийн засгийн салбарт тодорхой хувь нэмэр оруулж уул уурхайн дэд салбар болон хөгжих, хөдөөгийн ядуу иргэдэд ажлын байр, орлогын эх үүсвэр бүрдүүлж улмаар орон нутгийн эдийн засгийг дэмжин туслах боломжтой гэдгийг төслийн эхний шатны үр дүнгүүд харуулсан. 2006-6 сард төслийн туршилтын шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн баг ч үүнтэй ижил үнэлэлт дүгнэлтийг гаргасан. Иймд Швейцарийн хөгжлийн агентлаг ба төслийг хэрэгжүүлэгч Засгийн газрын байгууллага болох Үйлдвэр худалдааны яамны дэргэдэх АМГТХЭГ нь уг төслийн үйл ажиллагааг төлөвлөсний дагуу цаашид үргэлжлүүлэхээр харилцан тохиролцсон. Энэхүү хамтран хэрэгжүүлж буй төсөл бичил уурхайг уул уурхайн дэд салбар болгон хөгжүүлэх, байгалийн нөөцийн цогц менежментийн хүрээнд хөдөөгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах болно.

Швейцарийн хөгжлийн агентлаг нь сүүлийн 10 жил Өмнөд Америкийн зарим орнуудад бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих төслүүдийг хэрэгжүүлж, эдгээр орнууд болон бичил уурхайн олон улсын холбоо/байгууллага (CASM)–ын туршлагуудаас суралцах, сайн туршлагыг нэвтрүүлэх, харилцан санал бодлоо солилцоход өмнөд-өмнөдийн хөгжиж буй орнуудын хамтын ажиллагааг бий болгоход хувь нэмэр оруулж байна. Ялангуяа, **Эквадор улсын** (**PMSC)** төсөл нь бичил уурхайд байгаль орчны хамтын менежментийг бий болгож, байгаль орчинд ээлтэй олборлолтын аргуудыг нэвтрүүлсэн. **Болива улсад МЕДМИН** сангийн дэмжлэгээр хэрэгжсэн төсөл нь байгаль орчинд ээлтэй олборлолтын тоног төхөөрөмжийг орон нутагт үйлдвэрлэх, мөнгөн усыг алдахгүй барих технологийг хэрэглэж, уурхайчид ба ТББ-уудад сургалтуудыг зохион байгуулж байна. **Перу улсад хэрэгжиж буй ГАМА төсөл** төгсгөлийн шатандаа явж байгаа бөгөөд бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсоор хуульчлах туршлагыг олон улсын хэмжээнд таниулж, уул уурхайн олборлолтын удирдлагын төвлөрлийг сааруулахад дэмжлэг тусламж үзүүлж, харилцааны шинэлэг бүтцийг бий болгож, эрэлт хэрэгцээндээ үндэслэсэн цогц үйлчилгээг хүргэх, орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчдийг чадваржуулах асуудалтай уялдуулах туршлагыг бий болгосон төсөл юм.

### *1.1.4 Бодлого ба хууль эрх зүйн зохицуулалт*

Монгол улсын хөгжлийн гол бодлого нь тус улсын хөгжлийн зорилгууд (Мянганы хөгжлийн зорилгуудад үндэслэсэн бөгөөд үүн дээр засаглалын ба хүний эрхийн зорилгуудыг нэмж оруулсан), Эдийн засгийн хөгжлийг дэмжих ба ядуурлыг бууруулах стратеги, 2005-2008 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байна. Эдгээр баримт бичгүүд нь хувийн салбарыг хөгжүүлэх замаар ядуурлыг бууруулах, амьжиргааны нөхцөл байдлыг сайжруулахад чиглэнэ. Одоогоор Монгол улс нийгмийн эмзэг хэсэг, ядуу хүмүүсийг дэмжин туслах, Мянганы хөгжлийн зорилгыг биелүүлэх үүднээс энэ зорилгод үндэслэсэн Үндэсний хөгжлийн стратегийн баримт бичгээ боловсруулан гаргаж байна. Энэхүү боловсруулж буй баримт бичигт Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болох уул уурхайн салбарын хөгжлийн зарчмуудыг оруулсан байна. Хөгжлийн гол түлхүүр баганад дараахи зүйлүүдийг оруулсан байна. Үүнд:

- Макро эдийн засгийг тогтворжуулж, улсын салбарыг үр ашигтай болгох Үйлдвэрлэл ба экспортыг дэмжин, хувийн салбарыг хөгжүүлэх орчин нөхцлийг сайжруулах,

- Бүс нутгийн ба хөдөөгийн хөгжил, байгаль орчны тогтвортой хөгжил ялангуяа газрын шинэчлэлтэй холбоотой асуудлыг хурдасгах,
- Ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүний тогтвортой хөгжил, жендерийн асуудалд нэгэн адил анхаарлаа хандуулах,
- Сайн засаглалыг дэмжих, стратегийг хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийнэ.

Монголын засгийн газраас уул уурхайн салбарыг оновчтой хөгжүүлэх үүднээс Ашигт малтмалын тухай хуулиндаа нэмэлт, өөрчлөлт оруулан баталж, гэнэтийн ашгийн татварыг бий болгосон. Шинэчлэн баталсан энэ хууль нь хувийн хэвшлийн уурхайнуудын хууль эрх зүйн орчинг баталгаажуулж, харин ялангуяа төсвийн хөрөнгөөр тогтоож илрүүлсэн ордуудыг ашиглах үеийн орлогоос тодорхой хувийг төрд төлөхийг шаарддаг болсон. Энэ хууль нь олборлолт ба хайгуулийн лизенцээр газар олгох/хуваарилах ажиллагааг зохицуулах, боловсронгуй болгох зорилго тавьсаар байна. Өнгөрсөн хугацаанд лизенцийг хүсэлт гаргасан хүмүүст дараалын дагуу олгож ирсэн. Түүнчлэн олборлолт явуулж буй компаниудыг байгаль орчноо нөхөн сэргээх үүрэг хариуцлагаа хатуу чанд биелүүлдэг байх зохицуулалт хийсэн. Монгол улс нь Дэлхийн банкны дэмжлэг бүхий “Олборлох үйлдвэрүүдийн ил тод байдал” санаачлагад нэгдэн орж байна.

Бичил уурхайн эдийн засаг ба нийгмийн асуудлуудад илүү хандаж Монголын засгийн газар Швейцарийн хөгжлийн агентлагийн тусламжтайгаар тус төслийн хүрээнд боловсруулсан Бичил уурхайн тухай хуулийн төслийг дэмжин холбогдох талуудаар хэлэлцүүлэн санал дүгнэлтийг нь тусгуулсан. Энэ хуулийн төсөл нь бичил уурхайн өнөөгийн үйл ажиллагааг хуульчлан албан ёсны болгож цаашид эдийн засгийн тогтвортой дэд салбарын нэг болон хөгжүүлэхийг зорьж байна. Хуулийн төсөлд тусгагдсан өөр гол асуудал бол бичил уурхай эрхлэгчдэд ашиглалтын эрх олгох, байгаль орчноо хамгаалах үүрэг хариуцлагатай болгох, олборлосон бүтээгдэхүүнээ худалдах албан ёсны сувгуудыг бий болгох, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандартуудыг бий болгож мөрдүүлэхэд чиглэсэн.

Төсөл хэрэгжиж буй Баянхонгор аймгийн төлөөлөгчийг Латин америкийн зарим орнуудын бичил уурхай эрхлэж буй газруудад зохион байгуулсан танилцах аялалд оролцуулсны дараа тус аймгийн засаг захиргаанаас аймгийн хэмжээнд бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах түр журмыг батлан гаргасан. Энэ журам нь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах ба БУД төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн засаг захиргаа, хувийн салбар болон бусад нөөц ашиглагчдын хооронд хамтын ажиллагааны загварыг бий болгож бичил уурхайг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэж байна.

### *1.1.5 Швейцарийн хамтын ажиллагааны стратеги ба Швейцарийн хөгжлийн агентлагаас Монгол улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд*

**Зураг 1: Швейцарийн хамтын ажиллагааны стратеги ба Швейцарийн хөгжлийн агентлагаас Монгол улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд**




Швейцари улсын Монгол улстай хамтран ажиллах стратеги нь Швейцарийн хөгжлийн агентлагаас 2007-2012 онуудад тус улсад хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөрүүдийн гол чиглүүлэгч байна. Швейцарийн хөгжлийн агентлаг нь өөрийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдээ Монгол улсын хөгжлийн зорилгууд, Үндэсний хөгжлийн стратеги, Эдийн засгийн хөгжлийг дэмжих ба ядуурлыг бууруулах стратегитэй уялдуулахад нэн

тэргүүнд анхаарлаа хандуулдаг. Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй төслүүд нь хөдөөгийн малчид, өмнө малчин байсан иргэд тэдгээрийн дотор бичил уурхай эрхлэгчдэд чиглэж тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад тустай үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Швейцарийн хөгжлийн хөтөлбөр нь одоогоор Монгол орны баруун бүс нутагт голлон төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлж байгаа боловч цаашид үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үүднээс зөвхөн хүн ам, зах зээл цөөн өргөн уудам нутаг дэвсгэр бүхий ийм бүс нутагт тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн хүрээнд үйл ажиллагаагаа төвлөрүүлэхгүй байх болно. Анхаарч буй гол сэдвүүд бол хөдөөгийн хөгжлийн асуудалд байгалийн нөөцийн тогтвортой менежментийг бий болгох, тодорхой газруудын эдийн засгийн хөгжил, түүний дотор ядуу хүмүүсийг дэмжин туслах, тодорхой салбар эсвэл бүтээгдхүүнүүдийг сонгон авч тэдгээр нь тухайн орон нутгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулах, боломжууд байгааг авч үзэхэд чиглэсэн. Засаглал ба жендэрийн асуудал мөн холбогдох сэдвүүд байна. Бичил уурхай эрхлэгчдэд олборлолт явуулах албан ёсны эрхтэй болгох, нийгмийн үр дүнтэй үйлчилгээг хүргэх, газар, ус ашиглах эрх олгох зэрэг асуудлууд нь хөдөөгийн тогтвортой хөгжлийн асуудалд чухал гол асуудлууд болж байна. Швейцарийн хөгжлийн агентлаг орон нутгийн энгийн иргэдтэй хамтран ажиллаж ирсэн өөрийн туршлагаа нийгмийн хариуцлага, ядуу хүмүүсийг дэмжих санаачлага болон байгалийн нөөцийн үр ашигтай менежмент, иргэний нийгмийн оролцоог бэхжүүлэх бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай уялдуулах болно. Швейцарийн хөгжлийн ашентлаг нь хэрэгжүүлж буй өөрийн хөтөлбөрүүддээ жендерийн асуудлыг нэгэн адил хамруулж, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх болно. Түүнчлэн газар олголт ба байгалийн нөөцийн менежментэд оролцох оролцоо, нэмэлт орлого, хөдөлмөр хуваарилалтын тэгш байдал зэрэг гол асуудлуудад хандан жендерийн судалгаа явуулна. Хувь хүний болон байгууллага бүтцийн чадавхийг бий болгох, бэхжүүлэх асуудал бол чухал асуудлуудын нэг байх болно. Швейцарийн хөгжлийн агентлаг нь өөрийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээ залуу хүмүүсийг дэмжин туслах ажлыг урт хугацааны хэтийн төлөв болгон хэрэгжүүлдэг.

Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд (Бэлчээрийн экосистемийн менежмент, Бичил уурхайг дэмжих төсөл, Цөлжилт) нь үндэсний хэмжээнд малчдын оролцоотой байгалийн нөөцийн менежмент ба мониторинг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох, хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, малчдыг байгалийн гамшгийн эсрэг бэлтгэлтэй байж гарз хохирол багатай давж гарах, байгаль орчноо хамгаалан, эзэн нь байх (хүмүүнлэгийн дэмжлэг тусламж, Бэлчээрийн экосистемийн менежмент, Бичил уурхайг дэмжих, Орлогын эх үүсвэр бүрдүүлэх, Сайн чанарын үрийн төмс, Цөлжилт зэрэг төсөл хөтөлбөрүүд), төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй газруудын малчид болон малгүй болсон хүмүүсийг орлогын эх үүсвэртэй болгох үүний тулд малын үржил шимийг сайжруулж, орлого бүрдүүлэх олон талт үйл ажиллагааг (Бэлчээрийн экосистемийн менежмент, Сайн чанарын үрийн төмс, Орлого бүрдүүдэх, Бичил уурхайг дэмжих төсөл зэрэг төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан) дэмжин туслах болно. Энэ төслийг тус улсад хэрэгжүүлэхдээ Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй бусад төсөл хөтөлбөрүүд (Зураг 1)-ийн туршлага, ололттой талууд ба сургамжуудыг ашиглах болно. Төсөлтэй гол хамтран ажиллах гол төсөл хөтөлбөрүүд нь Ногоон алт, Цөлжилттэй тэмцэх төсөл ба шинээр хэрэгжүүлэх Орлого бүрдүүлэх төсөл байна.

### *1.1.6 Донор, хандивлагчдын үзүүлж буй тусламж дэмжлэгтэй уялдуулах*

Швейцарийн хөгжлийн агентлаг нь ядуурлыг бууруулах ерөнхий зорилт ба Мянганы хөгжлийн 1, 7, 9-р зорилтуудын хүрээнд донор хандивлагчидтай хамтран ажилладаг. Иймд эдгээр хөгжлийн асуудлуудад чиглэсэн донор хандивлагчдын тусламж дэмжлэгийг илүү үр ашигтай зарцуулах ашиглахад чиглэх болно. Швейцарийн хөгжлийн агентлаг нь тэгш, хариуцлагатай, эрх мэдэлтэй байх ба оролцооны зарчим зэрэг хүний эрхийн зарчмуудыг дагах болно. Швейцарийн хөгжлийн агентлаг нь ялангуяа залуу хүмүүсийг өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болох, салбарын хөгжлийн стратеги болон хөтөлбөрийн дизайн гаргах/боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож санал бодлоо хуваалцдаг болоход туслах болно. Бичил уурхай эрхлэгчдэд зарим төрлийн үйлчилгээ, тусламж дэмжлэгийг хүргэж буй төсөл хөтөлбөрүүд Монгол улсад

донор хандивлагчдын тусламжтайгаар хэрэгжиж байгаа ч Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй энэ төсөл шиг бичил уурхай эрхлэгчдэд тусламж дэмжлэгийг цогц байдлаар хүргэж буй нэг ч төсөл хөтөлбөрүүд одоогоор байхгүй байна. Бичил уурхайг дэмжих төсөл нь хэрэгжилтийн үндсэн шатандаа донор хандивлагчдын үйл ажиллагааг энэ салбар руу чиглүүлж оруулахад гол үүрэгтэй оролцож, тусламж дэмжлэгийн тодорхой механизм бий болгох ажлаа үргэлжлүүлэх болно. Одоогоор бичил уурхай болон том уурхайн үйл ажиллагаанд дараахи олон улсын байгууллагууд шууд ба шууд бусаар оролцож байна. Үүнд: **Олон улсын хөдөлмөрийн байгууллага** (хүүхдийн хөдөлмөр), **Дэлхийн банк** (Монгол улсын уул уурхайн салбарын тайлан, бичил уурхайг дэмжих олон улсын байгууллага /CASM/), **НҮБ-ийн хүн амын сан** (Бичил уурхай эрхлэгчдийн нийгэм эдийн засгийн эмзэг асуудлуудыг бууруулах), **ХБНГУ-ын Гео-шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн** (Уул уурхай дахь байгаль орчны хамгаалал төсөл), Нээлттэй нийгэмлэг (Ашигт малтмалын тухай хууль ба бодлого), **Азийн сан** (Нөөцийн хариуцлагатай менежментийг дэмжих), Монгол дахь Адвентист хөгжил туслалцааны агентлаг (Хөдөөгийн бизнесийг дэмжих сургалт), **Канад улсын Халифаксийн Ст. Мэригийн их сургууль** ба **СИДА** (Байгаль орчны боловсрол: Монгол дахь уул уурхай), **Герман улсын Касселийн их сургууль** (Усны нөөцийн цогц менежмент) зэрэг байгууллага байна (Холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 9.4-аас харна уу).

Швейцарийн хөгжлийн агентлаг бичил уурхайн үйл ажиллагааг дэмжин туслах чиглэлээр өмнөд америкийн орнуудад 3 төслийг Дэлхийн байгаль орчны сангийн төслийн багцийнхаа хүрээнд хэрэгжүүлж чухал туршлагыг бий болгосон. Эхний төслийг Эквадор улсад PMSC төслийг хэрэгжүүлж бичил уурхайн хүрээнд байгаль орчны хамтын менежментийн асуудлаар тодорхой туршлагыг бий болгон байгаль орчинд ээлтэй олборлолтын аргыг нэвтрүүлсэн. Болива улсад МЭДМИН сангийн шугамаар хэрэгжүүлсэн төслийн хүрээнд байгаль орчинд хор нөлөөгүй тоног төхөөрөмж үйлдвэрлэж мөнгөн усыг ил задгай орчинд халааж хэрэглэж байсан технологийг өөрчлөн байгаль орчинд хор нөлөөгүй технологийг нэвтрүүлэх талаар нэлээд сайн туршлагыг бий болгож, бичил уурхай эрхлэгчид ба олон нийтийн байгууллагуудын дунд сурталчилан зааж сургасан. Перу улсад хэрэгжүүлж буй ГАМА төсөл нь (одоогоор хэрэгжилтийнхээ төгсгөлийн шатандаа орсон) бичил уурхайн үйл ажиллагааг хууль эрх зүйн зохицуулалтанд оруулж, уул уурхайн удирдлага менежментийн төвлөрлийг сааруулж харилцааны шинэлэг бүтцийг бий болгож, орон нутгийн үйлчилгээ хүргэгчдийг үүсч буй хэрэгцээ шаардлагадаа үндэслэн цогц үйлчилгээг хүргэж чаддаг болоход нь тусламж дэмжлэг үзүүлэн туршлага бий болгосон.

### *1.1.7 Төслийн эхний ба туршилтын шатны үйл ажиллагааны хэрэгжилт*

*1.1.7.1 Зорилго ба зорилтууд:*

Төслийн эхний шатанд хөгжлийн гол зорилгыг дараахи байдлаар тодорхойлсон.

*“Бичил уурхайг дэмжих” төсөл нь бичил уурхайн салбарын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг явуулах таатай нөхцлийг бүрдүүлэн тухайн сонгосон газруудын байгалийн нөөцийн зохистой ашиглалтанд үндэслэн нийгэм эдийн засгийн хөгжилд нь хувь нэмэр оруулах болно.*

Энэхүү хөгжлийн зорилгодоо хүрэхийн тулд дараахи 4 зорилтуудыг тавьсан. Үүнд:

**Зорилт 1:** Бичил уурхайн албан бус үйл ажиллагааг албан/ хууль ёсны болгох таатай орчин бүрдүүлэх, бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааны баталгааг сайжруулах, хамтрагч оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгох талаар холбогдох талуудтай хамтран ажиллан бичил уурхайн үйл ажиллагаанд ил тод, шудрага **хууль эрх зүйн орчинг** бүрдүүлэхэд туслах;

**Зорилго 2**: Бичил уурхайн салбар ба холбогдох салбаруудын хүрээнд **бүтэц зохион байгуулалтыг бий болгох**, бүхий л түвшинд хамтын ажиллагааг хөгжүүлэх;

**<u>Зорилго 3</u>**: Бичил уурхайн олборлолтын үйл ажиллагааг сайжруулан аюулгүй ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлж бичил уурхай эрхлэгчид ба бусад холбогдох талуудын мэдлэг, ур чадвар, техник технологийг сайжруулах;

**<u>Зорилт 4:</u>** Дэлхийн байгаль орчны хөтөлбөрийн шаардлага, урт хугацааны хэтийн төлөвд нийцүүлэн байгалийн нөөцийн өнөөгийн ашиглалтын суурь мэдлэгийг бий болгон тэдгээрийг байгалийн нөөцийн менежмент ба хөдөөгийн хөгжлийн асуудлуудтай цогц авч үзэж хэрэглэх;

### *1.1.7.2 <u>Гарсан үр дүнгүүд</u>*

Бичил уурхайг дэмжих төслийн эхний ба туршилтын шатны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ (2006-6-7 саруудад) төслийн эхний шат амжилттай хэрэгжиж байна гэсэн дүгнэлтийг гаргасан. Төслийн ажилтнууд, төслийг хэрэгжүүлэгч Швейцарийн хөгжлийн агентлаг, АМГТХЭГ ба Проект консалт компанийн холбогдох ажилтнууд төслийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ (SWOT) хийж үйл ажиллагааны асуудал (туршилтын жижиг төслүүд, хууль эрх зүй, бүтэц зохион байгуулалтын асуудлуудыг оруулан), удирдлага зохион байгуулалт (ажилтнууд, дүрэм журам, ажлын харилцаа холбоо, зохицуулалт гм)-ын асуудлуудад өөрсдийн үнэлгээгээ өгсөн. Эдгээр үнэлгээний үр дүнгүүдийг төслийн үйл ажиллагаанд хийсэн гадаад үнэлгээний багийнханд танилцуулсан. Төслийн үйл ажиллагаанд үнэлгээг бичил уурхайн салбарын мэргэжилтэн (Колумба дахь Хариуцлагатай уул уурхайн ассоцаци) ба байгалийн нөөцийн менежментийн мэргэжилтэн (Берний их сургуулийн хөгжил судлалын төв)-ний бүрэлдхүүнтэй баг хийж төслийн үйл ажиллагааны эхлэл, туршилтын шатанд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийж, төслийн цаашдын шатуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, үндсэн чиглэлийг ерөнхийд нь тодорхойлж өгсөн.

Төслийн эхний шатны үйл ажиллагааг төслийн гол хамтрагч талууд тухайлбал АМГТХЭГ, Уул уурхайн аврах алба, Баянхонгор аймгийн засаг захиргаа, бичил уурхай эрхлэгчидтэй хамтран амжилттай сайн эхлүүлж чадсан. Энэ шатанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хүрсэн амжилтын талаар товч дурьдвал:

- Төслийн бүтцийг бий болгож, төслийн хамтрагч талууд, хэрэгжүүлэгч талууд (АМГТХЭГ, Швейцарийн хөгжлийн агентлаг)-ын идэвхитэй оролцоотой төслийн нэгжийн багийг бүрдүүлэн үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлж чадсан.
- Монгол улсад бичил уурхайн үйл ажиллагааг хууль эрх зүйн зохицуулалтанд оруулахад туслах ажил амжилттай хэрэгжиж нэлээд оновчтой уян хатан заалт бүхий хуулийн төслийг боловсруулж гаргахад тусалсан.
- Үндэсний, аймаг, сум/ дүүргийн хэмжээнд төр, засгийн байгууллагууд, судалгаа шинжилгээний байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хувийн салбар болон бусад төсөл хөтөлбөр, хандивлагч байгууллагуудын хооронд харилцаа холбоо тогтоон ажиллаж, 2006 оны 5 сард үндэсний зөвлөлгөөн зохион байгуулж бүхий л түвшний төлөөллийг оролцуулсан.
- Нэлээд нарийвчилсан судалгааг явуулсны үндсэн дээр төсөл Баянхонгор аймаг ба тус аймгийн Бөмбөгөр, Шинэжинст сумдыг сонгон төслийн гол туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна.
- Төсөл Уул уурхайн аврах албатай хамтран ажиллаж, явуулын ба хөдөлгөөнт аврах албыг байгуулан ажиллуулж, бичил уурхай эрхлэгчдэд газар дээр нь аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, сургалтуудыг зохион байгуулж байна. Тус аврах албаны мэдээлж байгаагаар бичил уурхай эрхлэгчдийн дунд гардаг аваар ослын тоо буурч байна. Түүнчлэн явуулын ба хөдөлгөөнт аврах алба нь бичил уурхай эрхлэгчид ба БУД төслийн хооронд харилцан итгэлцэлийг бий болгож, нээлттэй харилцах боломж бүрдүүлж өгч байна. Энэ нь төслийн зүгээс цаашид

хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гарах үр дүнгүүдэд сайнаар нөлөөлөх нөхцлийг бүрдүүлж өгч байна.

- Сургалтын хэрэгцээнд үнэлгээ өгч, шаардлагатай сургалтуудыг зохион байгуулах нөхцөл ба хэрэгжүүлэх стратегуудыг тогтоож өгсөн.
- Техникийн ба техникийн бус судалгаануудыг явуулсан. Тухайлбал хуурай баяжуулагчийг сайжруулах, бичил уурхай эрхлэгчдэд банкны үйлчилгээг ойртуулах, тэд нараас албан ёсоор алт худалдаж авдаг болох боломж нөхцлийг судалж, бичил уурхай эрхлэгчдийн зарим хэсэг нь зохион байгуулалтанд орж үйл ажиллагаагаа хамтран явуулдаг сайн туршлагыг судлан дэлгэрүүлэх боломжийг судалсан.
- Төслийн туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр сонгосон газруудад явуулсан судалгаа (төслийн баримт бичгийн Бүрэлдэхүүн хэсэг 4) нь тухайн газруудын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын талаар илүү сайн ойлголтыг өгч, төслийн үндсэн шатны үйл ажиллагааны төлөвлөлтийг хийхэд чухал ач холбогдолтой байлаа.
- Төслөөс тус улсын бичил уурхай эрхлэгчдийн талаар 3 хэсэг бүхий баримтат кино хийлгэсэн нь бичил уурхай эрхлэгчдийн өнөөгийн байдлын талаар бодитой ойлголт өгөх боломж бүрдүүллээ.

**<u>Төслөөс хэрэгжүүлсэн эдгээр үйл ажиллагааны нөлөө ба үр дүнгүүд:</u>**

- Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд төслөөс үзүүлсэн нөлөө өндөр байна. Тухайлбал Бичил уурхайн тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барихад чухал үүрэгтэй оролцсон. Хууль санаачлагчид, холбогдох яамдуудын төлөөллийг оролцуулсан уулзалт ярилцлагуудыг зохион байгуулж хуулийн төслийг танилцуулсан. Гэхдээ Монгол улсад хөдөөгийн иргэд байгалийн нөөцийг ашиглахдаа ямар ч лизенци зөвшөөрөл авах шаардлагагүй мэт ойлгогдож байна.
- Бүтэц зохион байгуулалтын хувьд: төсөл нэлээд чухал алхмуудыг хийж, тодорхой нөлөөг үзүүлж чадсан. АМГТХЭГ нь тус улсын бичил уурхай эрхлэлтийг зохион байгуулалтай болгох ажлын эхлэлийг тавихад идэвхитэй оролцож Бичил уурхайн тасаг/нэгжийг шинээр байгуулж төсөлтэй хамтран ажиллуулж байгаа нь тус салбарын хувьд чухал хамтрагч талуудыг бий болгож байна.

### *1.1.7.3 <u>Үйл ажиллагааны сургамжууд</u>*

<u>Анхаарах асуудууд/сургамжууд</u>

Төсөл нь бичил уурхайн асуудлыг нэлээд өргөн хүрээтэй авч үзэн, тодорхой бүтцийг бий болгож, эхний шатны үйл ажиллагаануудыг амжилттай хэрэгжүүлж чадсан ч дараахи асуудлуудад анхаарлаа хандуулж, нэг ёсны сургамжууд гэж үзэн төслийн үндсэн шатанд анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

- Бичил уурхай эрхлэгчидтэй шууд холбоотой, тэдэнд тустай үйл ажиллагаа (техник технологийг сайжруулах, нийгэм асуудлууд, зохион байгуулалтын асуудал гм) маш бага хийгдсэн. Уул уурхайн салбарын удирдлага, засаг захиргаа хөдөө орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж харилцан үйл ажиллагаагаа уялдуулахгүй байгааг анхаарч ажиллах хэрэгтэй.
- УУАА-ны хөдөлгөөнт аврах алба, сургалт үйлчилгээ нь Монголчуудын нүүдлийн амьдралд илүү нийцсэн гэдгийг анхааран цаашид бичил уурхай эрхлэгчдийн дунд техникийн ба техникийн бус асуудлаар нэлээд өргөтгөсөн үйлчилгээ сургалтыг явуулдаг байх хэрэгтэй.
- Хамтын ажиллагааг нэлээд өргөн хүрээтэй явуулах шаардлагатай. Энэ нь БУД (магадгүй цаашдаа АМГТХЭГ дэргэдэх Бичил уурхайн тасаг) төслийг зохицуулагч чиглүүлэгчийн үүрэгтэй гол бүлэг/core group/ болгож болох юм. Ялангуяа техникийн бус асуудал тухайлбал бичил уурхайн асуудлыг хөдөөгийн хөгжлийн асуудалтай уялдуулж, хүний хөгжлийн асуудлаар бусад холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх шаардлагатай.

- Монгол улсын бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааг сайжруулах, ямар нэг зөрчилдөөнгүйгээр ашигт малтмалаа олборлодог болох өөрчлөлтүүдийг хийх нь төслөөс газар дээр нь ямар үр дүнтэй ажлууд хэрэгжүүлэхээс ихээхэн хамаарна. Эхний удаад бол төслийн үйл ажиллагааны талаар өргөн мэдээлэл хийж, ололтой тал туршлага, гаргасан шийдвэрүүдээ даруй дэлгэрүүлэх ажлуудыг зохион байгуулах нь зүйтэй.
- Төслөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа ба үзүүлэх нөлөөнд хэрхэн мониторинг ба үнэлгээ хийх аргуудыг тогтоох ба энэхүү мониторинг ба үнэлгээний тогтолцоо нь оролцооны аргад үндэслэгдсэн байх ёстой гэдгийг анхаарах хэрэгтэй. Үнэлгээ мониторингийн аргуудыг тогтоохдоо төслийн эхний шатанд хийгдсэн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үнэлгээний үр дүнгүүдэд үндэслэх хэрэгтэй.
- Одоогоор АМГТХЭГ болон төслийн баг нь техникийн асуудалд илүү анхаарч байна. Иймээс төсөл нь цаашид техникийн бус, нийгмийн асуудлаар холбогдох байгууллагууд, төсөл, хөтөлбөр, санаачлагуудтай хамтран ажиллаж эрүүл мэнд, нийгэм, бүтэц зохион байгуулалт, менежмент зэрэг техникийн бус асуудлаар чадавхийг бий болгож ажиллахад анхаарах хэрэгтэй.
- Төсөл нь одоогоор зөвхөн тус улсын уул уурхайн салбар, хөдөөгийн хөгжил, хөдөөгийн байгалийн нөөцийн менежментийн хүрээнд чиглэж байна. Иймд цаашид зөвхөн эдгээр хүрээнд бус харин Монгол орны тогтвортой хөгжил ба улс орны ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг уялдуулах, тодорхой хувь нэмэр оруулахад чиглэх хэрэгтэй.

### *1.1.7.4 <u>Төслийн үндсэн шатны үйл ажиллагаа ба үнэлгээний ажлуудын үр дүнгүүд</u>*

Монгол улсад төсөл хэрэгжүүлэх боломж, нөхцөл байдалд хийсэн ерөнхий үнэлгээ, дүн шинжилгээний үр дүнгүүд нь төслийн эхний ба туршилтын шатны үйл ажиллагаа болон төслийн үйл ажиллагаанд хийсэн гадны үнэлгээний үнэлэлт дүгнэлтээр үндсэндээ баталгагдаад байна. Тухайлбал төслийн сонгож авсан байгалийн баялгийн цогц менежмент, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх газрын газар зүйн байрлал, хөндөж буй асуудлууд болон төсөл хэрэгжүүлэгчээр Засгийн газрын байгууллагыг сонгосон зэрэг нь зөв зүйтэй байсан гэдэгт үнэлэлт дүгнэлт хийсэн. Төслийн эхний/туршилтын шатны үйл ажиллагааны төлөвлөлтөнд тусгагдсан арга хэмжээ нь төслийн хамтрагч талууд, оролцогчдын хувьд тустай, шинэлэг санаануудыг өгч улмаар Монгол улсын бичил уурхай эрхлэгчид тэдгээрийн амьжиргаанд хувь нэмэр оруулах нөхцлийг бүрдүүлж өгсөн.

Баянхонгор аймагт явуулсан нийгэм эдийн засгийн суурь судалгаанд “тус аймагт бичил уурхай эрхлэгчид сард дундажаар 250-300 швейцар франкийн орлого олдог нь тухайн аймгийн хувьд бичил уурхай нь тогтвортой бас энгийн амарханаар орлого олж болох нэг боломж гэж үзсэн байна. Улирлаар ажилладаг хүмүүсийн хувьд өрх гэр бүлийнхээ нийт хэрэглээний 20-40 %-ийг бичил уурхайн үйл ажиллагаанаас олсон орлогоор бүрдүүлдэг байна. Эдгээр хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх, үр ашигтай байх боломжийг нэмэгдүүлэхийн тулд юуны өмнө илүү сайн, аюулгүй техник технологийг нэвтрүүлж, тэнд ажиллаж буй хүмүүсийг үйлдвэрлэл эрхлэх чадвартай болгох хэрэгтэй. Үүний тулд мөнгөний менежмент, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлуудаар сургалтууд зохион байгуулж, нийгмийн асуудлуудад нь анхаарлаа хандуулах шаардлагатай. Байгаль орчны суурь судалгаанд бичил уурхайн үйл ажиллагааг юуны өмнө байгаль орчны бохирдол ялангуяа мөнгөн ус, цианидын хэрэглээ, хөрс усны бохирдол, ургамал, бут сөөг устаж үгүй болж байгаатай холбож үзсэн байна. Иймээс мөнгөн усгүй үр ашигтай технологи хэрэглэж, ахуйн түлшний өөр эх үүсвэрүүдийг бий болгоход анхаарах нь төслийн үндсэн шатанд байгаль орчны асуудалд хандах гол үйл ажиллагааны нэг хэсэг байна.

# 2 Үндэслэл

Энэхүү төсөл Монгол улсын хөгжлийн тодорхой нэг асуудалд чиглэж байгаа билээ. Жилд 100 сая ам долларын орлого бүхий бичил уурхайн салбар нь тус орны хөдөөгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх дэд салбар юм. Иймд бичил уурхай эрхлэгчдэд хууль эрх

зүйн орчинг бий болгож өгснөөр бичил уурхай нь хөдөөгийн хөгжилд гол хөдөлгөгч хүч болж бичил уурхай эрхлэгчдийн аюулгүй байдлыг хангаж, ажиллах нөхцлийг сайжруулж тэдний хүртэх ашиг тус нь нэмэгдэх болно. Энэ утгаараа төсөл нь Монгол улсын хөгжлийн нэг гол түлхүүр асуудалд хандаж байгаа билээ. Төсөл хэрэгжилтийнхээ эхний шатанд Бичил уурхайн тухай хуулийн төслийг санаачлах, төслийг олон нийтэд өргөнөөр танилцуулах, УИХ-д өргөн барихад идэвхитэй оролцсон. АМГТХЭГ нь тус улсын бичил уурхай эрхлэлтийг зохион байгуулахад идэвхитэй оролцож Бичил уурхайн тасаг/нэгжийг шинээр байгуулж ажиллуулж байна. Төсөл нь энэ салбарыг хөгжүүлэхэд олон талуудтай харилцаа холбоо тогтоон хамтын ажиллагааг бий болгож, төслийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх газруудыг тогтоож тэдгээр газруудын экологи, эдийн засаг, нийгмийн суурь судалгааны үзүүлэлт /индикатор/-үүдийг тогтоож үнэлгээ хийлгэсэн. Түүнчлэн Өмнөд америкт Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй төслүүдийн туршлагаас суралцан өөрийн орны бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах дүрэм журмын төслүүдийг боловсруулж, төслийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр сонгосон Баянхонгор аймагт турших эхлээд байна.

**Зураг 2: Бичил уурхайг дэмжих төсөл ба түүний Дэлхийн байгаль орчны асуудлуудад эзлэх байр суурь**

Бичил уурхайг дэмжих төслийн үндсэн шатны үйл ажиллагаа нь SCS 07-12 ба Мянганы хөгжлийн зорилт 1, 7-г хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэнэ. Бичил уурхайн салбарт орж өөрийн тусламж дэмжлэгээ хүргэж хамтран ажиллах нь Швейцарийн хөгжлийн агентлагийн хувьд энэ төслийг хамтран хэрэгжүүлэгч ялангуяа АМГТХЭГ-ыг ялангуяа түүний салбар нэгжийг чадавхитай болоход нь хувь нэмэр оруулах болно. Энэ салбарт бүхий л шатанд бүтэц зохион байгуулалтыг бий болгож, чадавхитай болгох, сургаж бэлтгэх, шинэ мэдлэг, технологийг нэвтрүүлэх харилцан солилцох боломж олгох нь Швейцарийн хөгжлийн агентлагийн 2010 он хүртэл баримтлах гол стратегийн нэг хэсэг байх болно (Швейцарийн хөгжлийн агентлаг 2000 он).

Швецарийн хамтын ажиллагааны стратегид байгалийн баялагийн тогтвортой ашиглалтанд нэлээд тодорхой хандаж зааж өгсөн нь БУД төслийн үйл ажиллагаа энэ стратегид хамгийн сайн нийцэж буй төслийн нэг юм (Зураг 2:). Түүнчлэн Швейцарийн хөгжлийн агентлаг нь Өмнөд америкийн зарим орнуудад бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих  төслүүдийг хэрэгжүүлж туршлагатай болсон. Швейцарийн хөгжлийн агентлагийн Монгол дахь салбар нь Өмнөд америкийн орнуудад бичил уурхайг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдийн туршлагыг Монгол улсад дэлгэрүүлэх зорилгоор холбогдох мэргэжилтнүүдийг илгээж туршлага судлуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн үндсэн шатанд төсөл хэрэгжүүлэх талаар нэлээд туршлагатай болсон Проект консалт компанийг төсөлд зөвлөх үүрэгтэй оролцуулахаар харилцан тохиролцоод байна.



## 2.1 Хөтөлбөрийн тодорхойлолт

## 2.2 Хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд үзүүлэх тусламж дэмжлэг

Төслийн үйл ажиллагааны дунд үед хийсэн үнэлгээний дүгнэлтээс харахад Монгол улс өөрийн орны тогтортой хөгжлийг хангах ба улс орны ядуурлыг бууруулахад уул уурхайн салбар ямар үүрэгтэй байх вэ гэдгийг тогтоосон зүйл байхгүй байна гэж үзсэн байна. Түүнчлэн АМГТХЭГ-ын уул уурхайн хэлтсийн дарга “АМГТХЭГ-т цаашид бичил уурхайн талаар баримтлах бодлого боловсруулахад туслах”-ыг хүссэн. Иймд цаашид Монгол улсад бичил уурхайг чухал үүрэг бүхий уул уурхайн дэд салбар болгон хөгжүүлэхийн тулд тус орны уул уурхайн салбарын бодлогыг бүхэлд авч үзэх хэрэгтэй. Хэдийгээр Бичил уурхайн тухай хууль ойрын үед батлагдах төлөвтэй байгаа ч орон нутаг ба үндэсний хэмжээнд бичил уурхайн дэд салбарт нийцсэн дүрэм, журмыг боловсруулж, **хэрэгжүүлэх удирдамжийг** тогтоож өгөх талаар нэлээд ажил хийх шаардлагатай байна. Бичил уурхайн талаар баримтлах төрийн бодлого, дүрэм журам зохицуулалтыг юуны өмнө хариуцлагатай уул уурхайн асуудлуудтай холбож үзэх тухайлбал, нийгмийн, засаглал ба орон нутгийн хөгжлийн асуудлууд, хөдөлмөр ба хүний эрх, байгаль орчин, техник технологи үйлдвэрлэл, санхүү зах зээл/маркетингийн асуудлуудтай холбож уялдуулж өгөх нь зүйтэй.

Төсөл бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсны болгоход үндэсний, бүс нутгийн, орон нутгийн болон өрх гэр бүлийн хэмжээнд хамтран ажиллах болно. **Бүтэц зохион байгуулалтыг бий болгож, бэхжүүлэх ажлыг** “дээрээс мөн доороос” гэсэн зарчмаар хэрэгжүүлэх болно. Тухайлбал, Засгийн газрын түвшинд АМГТХЭГ бичил уурхайн асуудлаар үндэсний ба орон нутгийн хэмжээнд ажиллах бүрэн нөөц чадвартай болсон байна. Нөгөө талаас бичил уурхай эрхлэгчид нь зохион байгуулалтанд орж, өөрсдийн хүсэл зорилгоо илэрхийлж, тулгарч буй асуудлаа шийдвэрлэхэд тустай сургалтанд хамрагдаж, тусламж дэмжлэгийг авдаг болно. Оролцогч харилцлагч талууд бүгдээрээ хамтдаа “хариуцлагатай” уул уурхайг бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч хүн бүрт тухайлбал эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэдгээрийн гэр бүлийн амьдарлыг сайжруулахад хийгдэж буй бүхий л үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлох болно. Оролцогч хүн бүр жишээ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс нөөц ашиглахдаа тэгш эрхтэй байх, ашиг орлогоо тэгш шудрага хуваадаг байх, шийдвэр гаргахад ижил тэгш оролцдог байх ёстой.

Бичил уурхай эрхлэгч олон хүмүүс бичил уурхай эрхлэлт нь амьжиргааны асуудал гэж үзэж байгаа болохоор төсөл эдгээр хүмүүст тулгарч буй хүндрэлтэй асуудлууд юу болох, ер нь **ядуурлыг бууруулах, орлого бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах** цаашилбал хүний тогтвортой хөгжлийг дэмжихэд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Иймээс төсөл тухайн орон нутгийн хувьд илүү ач холбогдолтой байж болох салбар ба бүтээгдхүүнийг сонгох болно. Сүүлийн хэдэн жилд ашигт малтмалын илрүүлсэн нөөцийг даган газар авч буй  бичил уурхай эрхлэлтийг  тухайн орон нутгийн эдийн засгийн хөгжил ба нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд тус болохуйцаар зохион байгуулах  арга хэмжээнд гол анхаарлаа хандуулах болно.  Бичил уурхай эрхлэгчдийн эрх чөлөө, тэгш байдал, аюулгүй байдал, хүний нэр хүндийн асуудлыг дээдлэн тэдний амьдралын стандартыг дээшлүүлэхэд чиглэх хэрэгтэй.  Иймээс төсөл нь бичил уурхай эрхлэгчдийн **нийгмийн асуудлуудад** анхаарч, орон нутгийн нөхцөл байдлыг судлан, бичил уурхай эрхлэгчдийг өөрсдийн хэрэгцээ шаардлагаа зөв тогтоож, тэдгээрт нийцсэн арга хэмжээ авч чаддаг болоход анхаарах болно.

Хариуцлагатай уурхай нь бичил уурхай ба албан ёсны уурхай хоёрын хооронд олон талын уялдаа, холбоо байгаа гэдгийг авч үзэх хэрэгтэй. Тухайлбал зарим газруудад албан ёсны уурхай нь өөрийн лизенцитэй талбайн эдийн засгийн ач холбогдол багатай гэсэн хэсэгт бичил уурхай эрхлэгчид олборлолт хийх “эрх” олгож  байхад зарим уурхай өөрийн технологийн хаягдал  дээр ажиллах боломж олгодог.  Харин зарим газруудад албан ба албан бус уурхайн олборлогчид нөөцийн ашиглалтаас болж зөрчил мөргөлдөөнд ордог. Зарим компаниуд орон нутгийн хөгжлийг дэмжих санаачлагуудыг тавьж эхлээд байна. (Жишээлбэл, Бороо гоулд, Айванхо майнз компаниуд). Хэдийгээр

эдгээр үйл ажиллагаа санаачлагуудыг талархан хүлээж авч байгаа ч тус орны иргэний зарим байгууллагууд нөөц баялгийн хуваарилалт зөвхөн орон нутгийн засаг захиргаагаар дамжин шийдвэрлэгдэж байгаа тул нутгийн иргэдэд хүртэх ашиг тус байхгүй байна гэж үзэж байна. Иймээс төсөл албан бус олборлолт явуулж буй бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг албан уурхайтай холбож, тэдний хоорондын **зөрчлийг бууруулах, сайн ойлголцол бий болгож,** оролцогч харилцагч талуудын хооронд байгаа нөхцөл байдал, боломжийн талаар мэдээлэл хийж, бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааны эмзэг асуудлыг гарган тавихад туслах болно. Бичил уурхай эрхлэгчид нь тухайн олборлолт явуулж буй газрынхаа **байгаль орчны асуудлаар хариуцлага хүлээдэг,** экологийн нөхөн сэргээлтэнд анхаарлаа хандуулдаг байх ёстой. Хортой бодис ашиглах, хаягдалаа гол ус руу хаях, биологийн төрөл зүйлд сөрөг нөлөө үзүүлэх асуудлыг бууруулж улмаар зогсоох хэрэгтэй.

### *2.3 Төслийн зорилго ба зорилтууд*

Тогтвортой бичил уурхай төсөл нь хөдөөгийн малчид ба малгүй болсон иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, байгалийн нөөцийн нөхөн сэргээлт ба тогтвортой ашиглалт, экологийн чиг баримжаатай нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэсэн учраас Швейцарийн хамтын ажиллагааны 2007-2012 оны стратегийн зорилтод нийцсэн төсөл юм. Төсөл нь улс орны хэмжээнд [1] байгалийн нөөцийн менежмент ба мониторинг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг сайжруулах, [2] байгаль орчны хувьд хариуцлага хүлээдэг байх, [3] орлого нэмэгдүүлэх, орлого бүрдүүлэх олон эх үүсвэрийг бий болгоход хувь нэмэр оруулах болно. Швейцарийн хамтын ажиллагааны стратеги нь Мянганы хөгжлийн зорилтууд болон Монголын засгийн газрын бодлогын гол баримт бичгүүдтэй бүрэн нийцсэн. БУД төслийн хөгжлийн зорилгыг төсөл хэрэгжүүлж эхлэхээс өмнө зохион байгуулсан оролцооны сургалт семинар дээр боловсруулж төслийн хэрэгжилтийн явцад бага зэрэг өөрчлөлт оруулсан.

***Тогтвортой бичил уурхай төсөл нь Монгол улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж бичил уурхай эрхлэгчдийг хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болоход хувь нэмэр оруулах болно.***

Тогтвортой бичил уурхай төсөл нь энэхүү ерөнхий зорилгоо хангахын тулд дараахи 4 зорилтыг тавьж байна. Үүнд:

1. **Бичил уурхайн салбарт ил тод, шудрага бодлого, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах боловсронгуй болгох;**
2. **Бичил уурхайн салбарын бүтэц, зохион байгуулалтыг бүх түвшинд бий болгох бэхжүүлэх;**
3. **Бичил уурхай эрхлэгчдийг үр ашигтай, хариуцлагатай олборлолт болон ядуурлыг бууруулахад чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх чадвартай болгох;**
4. **Бичил уурхай эрхлэгчид ба бусад нөөц ашиглагчдыг байгаль орчин экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж гарч буй зөрчлүүдээ шийдэж чаддаг чадвартай болгоно.**

Төслийн эхний шат хэрэгжиж дуусах 2010 он гэхэд бичил уурхайн дэд салбар нь бүхий л түвшинд өөрийн бүтэц зохион байгуулалтыг бий болгож, хууль эрх зүй, дүрэм журмаар зохицуулагддаг болсон байна. Бичил уурхай эрхлэгчдийн ихэнхи нь албан ёсны зохион байгуулалтанд орж хариуцлагатай уурхайн дүрэм журам зохицуулалтыг дагаж мөрддөг болсон байна. Наад зах нь бичил уурхай эрхлэгчдийн 10 % хамтран ажиллаж жижиг үйлдвэрлэл эрхэлдэг болж тэдний орлого дээшилж, орлого олох бусад бизнес эрхэлдэг болсон байна. Уул уурхайн том компаниуд ба бичил уурхай эрхлэгчдийн хооронд байгалийн нөөц ашиглалттай холбоотой гардаг зөрчлүүдийг бууруулах, арилгах механизмуудыг бий болгож мөрддөг/хэрэглэдэг болсон байна. Бичил уурхайн дэд салбар ба түүнтэй холбогдох бусад гол салбарууд тухайлбал уул уурхай, байгалийн нөөц, хувийн салбарыг Зураг 3—т харуулсан. Баянхонгор аймагт хийсэн байгаль орчны үнэлгээний баг (Адъяасүрэн, үнэлгээний баг Эко-сфера, 2006)- ийн тодорхойлсноор бичил уурхай нь уул уурхайн дэд салбар байж байгалийн нөөц ашиглалтаараа том уурхайгаас ялгаатай, бие даасан байдаг. Тухайлбал: бичил уурхай эрхлэгчид нь байгаль дээр байгаа байгалийн баялаг (бут сөөг, аргал)-ийг маш их хэмжээгээр түлшинд хэрэглэж байгааг нутгийн малчид (харьцангуй бага хэмжээгээр хэрэглэдэг), орон нутагт олборлолт явуулж буй албан ёсны том компаниуд (дизель хөдөлгүүр эсвэл нүүрс хэрэглэдэг)-тай харьцуулж үзэхэд байгаль орчныг илүү ихээр сүйтгэж байна.

**Зураг 3: Бичил уурхайн дэд салбар ба түүнтэй холбогдох бусад гол салбарууд**




Дээр дурьдсан зорилтуудыг төслийн эхний шатны хэрэгжилтийн явцад бичил уурхай эрхлэгчид, албан ёсны уул уурхайн компаниуд, иргэний хөдөлгөөн, орон нутгийн ба олон улсын ТББ-ууд, Швейцарийн хөгжлийн агентлаг ба бусад донор хандивлагчдын төлөөлөлөгчид, холбогдох яамдууд, АМГТХЭГ-ын төлөөлөгчид зэрэг төслийн хамтрагч оролцогч талуудтай харилцан ярилцаж, зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлсон. Швейцарийн хөгжлийн агентлаг нь төслийн эхний бэлтгэл шатны үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт дүгнэлтэнд анхаарлаа хандуулсан (Ичиварриа, Клай 2006). Хөгжлийн асуудлыг жендер ба газар зүйн байрлалын хувьд тэнцвэртэй авч үзэх асуудал төслийн баримт бичгийн боловсруулалтын явцад нэлээд нухацтай авч үзсэн. Түүнчлэн Швейцарийн хөгжлийн агентлаг төслийн үндсэн шатны үйл ажиллагааг төлөвлөхдөө холбогдох талуудын дунд хийсэн сургалт семинарын үр дүнгүүд ба төлөвлөлтийн баримт бичгийн төслийг төслийн вэб хуудаснаа тавьж холбогдох талуудын санал, зөвөлгөөг авч төслийн төлөвлөлтөнд тусгасан.

## *2.4 Үйл ажиллагааны стратегийн зарчмууд*

Төслийн үндсэн стратеги бол бичил уурхай эрхлэгчид ба түүнтэй холбогдох талууд, байгууллагуудыг бэхжүүлэх, чадваржуулахад чиглэх болно. Үүний тулд бичил уурхайн асуудлаар холбогдох үндэсний ба олон улсын байгууллагуудын дунд харилцаа холбоо тогтоож харилцан ярилцлага зохион байгуулахад төсөл гол зохицуулах үүрэг гүйцэтгэнэ. Экологи, аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, хүүхдийн хөдөлмөр, зөрчлийг бууруулах ба шийдэх зэрэг гол асуудлуудад хандан “хариуцлагатай бичил уурхай”-н тодорхойлолтыг холбогдох талуудтай хамтран гаргах болно. Сургалт нь төслийн хувьд гол стратегийн асуудал байх болно. Сургалтыг бичил уурхай эрхлэгчдийн гэр бүл, уул уурхайн аврах алба, нийгмийн/иргэдийн хөдөлгөөнөөс эхлээд үндэсний ба бүс нутгийн түвшинд холбогдох төрийн байгууллагын ажилтнуудад явуулах болно. Сургалтууд нь

хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах тодорхой зорилт бүхий практик үйл ажиллагаанд чиглэх болно.

Олборлолтын эрх олгох, үр ашигтай төрийн үйлчилгээ, газар ба ус ашиглах эрхүүд зэрэг **засаглалын** асуудлууд нь үндсэн гол асуудлууд байна. Төсөл нь орон нутагт үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирсэн өөрийн туршлагаа **нийгмийн хариуцлагыг** дээшлүүлэх, орлого олох, орлогын олон талт эх үүсвэрүүдийг бий болгох, байгалийн нөөц ашиглалтын үр ашигтай менежментийг хэрэгжүүлэх **чадавхийг бий болгоход** хувь нэмэр оруулах санаачлага үйл ажиллагааг дэмжих бодлоготой уялдуулж холбох болно. Энэ хөтөлбөр нь дэд салбарын хүрээнд жендерийн асуудлыг авч үзэн, жендер, эрх, олон талын харилцаа холбоонд дүн шинжилгээ хийх болно.

Төсөл нь хариуцлагатай уул уурхайн талаар бусад холбогдох донор, хандивлагчид ба хувийн компаниудтай хамтын ажиллагаа бий болгоно. Уул уурхай, бичил уурхайн дэд салбарын түвшинд **зохицуулан уялдуулах** нь харилцагч хамтрагч талуудын нөөц бололцоог илүү үр дүнтэй ашиглахад хүргэнэ. Төсөл нь **тэгш эрх ба шудрага ёс**, хариуцлагатай байдал, эрх мэдэлтэй байх, оролцоотой байх гэсэн **хүний эрхийн асуудалд үндэслэсэн аргачлалыг** дагах болно.  АМГТХЭГ ба Швейцарийн хөгжлийн агентлагаас томилогдсон хүмүүс төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлэх болно.  Тус нэгж нь хөтөлбөрийн өдөр тутмын менежментийг хариуцах бөгөөд үндэсний хамтрагч, оролцогч талуудын чадавхийг нэмэгдүүлэх үүднээс үндэсний ба олон улсын холбогдох мэргэжлийн байгууллагууд, зөвлөхүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллах, сургагч нарыг сургах сургалт явуулах болно. Төслийн нэгжийг Швейцарийн хөгжлийн агентлаг ба АМГТХЭГ-аас хамтран томилсон төслийн Зохицуулагч удирдах болно.  Төсөл нь үндсэндээ 4 гол бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд бүрэлдэхүүн хэсэг бүр тус бүрээс гарах үр дүнгүүдтэй.  Бүрэлдхүүн хэсэг бүр тус бүрдээ багийн удирдагчтай байна.  Төслийн зохицуулагч нь төслийн 4 бүрэлдэхүүн хэсгийн аль нэг хэсгийг хариуцан ажиллах болно.  Түүнчлэн төслийн зохицуулагч нь “Төслийн гүйцэтгэлийг дүгнэх” хүснэгт (Хавсралт 10.1)-д тусгасан менежментийн үр дүнг хангаж ажиллах хариуцлага хүлээнэ.  Төслийн зохицуулагч нь ажлын явц (Үйл ажиллагааны хороо)-ыг тайлагнах, жилийн ажлын төлөвлөгөөг батлуулахдаа АМГТХЭГ ба Швейцарийн хөгжлийн агентлагт хандах ба Үйлдвэр худалдааны яамаар ахлуулсан Удирдах зөвлөлд тайлагнадаг байна. Энэхүү энгийн бөгөөд тодорхой бүтэцтэйгээр төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд баг бүрдүүлэн, менежментийг явуулж харилцаа холбоог улам бүр сайжруулах болно.

АМГТХЭГ-ын одоогийн мөрдөж буй санхүүгийн дүрэм журмаар энэ шатанд санхүүжилтийг нийлүүлэх боломжгүй. Иймээс төслийн зардалд тусд нь хяналт шалгалт явуулж байх болно. Гэхдээ төслийн хэрэгжилтийг илүү үр дүнтэй болгох шинэлэг алхмуудыг Швейцарийн хөгжлийн агентлаг, АМГТХЭГ-ын хооронд зөвшилцөж шийдвэрлэдэг байна.

Байгууллагын **чадавхийг хөгжүүлэх** асуудлыг төсөл хэрэгжиж дууссаны дараа бичил уурхайн салбарын асуудалд оролцож хамтран ажиллах талууд буюу төрийн ба төрийн бус, иргэний нийгэм, холбоо, бусад холбогдох байгууллагуудад чиглүүлэх болно. Швейцарийн хөгжлийн агентлагаас томилогдсон төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд төслийг дууссан үед гэрээгээ дуусгах бөгөөд харин АМГТХЭГ-аас томилогдон ажиллаж буй хүмүүс цаашид бичил уурхайн  асуудлыг үргэлжлүүлэн хариуцаж ажиллана.

Үндэсний болон олон улсын хамтрагч, харилцагч талуудын хооронд уялдаа холбоо, зохицуулалт хийх, **зохицуулан уялдуулах** нь хэрэгжилтийн стратегийн нэгэн хэсэг байх болно.

### 2.5 Гарах үр дүнгүүд ба хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги

#### 2.5.1 Бүрэлдэхүүн хэсэг 1: Бодлого, эрх зүйн зохицуулалтын орчинг сайжруулах

**Гарах үр дүн 1:** Бичил уурхайн салбарт ил тод, шударга бодлого, эрх зүйн зохицуулалтын орчинг бүрдүүлж хэрэгжилтийг эхлүүлсэн байна.

*Зорилт 1: Гарах үр дүнгүүд ба гол индикаторууд*

| **Зорилт 1: Гарах үр дүнгүүд** (хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд) | | **Нотлох гол индикаторууд** |
|---|---|---|
| 1.1 | Бичил уурхайн салбарын цогц бодлого ба үйл ажиллагаанд нь сайн зохицож, нийцсэн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх | Бичил уурхайн тухай хуулийг батлуулсан байна.<br>Харилцагч, хамтрагч талуудын оролцоог бий болгосон байна.<br>Бичил уурхайн тухай эрх зүйн зохицуулалтын орчин нь бусад холбогдох хуулиудтай уялдаж нийцсэн байна. |
| 1.2 | Үндэсний ба орон нутгийн хэмжээнд ил тод, шударга, орон нутгийн хэмжээнд зохицуулалт хийж болох (лизенцийн асуудлыг оролцуулан) бичил уурхайн эрх зүйн орчин (газар эзэмшил, байгаль орчны үнэлгээ, хортой бодисын хэрэглээ, хөдөлмөр хамгаалал гм)-г бий болгох | Орон нутгийн хэмжээнд эрх зүйн зохицуулалтыг оролцооны арга ба босоо зарчимтай уялдуулан боловсруулж батлуулдаг болсон байна.<br>Сонгосон газруудад хууль эрх зүйн зохицуулалтыг турших, дүн шинжилгээ (зардлууд, зөвшилцөл гм асуудлуудад) хийсэн байна. |
| 1.3 | Үндэсний болон олон улсын хэмжээнд бичил уурхайн талаар үнэн зөв найдвартай мэдээ мэдээлэл цуглуулах, боловсруулах, тэргүүн туршлага, сургамжаас суралцах, дэлгэрүүлэх | Холбогдох тайлангууд, газрын зургууд, нөөц ашиглалтын төлөвлөгөөнүүд хийгдэж, мэдээ мэдээллийг цуглуулж баримтжуулан, хэвлэн нийтэлж, холбогдох сургалт семинаруудыг зохион байгуулж, бичил уурхай эрхэлж буй газруудад очиж ажилласан байна.<br>Олон нийт ашиглаж болохуйц бичил уурхайн мэдээллийн санг бий болгож байгалийн нөөцийн цогц менежментийг бий болгосон байна.<br>Бичил уурхайн гол/түлхүүр хэмжээс параметрүүд бүхий мониторингийн тайлангууд гарсан байна. |

*Төслийн үндсэн үйл ажиллагаанууд, оруулах хувь нэмэр, гол харилцагч хамтрагч талууд*

| **Үр дүн** | **Үйл ажиллагаа** | **Гол харилцагч, хамтрагч талууд** | **Төслөөс оруулах хувь нэмэр** |
|---|---|---|---|
| 1.1 | Бичил уурхайн салбарт хууль эрх зүйн орчин бүрдүүлэхэд холбогдох бүх талуудын оролцоог бий болгох<br>Шийдвэр гаргагчдыг бичил | Улсын их хурал<br>Орон нутгийн засаг захиргаа<br>Бичил уурхай | Холбогдох уулзалт ярилцлагуудыг зохион байгуулах<br><br>Олон улсын |

| | | | |
|---|---|---|---|
| | уурхайтай холбоотой мэдээлэл, олон улсын ололт амжилт, туршлагатай танилцуулж, холбогдох мэдээллээр хангах | эрхлэгчид<br>Уул уурхайн ассоициаци | туршлага, жишээнүүд |
| 1.2 | Бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, дүрэм журмыг боловсруулан гаргахад бүхий л түвшинд дэмжлэг туслалцаа үзүүлэх<br>Олборлолт явуулж буй газруудад холбогдох дүрэм журмыг танилцуулах дэлгэрүүлэх, турших ажлуудад туслах | Орон нутгийн засаг захиргаа<br>Бичил уурхай эрхлэгчид<br>Иргэний хөдөлгөөнүүд | Оролцооны уулзалт ярилцлагуудыг зохион байгуулахад туслах<br>Олон улсын туршлагууд<br>Туршилт хийхэд туслах |
| 1.3 | Бичил уурхайн асуудлаар үндэсний болон олон улсын туршлагаас суралцаж мэдлэгийн менежмент ба суралцах боломжийг бий болгох<br>Мэдлэгээ хуваалцах, харилцан ярилцах, хэлэлцэх уулзалтуудыг зохион байгуулах, гарсан зөвлөмж, баримт мэдээллүүдийг холбогдох талуудад тараах<br>Бичил уурхайн дэд салбарын тухай олон нийтийн мэдээлэл сурталчилгааг бий болгох | Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй холбогдох талууд | Суралцах ба мэдлэгээ хуваалцах уулзалт ярилцлага бусад үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэх<br>Хандивлагчид ба бусад хамтрагч оролцогч талуудын хооронд хамтын ажиллагаа бий болгоход тусламж дэмжлэг үзүүлэх Хэвлэл нийтлэл, радио, телевизийн хөтөлбөрүүд хийхэд туслах, — Интернетэд вэб хуудсаа байрлуулах, мэдээллийн сантай болсон байна. |

*2.5.1.1 Үйл ажиллагааны стратеги - хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх*

Бичил уурхайн дэд салбарыг уул уурхайн салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулж бичил уурхайн хэтийн төлвийг бүрэн тусгаж чадсан хууль эрх зүйн зохицуулалтын орчин бүрдүүлж чадвал бичил уурхайн үйл ажиллагааг мэргэжлийн ба эдийн засгийн хувьд үр дүнд хүргэнэ. Ийм орчинд бичил уурхай эрхлэгчид ба тэдгээрийн гэр бүл, жижиг үйлдвэр болон нийт ард иргэд ашиг хүртэж чадна. Лизенци, зөвшөөрөл олгох явдлыг ил тод болгох, бичил уурхай эрхлэгчдийг албан ёсны бүртгэлтэй болгох тухай орон нутгийн санал, шийдвэрүүд нь уул уурхайн үйл ажиллагааны хууль эрх зүйн орчин бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ. Иргэд албан ёсны бүртгэлтэй болсноор саналаа өгөх, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжтой болохоос гадна өөрийгөө хүндэтгэх, өөртөө итгэх итгэлтэй болгоно.
Зорилт 1-д хүрэхийн тулд төсөл нь холбогдох хуулиудын хүрээнд Хүний эрх, жендерийн тэгш байх зарчмуудыг үндэслэн бичил уурхайн эрх зүй зохицуулалтын таатай орчин бүрдүүлэхэд хамтрагч, харилцагч бүх талуудтай хамтран ажиллах болно. Төслийн туршилтын ба эхний шатны үед боловсруулсан хуулийн төсөл батлагдах магадлалтай ч үндэсний ба орон нутгийн хэмжээнд хариуцлагатай бичил уурхайн дүрэм журам, удирдамжуудыг боловсруулан гаргах хэрэгцээ байсаар байна. Ийм эрх зүйн зохицуулалтын орчин бий болгож, мөрдөж хэрэгжүүлснээр бичил уурхайгаас

хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах нөхцөл бүрдүүлж өгнө. Эрх зүйн зохицуулалтын ийм орчинд хариуцлагатай бичил уурхайг байгалийн нөөц ашиглагчид ялангуяа малчдын үйл ажиллагаатай харилцан уялдаатай зохицуулж хөгжүүлж чадна. Төсөл нь хууль эрх зүйн орчин (хууль, дүрэм журам, тэргүүн туршлага, удирдамж)-ы гол/түлхүүр ойлголтууд/элементүүдийг боловсруулахад туслах болно. Эдгээр нь хэрэгжилтийн шатандаа ч ил тод байж, гол оролцогч талууд нь жендерийн болон бусад асуудлаар орон нутгийн бүр анхан шатны түвшинд ч хариуцлага хүлээсэн гэдгийг харуулах болно. Энэ зорилтыг хэрэгжүүлснээр гарах үр дүн нь юуны өмнө АМГТХЭГ-ын дэргэд шинээр байгуулсан Бичил уурхайн нэгжийг бэхжүүлэх, чадваржуулах, бичил уурхайн хууль эрх зүйн орчин бий болгоход тэргүүлэх үүрэгтэй оролцдог байгууллага болгоход чиглэнэ. Бүх оролцогч талууд нь хууль эрх зүйн зохицуулалтыг дагаж биелүүлдэг болгох чиглэлийг баримтлана.

Төсөл нь эхнээсээ бичил уурхай эрхлэлтийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол, хүндрэлтэй асуудлууд болон байгаа боломжуудын талаар ард нийт, төр засгийн байгууллагуудын дунд илүү сайн ойлголтыг өгөхөд гол үүрэгтэй оролцох болно. Бичил уурхай эрхлэгчдийг төлөөлсөн шүхэр байгууллага бий болсноор энэ үүргийг цаашид үргэлжлүүлэх болно. Иймээс бичил уурхайтай холбоотой мэдлэг, мэдээллийг цуглуулах, боловсруулах, мэдээллийн суурь бий болгох нь хамгийн чухал юм. Үүний зэрэгцээ бичил уурхай эрхлэгчдийн дунд мэдээллээ хуваалцах, харилцан суралцах ажлыг зохион байгуулна. Цаашид төсөл хөдөөгийн тогтвортой хөгжилд бичил уурхайн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэл, сурталчилгааг бий болгоход ажлаа чиглүүлнэ. Эдгээр мэдээллийн сүлжээ нь холбогдох талуудын хооронд бичил уурхайн талаар илүү сайн ойлголт бий болгож, харилцаа холбоог сайжруулж, гарч буй зөрчил тэмцлийг бууруулахад туслана.

### *2.5.1.2 <u>Гарч болох эрсдэлүүд ба таамаглалууд</u>*

Бичил уурхайг дэмжих төсөл хэрэгжиж эхэлснээс хойш бичил уурхайтай холбогдох мэдээлэл, сурталчилгааг илүү сайн хийж байна. Улс төрийн болон уул уурхайн салбарын талаар үүсэж буй нөхцөл байдалтай холбоотойгоор Бичил уурхайн тухай хууль батлуулах явц хойшлогдож, удааширч болох эрсдэл байна. Хэдийгээр хууль батлуулах нь чухал боловч энэ нь цаашид эрх зүйн зохицуулалтын орчны эцсийн хязгаар болохгүй. Аюулгүй ажиллагааны стандартууд, химийн хорт бодисыг зөв зохистой ашиглах, хог хаягдлыг бууруулах заавар, зөвлөмж зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, амьдрал практикт хэрэглэдэг байх нь зүйтэй. Мөнгөн усыг хэрэглэх нь хууль бус үйл ажиллагаа гэж төр засгийн зарим ажилтнууд үздэг болохоор мөнгөн усны хэрэглээг зохицуулах тухай ярилцлага хийх нь төдийлөн амжилттай болохгүй учраас үүнтэй адил алтны үндсэн орд дээр ажилладаг бичил уурхай эрхлэгчидтэй алтыг хортой бодисоор бариулах талаар ярилцах боломжгүй. Гэхдээ практик дээр бол байгаль орчны байцаагчид энэ асуудлаар ярилцлага хийх хэрэгтэй гэж үздэг бол бичил уурхай эрхлэгчид өөрсдөө техник технологио сайжруулж, аюулгүй ажиллагааны стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөхөд бэлэн байгаагаа илэрхийлдэг.

Бүх оролцогч талууд бичил уурхайн эрх зүйн зохицуулалтын орчин бүрдүүлэхэд оролцож, тэргүүн туршлага, амжилт амжилтуудаа харилцан хуваалцана гэж тооцоолж байгаа ч уул уурхайн салбар ба иргэний хөдөлгөөнүүдийн хооронд асар их ялгаа зөрүүтэй ойлголтууд байгаа нь зөрчил тэмцэл гарсаар байж болох бас нэг эрсдэл байна. Гэхдээ төсөл Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, Дэлхийн банк зэрэг бусад байгууллагуудтай хамтран үндэсний зөвлөлгөөнийг зохион байгуулсан нь уул уурхайтай холбоотой асуудлаар холбогдох талуудын дунд үр дүнтэй харилцан ярилцлага, хэлэлцүүлэг явуулж санал солилцох сайхан боломж олголоо.

Төсөл нь туршилтын шатанд бичил уурхайтай холбоотой асуудлаар шийдвэр гаргагчидтай уулзалт ярилцлагуудыг зохион байгуулж санал бодлоо солилцсон. Төсөл АМГТХЭГ-тай хамгийн ойр дөт хамтран ажиллаж байгаа нь Монгол улс дахь Швейцарийн хөгжлийн агентлагийн нэр хүндийг өргөх, төслийн үйл ажиллагааг илүү үр

дүнтэй болгох,  бичил уурхайн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх  үндэс суурийг тавьж байна.

### 2.5.2 Бүрэлдэхүүн хэсэг 2: Бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох бэхжүүлэх

**Гарах үр дүн 2: Бүхий л түвшинд бичил уурхайн салбарын бүтцийг бий болгож, зохион байгуулалтыг боловсронгуй болгож бэхжүүлсэн байна.**

*Зорилт 2: Гарах үр дүнгүүд ба гол индикаторууд*

| **Зорилт 2: Гарах үр дүнгүүд** (хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд) | | **Нотлох гол индикаторууд** |
|---|---|---|
| 2.1 | Үндэсний ба орон нутгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчдэд түшиг тулгуур болох үр ашигтай бүтэц, зохион байгуулалтыг бий болгож бэхжүүлэх | Бичил уурхай эрхлэгчдийн дунд бүтэц, зохион байгуулалтыг бий болгож албан ёсны болгосон байна.<br>Гол оролцогч талууд ба төр, засгийн байгууллагуудтай хамтран асуудлыг хэлэлцэх, зөвшилцөхөд бичил уурхайн бүтцийн төлөөлөл албан ёсны нэг тал болж оролцдог болсон байна. |
| 2.2 | Бичил уурхай эрхлэгчдэд үйлчилгээ хүргэгчид ба гол оролцогч байгууллагуудын чадавхийг бэхжүүлж үр ашигтай ажиллагаар хэрэгжүүлэх | Бичил уурхайн асуудлаар холбогдох байгууллагууд (АМГТХЭГ, УУАА, БУД төсөл гм)-ын үйл ажиллагаар үр дүнд хүргэхийн тулд тэдгээрийн ажилтнуудын нөөц бололцооны ашиглалт, чадвар дадлагыг дээшлүүлсэн байна.<br>Явуулын ба хөдөлгөөнт үйлчилгээний нэгжүүд/гэрүүдийг байгуулсан байна<br>Холбогдох талууд зохицуулалтын дүрэм, журмуудыг дагаж биелүүлдэг болсон байна . |
| 2.3 | Монгол улсын бичил уурхай эрхлэгчдийн үндэсний зөвлөл ба сүлжээг бий болгож улмаар олон улсын сүлжээ, мэргэжлийн төвүүдтэй холбоо харилцаа тогтоох | Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний сүлжээ (БУЭҮС)-г албан ёсоор бий болгосон байна.<br>Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэгийн ээлжит хуралдааныг Монгол улсад зохион байгуулах<br>Өмнөд-өмнөдийн хөгжиж буй орнуудын хамтын ажиллагаар бий болгож харилцан туршлага солилцох |

*Төслийн үндсэн үйл ажиллагаа, оруулах хувь нэмэр, гол харилцагч хамтрагч талууд*

| **Үр дүн** | **Үйл ажиллагаа** | **Гол харилцагч, хамтрагч талууд** | **Төслөөс оруулах хувь нэмэр** |
|---|---|---|---|
| 2.1 | Орон нутгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчид, малчид болон бусад сонирхогч талуудын хооронд мэдээлэл солилцох зорилгоор оролцогч талуудын уулзалт ярилцлагуудыг зохион байгуулах<br>Бичил уурхай эрхлэгчдийг төлөөлсөн үндэсний байгууллагын эрхэм зорилгыг тодорхойлох, гол баримт бичгийг боловсруулах, | Нутгийн иргэд<br>Бичил уурхай эрхлэгчид<br>Иргэний хөдөлгөөн<br>Оролцогч хамтрагч талуудаас байгуулсан ажлын | Холбогдох уулзалтуудыг зохион байгуулах<br>Сургагч, зохион байгуулагчдыг сургаж бэлтгэх<br>Олон улсын ба үндэсний |

| | | | |
|---|---|---|---|
| | бүтэц, дотоод дүрэм журам (Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний зөвлөл)-ыг гаргахад туслах<br>Удирдан чиглүүлэх, зөвшилцлийг бий болгох чадварыг нэмэгдүүлэх сургалтуудыг зохион байгуулах | хэсэг<br><br>БУЭҮС-ний удирдагчид | мэргэжлийн хүмүүс ба хуулийн зөвлөгөө<br><br>Сургалтууд |
| 2.2 | Үйлчилгээний ба сургалтын төвүүд, явуулын ба хөдөлгөөнт алба (УУАА)-ыг байгуулахад тусламж дэмжлэг үзүүлэх<br>Удирдлага, менежментийн чадварыг дээшлүүлсэн сургалтуудыг зохион байгуулах | Нутгийн иргэд<br>Уул уурхайн аврах алба<br><br>АМГТХЭГ ба төслийн ажилтнууд | Шинэ техник технологийг нэвтрүүлэх<br>Сургалт дэд бүтцийг дэмжих туслах<br>Удирдлага менежментийн сургалтууд хийх |
| 2.3 | Өмнөд-өмнөдийн хөгжиж буй орнуудын олон улсын мэргэжлийн төвүүдтэй холбоо харилцаа тогтоон харилцан туршлага солилцох<br>Улс орны хэмжээнд мэдээлэл сурталчилгааг бий болгох | БУЭҮС<br>Иргэний хөдөлгөөн АМГТХЭГ | Бичил уурхайн сүлжээг бий болгоход дэмжлэг туслалцаа үзүүлэх<br><br>Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэгийн ээлжит хуралдааныг УБ-т зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх |

*2.5.2.1 <u>Үйл ажиллагааны стратеги</u>*

Зорилт 2–г хангахын тулд төсөл нь бичил уурхай эрхлэгчдийн дунд анхан шатны хүчтэй хөдөлгөөн санаачлагуудыг бий болгоход чиглэн ажиллана. Эхлээд орон нутгийн иргэд өөрсдөө зохион байгуулалтанд орох түүний дараагаар бүс нутгийн хэмжээнд бүтэц зохион байгуулалтыг бий болгож, улмаар Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний зөвлөлд нэгдэх хэрэгтэй. Олон улсын туршлагаас харахад экологийн хувьд нийцсэн хор нөлөөгүй байгалийн нөөцийн ашиглалтыг гэр бүлийн хэмжээнд хэрэгжүүлж чадахгүй харин ашиглагч хэрэглэгчдийн бүлэг эвслээр дамжуулан хэрэгжүүлж болно. Одоогоор бичил уурхай эрхлэгчид нь өрх гэр бүлээрээ хэд хэдэн хэсэгт ч хуваагдаж болох хэсэг бүлгүүдээс бүрдэж байна. Бүлэг бүр албан бусаар сонгогдсон удирдагч толгойлогчтой. Эдгээр удирдаж толгойлж буй хүмүүс нь ихэвчлэн бусдаасаа илүү туршлагатай бөгөөд бүлгийн гишүүдийн итгэлийг хүлээсэн хүмүүс байдаг. Иймээс бичил уурхай эрхлэгчдийн энэ албан бус бүтэц зохион байгуулалтыг албан ёсны болгох, тэдний гол төлөөллийг сургах, бусад гишүүдээ төлөөлөн тэдэнд байгаа нөөц, эрхийнхээ төлөө өөрсдийн санал бодлоо илэрхийлдэг болоход нь туслах хэрэгтэй. Цаашид төсөл нь бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах үүднээс бүс нутаг ба үндэсний хэмжээнд иргэний нийгмийн байгууллагуудыг байгуулж ажиллуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх болно. Хөтөлбөр нь харилцагч хамтрагч талууд ялангуяа АМГТХЭГ ба түүний дэргэд байгуулсан Бичил уурхайн нэгж, орон нутгийн төлөөлөгчийн газруудад чиглэн чадавхийг бий болгож, бэхжүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх болно.

Нөөц ашиглагчдыг зөв зохион байгуулан шаардлагатай сургалтуудад хамруулан, тэдэнд нийцсэн тохирсон техникийн ба санхүүгийн арга хэрэгслээр дамжуулан нөөц ашиглагчдын бүлэг/хэсгүүдийг татан оролцуулах, өөрсдийн хийж буй зүйлээсээ суралцах боломж нөөц нэлээд байна гэдгийг Швейцарийн хөгжлийн агентлаг ба

хэрэгжиж буй бусад хөтөлбөрүүдийн туршлага харуулж байна. Байгалийн нөөцийн менежментийг явуулах тогтолцооны чадавхи сул байгаа бэрхшээлийг даван туулахын тулд эдгээр бүлэг хэсгүүдэд хариуцлага хүлээлгэх, зохицуулах, сургалтууд явуулах, сайтар тооцоолж үзсэний үндсэн дээр тэдгээрийн үйл ажиллагааг хамтран санхүүжүүлэх зэргийг шаарддаг. Эдгээр тусламж дэмжлэгийг зохицуулан хүргэх нь орон нутгийн ба үндэсний хэмжээний засаг төрийн байгууллагуудын үүрэг байх болно. Төсөл нь зөвхөн тусламж дэмжлэгийг үзүүлэх гэсэн зорилттойгоор тодорхой хугацаанд хэрэгжих учраас төр засгийн зохицуулах үүрэг хариуцлагыг өөртөө хүлээхгүй.

Менежментийн хувьд байгууллагын дотоод зохицуулалт, хамтын ажиллагаанд үндэслэгдэх бөгөөд бичил уурхай эрхлэгчдийн ашигт малтмалын нөөц ашиглалтын макро эдийн засгийн ашиг тусыг сайжруулах олон нийтийн-хувийн санаачлагыг дэмжих болно.

*2.5.2.2 <u>Гарч болох эрсдлүүд ба таамаглалууд</u>*

Чадавхийг бий болгож, хөгжүүлэх гэсэн асуудал бол бичил уурхайн дэд салбар төдийгүй АМГТХЭГ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн хувьд бичил уурхайн тогтвортой бүтэц бий болгоход туслах гол асуудал байна. Чадавхийг бий болгох үйл ажиллагааны бодит үр дүнгүүд төлөвлөсөн хугацаанд харагдахгүй байж болно. Ер нь төслүүд нь чадавхи бий болгоход гарах эрсдлийг бууруулахдаа нэг бол тухайн шаардлагатай чадавхийг үндэсний ба олон улсын зах зээлээс түр хугацаагаар олж авдаг эсвэл төсөл хэрэгжих хугацаанд гарах үр дүнг өөрчлөн чадавхийг бий болгоход шаардагдах нэмэлт хугацааг тогтоох гэсэн 2 арга замын аль нэгийг сонгодог. Иймээс төсөл хэрэгжүүлэх нэгж нь эрсдлийг бууруулах стратеги, ерөнхий хөтөлбөрийн хэмжээнд ямар үр дүн, нөлөөтэй байх вэ гэдгийг нэлээд нухацтай авч үзэх хэрэгтэй. Төсөл нь нэг талаас Швейцарийн хөгжлийн агентлагаар дамжуулан тодорхой ажлын байруудад төслийн ажилтнуудыг сонгон авч нөгөө талаас өмнө төрийн ажилтан байгаад АМГТХЭГ-ийн зарим ажилтнуудыг Бичил уурхайн тасагт томилон ажиллуулж төслийн хамт олныг бүрдүүлж байгааг авч үзэх хэрэгтэй. Эдгээр ажилтнуудын чадавхи, санал бодол, ажиллах нэмэлт цаг хугацааны хувьд харилцан адилгүй байгааг анхааран тэдний чадавхийг бий болгох асуудлыг нухацтай авч үзэх хэрэгтэй. Түүнчлэн орон нутагт бичил уурхай эрхлэгчдийн дундаас жинхэнэ төлөөллийн байгууллагыг байгуулахад магадгүй төлөвлөж байснаас илүү хугацаа шаардаж болох юм. Учир нь тухайн төлөөлөгчид нь бичил уурхайчдыг бус харин өөрсдийн аймаг, бүс нутгаа төлөөлж байгуулагдаж байна.

Гаргасан дүрэм журмыг дагаж мөрдөхгүй, орон нутгийн засаг захиргааны зүгээс дүрэм журмыг сахиулах, хэрэгжүүлэх хүч нөөц дутмаг байж болох эрсдэлтэй. Энэ эрсдлийг бууруулахын тулд бичил уурхай эрхлэгчид ба олборлолт явуулдаг газруудын төлөөллийг тухайн дүрэм журмыг боловсруулахад оруулах мэдээлэл сурталчилгаа, танилцуулгыг өргөнөөр хийх сургалт явуулах, мэдээллийг нээлттэй хүртээмжтэй байлгах арга хэмжээ авах нь зүйтэй.

Одоогийн байдлаар төр засгийн байгууллагууд АМГТХЭГ дээр бичил уурхайн асуудал эрхэлсэн тусгай нэгж байгуулж ажиллахыг бүрэн дэмжиж цаашид ч дэмжиж хамтарч ажиллах болно гэсэн таамаглал хийж байна. Ийм ч үүднээс төслийн туршилтын шатанд тус агентлаг дээр Бичил уурхайн тасгийг шинээр байгуулан хамтран ажиллаж эхлээд байгаа билээ.

### 2.5.3 Бүрэлдэхүүн хэсэг 3: Орон нутгийн эдийн засгийн хөгжлийг сайжруулах ба хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх

**Гарах үр дүн 3: Бичил уурхай эрхлэгчдийг үр, ашигтай хариуцлагатай бичил уурхай болон бусад бизнесийн үйл ажиллагаа эрхлэх чадвартай болоход нь туслах**

*Зорилт 3: Гарах үр дүнгүүд ба гол индикаторууд*

| **Зорилт 3: Гарах үр дүнгүүд** (хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд) | | **Нотлох гол индикаторууд** |
|---|---|---|
| 3.1 | Ил, далд бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулж бичил уурхай эрхлэгчид дагаж мөрддөг болоход туслах (уурхайн аюулгүй ажиллагаа, гэрэлтүүлэлт, агааржуулалт, тоосжилтыг бууруулах гм) | Монгол улсад мөрддөг заавачлагуудыг олон улсын сайн туршлага, технологид ойртуулж нийцүүлэх<br>Аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу ажилладаг бичил уурхайчдын тоог гаргасан байх,<br>Шинээр гаргасан аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдсөнөөр гарч буй ослын тоо буурсан байх. |
| 3.2 | Алт ялгах технологи ба тоног төхөөрөмжийн хийц, ашиглалтыг сайжруулж, нэвтрүүлсэн байх | Мөнгөн усны хэрэглээ эрс буурах<br>Алт ялгалт сайжирсан байх. |
| 3.3 | Боломжийн орлого олох орлогын эх үүсвэрүүдийг тогтоож, зарим бизнесийн үйл ажиллагааг эхлүүлсэн байх | Бизнес эрхлэж эхэлснээс хойш нэг жилийн дараа уг бизнесийн үйл ажиллагаа үргэлжилж байх<br>Төслийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн орлого дээшилсэн байх. |
| 3.4 | Иргэдийн санхүү, бизнес, менежмент, маркетингийн чадварыг дээшлүүлсэн байх | Хүмүүсийн орлого, зарлагын байдлыг баримтжуулсан байх<br>Бизнес төлөвлөгөөнүүдээ боловсруулдаг болсон байх<br>Зах зээл/маркетингийн стратегийг сайжруулж нэмэлт орлого олдог болсон байна. |

*Төслийн үндсэн үйл ажиллагаанууд, төслөөс оруулах хувь нэмэр, харилцагч хамтрагч талууд*

| **Үр дүн** | **Үйл ажиллагаа** | **Гол харилцагч, хамтрагч талууд** | **Төслөөс оруулах хувь нэмэр** |
|---|---|---|---|
| 3.1 | Аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулах<br>Аюулгүй ажиллагааны сургалт явуулах<br>Шинэ техник технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэх ажиллагааг дэмжих Support the | Бичил уурхай эрхлэгчид<br>Уул уурхайн аврах алба | Ноу-хау нэвтрүүлэх<br>Сургалтууд ба аюулгүй ажиллагааны курсууд |
| 3.2 | Шинэ техник технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэх ажлыг | Бичил уурхай эрхлэгчид | Ноу-хау нэвтрүүлэх<br>Сургалтууд |

| | | | |
|---|---|---|---|
| | зохицуулах<br>Технологийн сонголтуудад үнэлгээ өгч, тэдгээрийг зөв хэрэглэх талаар сургалтууд явуулах, батлагдсан технологийг дэлгэрүүлэх арга хэмжээ авах | | Судалгаа явуулах, мэдлэгээ хуваалцах багаж тоног төхөөрөмжийг дотооддоо, орон нутагт үйлдвэрлэх эхлэл бий болгох, |
| 3.3 | Орон нутгийн хэмжээнд орлого бүрдүүлэлт ба олон талт орлогын эх үүсвэрүүдэд үнэлгээ өгөх,<br>Бизнес хөгжүүлэх, эхлэл гараа, технологи, үзэсгэлэн худалдааны стандартууд зэрэг асуудлаар сургалтууд явуулах<br>Эхлэл гарааны хөрөнгөөр туслах | Бичил уурхай эрхлэгчид<br>Үйлдвэрлэл эрхлэгчид ба саначлагатай хүмүүс | Үнэлгээний судалгаа<br>Сургалтууд<br>Багаж тоног төхөөрөмж |
| 3.4 | Санхүү ба бизнесийн менежментийн сургалтууд<br>Зах зээлийн үнэлгээ ба маркетинг сургалтууд ба зохицуулалт<br>Алт худалдаж авах механизмыг албан ёсны болгох | Бичил уурхай эрхлэгчид ба малчид<br>Бичил уурхай эрхлэгчид ба үйлдвэрлэгчид<br>Арилжааны банкууд ба бичил уурхай эрхлэгчид | Сургалтууд<br>Сургалтууд, зах зээлийн дүн шинжилгээ,<br>Мэргэжлийн туслалцаа |

*2.5.3.1 <u>Үйл ажиллагааны стратеги</u>*

Зорилт 3-г хэрэгжүүлэхэд бүс нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд шинэ мэдлэг, ноу хоу, технологийг дэмжих болно. Үүнд байгаль орчинд ээлтэй, зардал хэмнэлттэй, үр ашигтай, аюулгүй технологийг бичил уурхайн хүрээнд турших, улам боловсронгуй болгох, дэлгэрүүлэх үйл ажиллагаа орно. Технологийг шинээр нэвтрүүлэх нь аюулгүй ажиллагааны дүрэм журам болон технологийн хамгийн зөв зохистой ашиглалтыг хангахад нийцсэн байх ёстой.

Түүнчлэн төслийн стратеги бол бичил уурхай эрхлэгчдийг тогтвортой үйлдвэрлэгч (ЖДҮ-чид) болоход дэмжин тусалж, улмаар албан ёсны ажлын байр бий болгож, ажил хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн (алт угаах үйлчилгээ, адал явдалт аялал жуулчлал, уул уурхайн тоног төхөөрөмж ба эсвэл үнэт эдлэлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл гм)-ний нэр төрлийг олон янз бий болгоход чиглэнэ. Уул уурхайн дэд салбар болох бичил уурхайн төрөл бүрийн ЖДҮ-чдийг бий болгох нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд шууд бусаар хувь нэмэр оруулах болно. Орлогыг бий болгох, нэр төрлийг олон болгох асуудлыг дараахи стратегиар зохицуулах хэрэгтэй. Үүнд:

- Хувийн салбарын хувьд ажлын байр бий болгох, баялагийг тэгш хуваарилах/ хуваах асуудал бол гол хүндрэлтэй асуудал биш юм. Иймд төсөл нь а) шинэ зах зээл ба бүтээгдхүүнийг бий болгох, б) хөдөлмөрийн тусгай эрчимжүүлсэн төрлүүдийг бий болгох ба бүтээгдхүүн үйлдвэрлэх аргуудыг дэмжих, в) ажлын шинэ байр ба орлогыг бий болгож чадна гэсний үндсэн дээр ЖДҮ -ийг дэмжих гэсэн асуудлуудад шууд бусаар хандаж/ чиглэж болно. Харин төсөл тогтвортой ажлын байр, орлогыг шууд бий болгож чадахгүй.
- Тогтвортой байлгах, төлбөр татвар гэдэг асуудлууд нь нийцэхгүй асуудал. Хэрэв аливаа үйлчилгээ, хүртэх ашиг тусыг тогтвортой удаан хугацаанд үргэлжлүүлэх гэж тодорхойлж байгаа бол татвар хураамжийг үг дуугүй өгөх нь тогтвортой байдлыг бий болгож чадахгүй. Хэрэв төлбөр хураамжийг аажимдаа бүтээгдхүүний үнэд оруулж өгөхгүй бол тухайн үйл ажиллагааг унагахад хүргэж байгаа гэсэн үг

юм. Энэ нь төсөл дууссаны дараа төр засаг энэ санхүүгийн үйлчилгээний цоорхойг нөхөх байх гэсэн хоосон санааг хэлж байна.

- Төслийн хувийн салбарт оролцох оролцоо нь ямагт эрсдэл байна, магадгүй нэлээд сайн ажиллагаатай зах зээлүүд ч тухайн зах зээл дэх хамгийн сул талуудад ч өртөж болно. Иймээс газар орон нутаг бүрт байгаа бизнесийн боломжууд, шинээр санаачилсан бүтээгдхүүн ба эсвэл үйлдвэрлэл тэдгээрийн үр дүнгүүдэд сайтар анализ дүн шинжилгээ хийх хэрэгтэй.
- Төсөл месо/meso/ түвшинд гол анхаарлаа хандуулна. Энэ нь юуны өмнө “боломж нөхцөлд хүрэх/олж авах” гэсэн үг. Тухайлбал мэдлэгийг олж авах, ур чадвартай болох, хөрөнгөтэй болох, нийгмийн тодорхой зорилтод хэсгүүдэд зах зээл, үйлдвэрлэл, ажлын байр бий болгох зэрэгт анхаарлаа хандуулна. Үр дүнтэй оролцоог бий болгох урьдчилсан нөхцөл бол тухайн чадварлаг үйлчилгээ хүргэгч үзүүлэгчдийг бий болгох явдал юм. Төсөл нь микро түвшинд тухайлбал хувийн бизнесийн үйл ажиллагаанд шууд оролцож ажиллахгүй.

*2.5.3.2 Эрслүүд ба таамаглал*

Шинэ технологийг нэвтрүүлэх нь эрсдэлтэй байдаг. Энэ нь Монголын нөхцөлд нарийн шалгаж туршин сайн тохируулж хийхгүйгээр эрсдэл гарна. Монголчууд шинэ технологийг туршин шалгаж үзэх, тэдгээрийг тааруулж хэрэглэхдээ дэндүү хурдан заримдаа зөв хэрэглэх ашиглах, засвар үйлчилгээнд зардлууд гаргадаг.

Хийж буй үндсэн таамаглал бол орлого бий болгох/олох хувилбарууд байсаар байна харин тэдгээр нь олон янз байх нь боломжтой. Гэхдээ хэр зэрэг гэдэг нь тухайн газар орон нутаг, иргэдийн хэрэгцээ, боломжоос нэлээд хамаарах бөгөөд эдгээрийн төслийн үйл ажиллагаа, оролцоонд хэрхэн хамруулснаас хамаарна.

Одоогоор тус улсын /орон нутгийн банкууд алт худалдаж авдаггүй учраас алтны ихэнхийг хууль бусаар худалдаж байна. Мөн албан ёсоор худалдаж буй алтны татварт төрөөс тавьж буй шардлагууд нь бичил уурхай эрхлэгчдийг алтаа шууд алтны худалдаачдад худалдахад хүргэж байна.

### *2.5.4 Бүрэлдэхүүн хэсэг 4: Нийгмийн хамгааллыг сайжруулах, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл болон зөрчлийг бууруулах*

**Гарах үр дүн 4: Бичил уурхай эрхлэгчид ба бусад нөөц ашиглагчдыг байгаль орчин экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж, гарч буй зөрчлүүдээ шийдэж чаддаг чадвартай болгох**

*Зорилт 4: Гарах үр дүнгүүд ба гол индикаторууд*

| **Зорилт 3: Гарах үр дүнгүүд** (хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд) | | **Нотлох гол индикаторууд** |
|---|---|---|
| 4.1 | Иргэний нийгэм, төр засгийн байгууллага хувийн компаниудын хооронд харилцан ойлголцол бий болгох ярилцлага уулзалтууд зохион байгуулагдсан байх | Зөрчлүүдийг шийдэж, гарч болох зөрчлүүдээс сэргийлсэн байх.<br>Нөөц ашиглалтын гэрээ/ газар ашиглалтын нэгдсэн төлөвлөгөөтэй болсон байх,<br>Зөрчлийн зохицуулагчдыг сургаж, зөрчлийг бууруулах арга хэрэгслийг бий болгосон байх. |
| 4.2 | Бичил уурхай эрхлэгчдийг өөрсдийн хэрэгцээ шаардлагаа тодорхойлж, үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөөтэй тэдгээр хэрэгцээгээ шийддэг болгох,<br>(Жишээ нь: ерөнхий дэд бүтэцтэй холбоотой ба нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг сайжруулах) | Олон нийтийн хөгжлийн байдалд тодорхой чиглэлээр үнэлгээ хийх<br>Тодорхой үр дүнгүүд гарсан байх Тухайлбал:<br>➢ ДОХ зэрэг эрүүл мэндийн асуудал, урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэгтэй болсон байх,<br>➢ Сургууль завсардалт буурсан байх<br>➢ Эрүүл ахуйн шаардлага хангасан ундны устай болсон байх |
| 4.3 | Төслийн оролцооны мониторингийн механизмууд ба байгалийн нөөцийн цогц ашиглалтыг орон нутагт бий болгох | Холбогдох талууд (төсөл оролцон)-ын баримтжуулж өгсөн хариулт, санал дүгнэлтүүдийг мониторингийн тайланд тусгах |
| 4.4 | Байгаль орчинд учруулсан хор хохирол, гарч болох зөрчлүүд буурсан байх | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлал гарсан байх<br>Нөхөн сэргээлтийн аргуудыг туршсан байх<br>Усны бохирдлыг бууруулсан байх<br>Түлшний үр ашигтай эх үүсвэрүүдийг тогтоож бичил уурхай эрхлэгчдийн дунд хэрэглэдэг болсон байна. |

*Үндсэн үйл ажиллагаанууд, төслөөс оруулах хувь нэмэр, гол харилцагч хамтрагч талууд*

| **Үр дүн** | **Үйл ажиллагаа** | **Гол харилцагч, хамтрагч талууд** | **Төслөөс оруулах хувь нэмэр** |
|---|---|---|---|
| 4.1 | Зөрчлийг зохицуулах, сэргийлэх хууль эрх зүйн орчны талаар хийх сургалтууд | Иргэний хөдөлгөөн, ТББ-ууд, орон нутгийн засаг | Сургалтууд ба мэргэжлийн туслалцаа |

| | | | |
|---|---|---|---|
| | Зохицуулагчдыг сургах сургалтууд<br>Баримтжуулсан мэдээллийг цуглуулж, боловсруулан хэрэглэгчдэд нээлтэй байлгах | захиргаад | Мэдээлэлд дүн шинжилгээ хийх ба боловсруулах (жишээ нь:нөөц, ашиглагчид, газрын зургууд, усны чанарын талаарх мэдээ мэдээлэл гм) |
| 4.2 | Бичил уурхай эрхлэгчдийн хэрэгцээнд оролцооны аргаар үнэлгээ хийх<br>Мэдээлэлтэй болж, чадвараа дээшлүүлэх боломж олгох<br>Бичил уурхай эрхлэгчдийн гол төлөөллийг зохион байгуулалтын асуудлаар сургах, үйл ажиллагаанд татан оруулах<br>Олон нийтийн санаачлагуудыг дэмжих | Бичил уурхай эрхлэгчид<br>Багийн дарга нар ба багийн төлөөлөгчид | Хэрэгцээнд үнэлгээ өгөх<br>Сургалтууд<br>Олон нийтийн хөгжлийг дэмжих санаачлагууд<br>Шинэ техник технологийг нэвтрүүлэх |
| 4.3 | Байгалийн нөөцийн цогц үнэлгээний сургалт<br>Төслийн оролцооны мониторингийн сургалт<br>Төслийн хувьд суралцах үйл явцыг баримтжуулах | Засаг захиргаа ба бичил уурхай эрхлэгчдийн төлөөлөгчид<br>БУД төслийн ажилтнууд | Сургалтууд<br>Аргачлал ба аргууд<br>Сургалт семинарууд |
| 4.4 | Бичил уурхайд нийцсэн өртөг хямдтай байгаль орчны үнэлгээний аргачлалыг бий болгох,<br>Бичил уурхайгаар олборлолт хийж байгаад орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийх аргуудыг боловсруулах<br>Байгаль орчинд ээлтэй технологийг бий болгож дэлгэрүүлэх | Орон нутгийн засаг захиргааны ажилтнууд<br>Улсын байцаагчид ба бичил уурхай эрхлэгчид<br>Бичил уурхай эрхлэгчид ба малчид | Шинэ техник технологийг нэвтрүүлэх<br>Газар дээр нь туршилтууд хийгдсэн байх<br>Нөлөөллийн үнэлгээнүүд ба арга хэрэгсэл |

*2.5.4.1 <u>Үйл ажиллагааны стратеги</u>*

Төсөл нь юуны өмнө а) зөрчлийг шийдвэрлэх механизмууд бий болгох б) зөрчлийг үүсгэж байгаа шалтгаануудыг тогтоож тэдгээрийг арилгах гэсэн хоёр арга замаар ажиллах болно. Энэ хоёр арга замаар ажиллахдаа Швейцарийн хөгжлийн агентлагаас гаргасан Энхийг сахиулах удирдамж (SDC 2006)-д заасны дагуу тус агентлагаас төв Азийн Ферганы хөндийд зөрчлийг зохицуулж ирсэн туршлагаас хэрэглэх болно.

Байгалийн нөөц ашиглалтын төлөө тэмцэл зөрчил хийж байсан өнгөрсөн түүхээс харахад нэлээд нарийн сүлжээ үүсгэсэн гэж хэлж болно. Иймээс төсөл төв, бүс нутгийн засаг захиргаадын хооронд эрх мэдлийг хуваах, улсын ба хувийн салбар, бичил уурхай эрхлэгчид, иргэний нийгмийн хоорондын холбоо харилцааг бүхэлд нь сайжруулахад чиглэх болно. Төсөл нь нийгмийн шударга байдал, хүний эрх, тэгш байдал, хүний аюулгүй байдлыг дээдлэн зөрчлийг зохицуулахад оролцож буй талуудад сургалт явуулж, тэдгээрийг чадваржуулахад анхаарах болно. Байгалийн нөөцийг ашиглах боломж олгохгүй байх, эсвэл зогсоох, эвдрэл сүйрэл бий болгох, эдгээрийг дагаад ядуурал өсөх гэсэн гаж хандлагын улмаас гол хүндрэл бэрхшээл үүсэж болох юм.

Зөрчлийг үүсгэж буй шалтгаануудыг авч үзэхдээ орон нутгийн иргэд өөрсдийн амьжиргааг дээшлүүлэхэд идэвхитэй оролцдог болоход анхаарах болно. Төсөл нь өөрийн ажилтнууд ба хамтрагч талуудаа техникийн, нийгмийн асуудлуудыг боловсруулах дадал эзэмших нөхцөл бүрдүүлнэ. Үүний тулд зөрчил үүсгэгч шалтгаануудыг бий болгохгүй байх, оролцооны аргаар шийдвэр гаргадаг механизмууд ба нөөцийг ашиглах нөхцлийг бий болгоно.
Хамтрагч талуудын дунд зөвхөн сайн засаглалын зарчмуудыг дэмжих бус харин нутгийн иргэдийг харилцан бие биенээсээ суралцдаг, харилцан ашигтай байхад төсөл анхааран ажиллана. Иймээс төслийн үр дүнгийн оролцооны мониторинг (Germann and Gohl 1996)–ийг бичил уурхай эрхлэгчдийн нийгэм соёлын асуудлуудад гарч буй өөрчлөлтийг хэмжихэд хэрэглэх болно. Бичил уурхай эрхлэгчдийг ажиглалт хийх, тусгаж авах (бодож тунгааж зөвшилцөлд хүрэх), шийдвэр гаргаж чаддаг болоход сургаж бэлтгэх хэрэгтэй. Үүнтэй адил байгаль орчны эрүүл байдалд хяналт тавьж чаддаг болгох зарчмуудыг мөн хэрэглэх болно. Байгаль орчинд ээлтэй техник технологийг хэрэглэхийг дэмжих болно.

#### *2.5.4.2 <u>Гарч болох эрсдлүүд ба таамаглалууд</u>*

Зөрчлийг улам хурцатгаж болох эрсдэл байна. Иймээс зөрчлийг зохицуулагчид нь төвийг сахисан байр суурьтай, оролцогч талуудыг сайн сонсож, тэдний тавьж буй асуудлуудыг анхааралтай авч үзэх ёстой. Одоогоор зөвхөн албан ёсны компаниуд лизенци авах боломжтойгоос гадна Монголын газар нутгийн бараг 50%-г ашиглалтын ба хайгуулын лизенцтэй талбай эзэлж байна. Бичил уурхай эрхлэгчид, малчдын хувьд тийм боломж байдаггүй нь шударга бус байна. Гэхдээ уул уурхайн албан ёсны компаниуд өөрсдийн лизенцитэй талбайн нөөц нь хязгаарлагдмал хэсэгт бичил уурхай эрхлэгчидтэй тодорхой гэрээний үндсэн дээр ашиглуулах талаар хэлэлцэхэд бэлэн байгаа гэдэг нь төслийн туршилтын шатны хугацаанд ажиглагдаж байсан.

Бичил уурхай эрхлэж буй хүмүүсийн хувьд олон нийтийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд тогтвортой оролцох боломжгүй байж болох талтай. Учир нь бичил уурхай эрхэлж буй хүмүүс (зарим нь гаднаас янз бүрийн хугацаатай ирдэг, зарим нь ажиллаж байсан газраасаа явж байдаг)-ийн бүтэц бүрэлдэхүүнд байнга өөрчлөлт орж байдаг. Ер нь байгаа нөөц (алт, ус, түлш гм)-ний олдоц эсвэл эрх зүйн зохицуулалт (хүч хэрэглэн нүүлгэх) зэргээс хамааралтай байдаг. Иймээс олон нийтийн хөгжлийн асуудлыг авч үзэхдээ нүүдлийн хүмүүст тохирсон нийцсэн арга хэмжээ, шийдлүүдийг олох нь зүйтэй юм. Төслийн туршилтын шатанд байгуулан ажиллуулж буй явуулын ба хөдөлгөөнт аврах албаны туршлагаас харахад эдгээр хүмүүст хөгжлийн бусад арга хэмжээг мөн ийм хэлбэрээр явуулах нь зүйтэй гэсэн үр дүнг харуулж байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ нь бичил уурхай эрхлэгчдийн хувьд хэтэрхий өндөр өртөгтэй байж болно. Хэдийгээр мод, модлог ургамлыг түлшинд хэрэглэхийг бууруулах, түлшний өөр эх үүсвэрээр солих, орхигдсон газруудыг нөхөн сэргээх, усны нөөцийг сайжруулах практик ач холбогдлын талаар онцлон авч үзэж байгаа ч төсөл эдгээр арга хэмжээтэй холбогдсон зардлуудыг тооцож дүн шинжилгээ хийж үзэх хэрэгтэй. Хэрэв эдгээр арга хэмжээ нь зардлын хувьд хэмнэлтэй, дундыг баримталсан байж, өргөнөөр тогтвортой ашиглах боломжтой байвал үр дүнтэй үйл ажиллагаа болно.

## *2.6 Төслийн хүлээгдэж буй үр дүн*

Төсөл хэрэгжиж дуусах үед бичил уурхайн үйл ажиллагаа нь үр ашигтай техник технологи хэрэглэж нийгэм ба байгаль орчны хувьд хариуцлагатай байж албан ёсны, зохион байгуулалттай ашигтай үйл ажиллагаа болсон байна. Бичил уурхай эрхлэгчид нь сайн засаглал, хууль эрх зүй, оролцоо, олон янз байдлыг хүндэтгэсэн нөхцөлд амжилттай хөгжиж, чадваржиж чадна. Бичил уурхай эрхлэлт нь ажлын байр бий болгох, орон нутгийн хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулах, байгалийн нөөц ашиглагч

бусад талуудтай уялдуулах, олборлосон бүтээгдэхүүн (ашигт малтмал), үнэт эдлэлийг шударга худалдаагаар борлуулдаг болоход чухал үүрэгтэй байх болно.

### 2.6.1 Бүрэлдхүүн хэсэг1: Бодлого, зохицуулалтын орчинг сайжруулах

Бичил уурхайн тодорхой бодлогоор дэмжсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлэх нь бичил уурхайн үйл ажиллагааг илүү мэргэжлийн түвшинд хүргэж, эдийн засгийн ашигтай үйл ажиллагаа болгохын дээр зөвхөн бичил уурхай эрхлэгчид тэдгээрийн гэр бүлд ашиг тустай байгаад зогсохгүй хөдөө орон нутагт орлогын хоёрдогч эх үүсвэрийг бий болгоно.

Бичил уурхай эрхлэгчдэд зөвшөөрөл олгох ба тэднийг орон нутагт бүртгэлтэй болгох асуудлыг ил тод шийдвэрлэх нь бичил уурхайн хууль эрх зүйн орчноос гарах гол чухал үр дүн байх бөгөөд энэ нь бичил уурхай эрхлэгчдийг албан ёсны бүртгэлтэй болгож иргэдийн эрхийг эдлүүлж тэднийг саналаа өгөх, нийгмийн үйлчилгээг авах улмаар өөрсдийгөө хүндэтгэдэг болоход чухал нөлөө үзүүлэх болно.

### 2.6.2 Бүрэлдхүүн хэсэг 2: Бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, бэхжүүлэх

Төслийн шинээр бий болгож буй бүтэц, зохион байгуулалт нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зүй зохистой удирдлагаар хангах, төслийн гол хамтрагч байгууллага болох АМГТХЭГ-ын Бичил уурхайн нэгжид чадавхи, мэргэжлийн чадварыг түргэн шуурхай системтэй бий болгоход чиглэж байна. Шийдвэр шууд гаргах ба үүрэг, хариуцлаг хүлээх үүргийг мэргэжилтнүүд ба АМГТХЭГ-т хүлээлгэх нь зөвхөн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаад зогсохгүй үйл ажиллагааны төлөвлөлт хийх, төсөв хуваарилах хяналт тавихад оролцож хамтрагч талуудыг чадваржуулахад чухал нөлөө үзүүлэх болно. Ийм бүтэц зохион байгуулалт нь үйл ажиллагааны менежмент, хүлээх үүрэг, хариуцлагыг аажимдаа Монголын эрх бүхий байгууллагад шилжүүлэх үндэслэл болж үүнийг төслийн төгсгөлийн стратеги гэж тодорхойлж байгаа юм. Түүнчлэн энэ бүтэц зохион байгуулалт нь төслийн багийн хэмжээнд багаар хамтран ажиллах сайхан нөхцөл бүрдүүлж өгч байгаа юм.

Үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ харилцагч хамтрагч талууд, төсөл хөтөлбөрүүдийг хооронд нь уялдуулж хамтран ажиллах нь Монгол орны бичил уурхайн салбар ба байгалийн нөөцийн менежментэд хамтын ажиллагааны зарчмыг хэрэглэн нэлээд өргөн хүрээний сүлжээг бий болгох болно. Бичил уурхай нь хөдөөгийн ядуу иргэдийн эдийн засгийн нэн тэргүүний хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй гэдэг үүднээс салбар хоорондын асуудлуудыг нухацтай авч үздэг болоход холбогдох байгууллагуудын ажилтнуудад сургалт явуулах болно. Менежментийн арга замууд болон үндсэн мэдлэгтэй холбоотой материалын эх сурвалжууд гол харилцагч хамтрагч талуудад бэлэн байх болно.

### 2.6.3 Бүрэлдхүүн хэсэг 3: Орон нутгийн эдийн засаг ба хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх

Өмнөд Америкийн орнууд болон бусад орнуудад хэрэгжсэн бичил уурхай төслүүдийн туршлагаас суралцан орон нутагт/дотооддоо үйлдвэрлэж болох, нийгмийн хувьд хүлээн зөвшөөрсөн, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн ашигтай техник технологийг нэлээд өргөн хүрээгээр дэмжин нэвтрүүлэх болно. Энэ нь зөрчил, эрсдэл, байгаль орчинд хортой, бохирдол үүсгэдэг олборлолтоос байгаль орчинд ээлтэй, тогтвортой, үр дүн сайтай бичил уурхайн үйл ажиллагаанд шилжүүлэх явдал юм. Ингэснээр бичил уурхай нь хөдөөгийн хөгжилд макро эдийн засгийн хүрээнд хувь нэмэр оруулах болно.

Түүнчлэн Монгол улсад хүний эрхийг дээдэлсэн шударга хөдөлмөр бүхий бичил уурхайгаар олборлож, экологийн цэвэр бүтээгдхүүнээр хийсэн үнэт эдлэлийг дэлхийн зах зээлд Монгол улсын брэнд бүтээгдхүүн болгон нийлүүлэхэд төсөл хувь нэмэр оруулах юм.

### 2.6.4 Бүрэлдхүүн хэсэг 4: Нийгэм ба байгаль орчинтой холбоотой гарч буй зөрчлийн бууруулах ажлыг сайжруулах

Бичил уурхай эрхлэгчдийг өөрсдийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагаа тодорхойлж, төслийн дэмжлэг тусламжтайгаар өөрсдийн нөөц, хүчээр шийдэж чаддаг болгоно. Байгалийн нөөцийн зохистой ашиглалт ба төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлд оролцооны аргаар мониторинг хийх нь төслийн талаар тэдний санал дүгнэлтийг авч чадахаас гадна харилцан суралцах ба мэдлэгийн үр ашигтай менежментийг бий болгоход тустай байх болно. Төсөл нь Монгол улсын хөдөөгийн ядуу иргэд ялангуяа бичил уурхай эрхлэгчид , тэдгээрийн гэр бүлийн нийгмийн асуудал, амьжиргааг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх болно. Хууль эрх зүйн зохицуулалтанд гарч байгаа саадыг багасгах, бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг албан ёсны болгохыг дэмжин туслах, тэднийг нийгмийн үйлчилгээ (ялангуяа эрүүл мэнд, боловсрол, ундны цэвэр ус гм)-г авч чаддаг болгох нь бичил уурхай эрхлэгчдийг нийгмийн зүй ёсны нэг хэсэг болгон, тэдний амьжиргааг дээшлүүлэх, тэдний үр хүүхдүүдийг цаашид боловсролтой болж ирээдүйн чиг баримжаагаа зөв олоход нь туслах болно.

Уламжлалт болон байгаль орчинд хор нөлөөтэй технологийг байгаль орчинд ээлтэй технологиор сольж аажимдаа бичил уурхайн олборлолтоор эвдрэлд орсон газруудыг нөхөн сэргээх болно. Тусгайлан сургаж бэлтгэсэн зохицуулагчдын оролцоотой аливаа зөрчлийг тайван ба оролцооны аргаар шийдвэрлэж, цаашдаа оролцогч талуудын хооронд нөөц ашиглалтын талаар харилцан тохиролцсон гэрээ хэлэлцээр хийдэг болоход хүргэнэ.

Төслөөр дамжуулан Монгол улсын уул уурхайн удирдлагын тогтвортой байдлын зарчмууд ба нийгмийн хариуцлагын асуудлыг загварчлах болно. Энд Монгол улсын хөдөөд ядуурлыг бууруулах, ашигт малтмалын нөөцийн ашиглалтыг эдийн засгийн мезо ба макро түвшинд ашигтай байлгахад АМГТХЭГ-ын оруулах хувь нэмэр их байх болно. Энэ нь эргээд уул уурхайн том компаниуд ба бичил уурхай эрхлэгчдийн хооронд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх болно.

## 2.7 Гол харилцагч, хамтрагч талууд ба төслийн үр ашгийг хүртэгчид

Тогтвортой бичил уурхай төсөл нь бичил уурхайн үйл ажиллагаанд шууд ба шууд бусаар оролцож байгаа талуудтай хамтран ажиллах болно. Тухайлбал төр засгийн байгууллагууд, хувийн салбар, иргэний нийгмийн байгууллагууд, бичил уурхай эрхлэгчид болон бичил уурхайн үйл ажиллагааны нөлөөнд орсон малчид ба тэдгээрийн гэр бүлийн гишүүд байх болно. Хамгийн гол чухал хамтрагч, харилцагч нарын талаар Хавсралт 10.2-т дэлгэрэнгүй үзүүлсэн болно..

### 2.7.1 Бичил уурхай эрхлэгчид

Одоогоор бичил уурхай эрхлэгчид нь олборлолт явуулах зөвшөөрөгдсөн газаргүй, маш хязгаарлагдмал хүрээнд олборлолт явуулж байгаа ч тэдний тоо жилээс жилд өсөж байна. АМГТХЭГ тус оронд 100,000 орчим бичил уурхай эрхлэгчилд байдаг гэсэн тоог гаргасан байна. Эдгээр бичил уурхай эрхлэгчид нь бүгд байнга ажилладаггүй зарим хэсэг нь улирлаар нөгөө хэсэг амралтын өдрүүдэд ажилладаг. Бичил уурхай эрхлэгчдийг олборлолт явуулах газартай болгох, аюулгүй ажиллагааны нөхцөл, техник технологийг сайжруулснаар тэдний амьжиргааны түвшин эрс дээшлэх болно. Бичил уурхай эрхлэгчдийн ихэнхи нь гар ажиллагаатай хөдөлмөр эрхэлж байна. Хүүхдийн хөдөлмөр байсаар байна. Бичил уурхай эрхлэгчид нь төслийн үр ашгийг хүртэгч хамгийн гол хэсэг нь байж өөрийн гэсэн байр суурь, эрх, нэр хүндтэй болж илүү орлого олох боломжтой болно.

Түүнчлэн бичил уурхай эрхлэгчдэд үйлчилгээ хүргэдэг иргэд, жижиглэнгийн худалдаа эрхлэгч хүмүүс энд орно. Эдгээр хүмүүсийг хөдөөгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах хүмүүс гэж үзэх болно. Эдгээр бизнес эрхлэгч хүмүүс, бичил уурхай эрхлэгчдийн хооронд харилцан итгэлцэл маш сайн байдаг гэж үздэг. Иймээс эдгээр

бүлэг хүмүүсийг бичил уурхай эрхлэгчдийн холбоонд оруулах нь олон нийтийн хөгжлийн асуудалд чухал ач холбогдолтой байх болно.

### *2.7.2 Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ)*

Ашигт малтмалын нөөцийн менежментийн асуудлыг хариуцдаг тус хэрэг эрхлэх газар нь Үйлдвэр худалдааны яаманд харьяалагддаг. АМГТХЭГ нь лизенцийн төлбөрөөс асар их хэмжээний орлого олдог ч бичил уурхайн салбарыг үр дүнтэй зохицуулж ажиллахад хөрөнгө санхүүгийн нөөц бололцоо дутмаг байдаг. Бичил уурхайг дэмжих төсөл хэрэгжиж эхэлснээс хойш тус салбарын үйл ажиллагаанд илүү анхаарал тавьж Бичил уурхайг дэмжих тасгийг байгуулж ажиллуулж эхлээд байна. Тус нэгжид ажиллаж буй ажилтнууд нь юуны өмнө бичил уурхайн асуудлаар ажлын байранд суралцах нөхцлөөр хангагдахаас гадна төсөл хэрэгжих хугацаанд тус нэгжийн ажилтан, мэргэжилтнүүдийн чадавхийг бий болгоход зориулан тусгай нөөц хуваарилаад байна.

### *2.7.3 Аймаг, сумдын засаг захиргаа*

Аймаг сумын засаг захиргаад нь орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн нөөцийн менежментэд чухал үүрэгтэй оролцох хэдий ч одоогоор энэ чиглэлээр ажиллах хөрөнгө нөөц, чадварын хувьд дутагдалтай байдаг. Сум бүр сургаж бэлтгэсэн газар зохион байгуулагч мэргэжилтэн байх ёстой ч одоогоор нийт 360 сумаас зөвхөн 100 сум нь ийм мэргэжилтэнтэй байна. Иймээс энэхүү төсөл хөтөлбөр нь ялангуяа газар ашиглалт/ зохион байгуулалтын төлөвлөлт ба эрх зүйн асуудлаар гол шийдвэр гаргахад оролцох болно. Орон нутгийн засаг захиргаад нь газар ашиглах эрх, байгалийн нөөц, ус ашиглах лизенци, зөвшөөрлийг батлах эрх мэдэл бүхий байгууллага байна. Сум бүр байгаль орчны дүрэм журмыг сахиулах үүрэгтэй байгаль орчны байцаагчтай бөгөөд эдгээр байцаагчид нь тус улсын Ерөнхий сайдын удирдлага дор ажилладаг Улсын мэргэжлийн хяналтын албанд харьяалагддаг.

### *2.7.4 Уул уурхайн албан ёсны компаниуд*

Уул уурхайн албан ёсны компаниудын хувьд бичил уурхай эрхлэгчидтэй гардаг зөрчлийг бууруулах нь чухал юм. Эдгээр компаниуд ялангуяа олон улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниудад “хариуцлагатай уул уурхай”-н асуудал мөн ижил чухал асуудал байна. Албан ёсны компаниуд нь төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжиж бичил уурхайн салбарыг зохицуулалтанд оруулахыг хүсдэг.

### *2.7.5 Үйлдвэр худалдааны яам, Байгаль орчны яам*

Үйлдвэр худалдааны яам (ҮХЯ) нь худалдаа ба үйлдвэрийн салбарын бодлогын асуудлыг тодорхойлж, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй ажилладаг. Үүнтэй адил Байгаль орчны яам (БОЯ) байгаль орчны бодлогын орчинг тодорхойлж, бодлогын холбогдолтой зөвлөмж, стандартуудыг гаргадаг. Тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ихэнхи нь энэ хоёр яамтай холбоотой учраас тус хоёр яамны төлөөлөл төслийн Удирдах зөвлөлд орсон. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тэдний гүйцэтгэх үүргийг дараахи байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Удирдах зөвлөлд идэвхитэй оролцох,
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийгдэх мониторинг ба үнэлгээнд оролцох,
- Орон нутгийн засаг захиргаа ба бодлого боловсруулагчидтай холбоо тогтооход туслах,
- Хөтөлбөрт холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулж, хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэх,
- Холбогдох статистикийн болон бусад шаардлагатай мэдээ мэдээлэлтэй болоход туслах,
- Гаднаас шаардлагатай техник технологи оруулж ирэх ба мэргэжилтнүүдийг урьж гэрээгээр ажиллуулахад тусламж дэмжлэг үзүүлэх.

### *2.7.6 Их сургуулиуд ба төрийн байгууллагууд*

Хөтөлбөр нь Монгол улсын их сургуулиуд ба Уул уурхайн аврах алба зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах болно. Эдгээр байгууллагуудын ажилтнуудад шаардлагатай сургалтыг явуулж, бичил уурхайн салбарт шаардлагатай техник технологийг нэвтрүүлэх, турших, олон нийтийг татан оролцуулах, үйлчилгээ үзүүлэх, нийгмийн асуудал болон оролцооны аргаар шаардлагатай судалгааг явуулах зэрэг үйл ажиллагаанд оролцох болно. Их сургуулиуд ба судалгааны байгууллагууд дараахи үүрэгтэйгээр хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллана. Үүнд:

- Шинэ техник технологи, тоног төхөөрөмжийг бүтээх, турших, дэлгэрүүлэхэд туслах,
- Үнэлгээ ба дүн шинжилгээ хийх ажлуудаар сургалтууд, мэргэжлийн/техникийн тусламж үзүүлэх,
- Шаардлагатай хэмжигдхүүн/параметрүүд (жишээ нь усны бохирдол, мөнгөн усны бохирдол, түлшний хэмнэл, алт барилт гм)-ийг тогтоох хээрийн судалгааны ажлуудыг явуулах,
- Орон нутагт шаардлагатай сургалтууд, туршилтуудыг явуулахад туслах.

### *2.7.7 Олон улсын хамтрагч талууд*

Хөтөлбөр нь АМГТХЭГ ба Өмнөд америкийн зарим орнуудад Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлдэг төслүүд-(Medio Ambiente y Minerнa, Proyecto Minerнa Sin Contaminaciyn)-ээр дамжуулан Проект консалт олон улсын зөвлөх компани, Хариуцлагатай уул уурхайн холбоо зэрэг бусад холбогдох байгууллагуудаас техникийн болон судалгаа, мэргэжлийн зөвлөгөөг авч байх болно. Хөтөлбөрт шаардлагатай зөвлөгөөг Проект консалт (Герман) компани ба АМГТХЭГ (Монгол) зохицуулан өгөх болно. Хөтөлбөрт зөвлөхөөр ажиллах хүмүүс нь юуны өмнө бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, техник технологийг сайжруулах, мэргэжлийн байгууллагууд (жишээ нь: УУАА)-ад шаардлагатай сургалтууд явуулах, нөөц ашиглагчидтай холбоотой судалгаа шинжилгээ, хөгжлийн асуудлуудад чухал үүрэгтэй оролцох болно. Зөвлөхүүд нь төслийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж оруулсан сургалтуудад мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх болно.

### *2.7.8 Хөтөлбөрөөс шууд бусаар ашиг хүртэгчид*

Бичил уурхай эрхлэгчдэд шаардлагатай тусламж дэмжлэгийг хүргэж тэдний гол асуудлуудыг шийдвэрлэснээр тухайн орон нутгийн иргэд түүний дотор малчид ба тэдгээрийн гэр бүлийн гишүүд хөтөлбөрөөс шууд бусаар ашиг хүртэх болно. Тухайлбал, байгаль орчинд хоргүй технологи хэрэглэж бохирдол буурч, бичил уурхай эрхлэгчид ба малчдын хооронд бэлчээр, усны төлөө гардаг зөрчил буурах болно. Швейцарийн хөгжлийн агентлаг

Швейцарийн хөгжлийн агентлаг нь хөтөлбөрийг санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагынхаа хувьд хөтөлбөрийн менежмент ба хэрэгжилтийн аль алиныг хариуцах болно. Швейцарийн хөгжлийн агентлаг нь хөтөлбөрийн санхүүжилт, нөөцийг төлөвлөсөн үйл ажиллагаа, гарах үр дүнгийн дагуу зарцуулах болно. Тус агентлаг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн санхүүжилтээ зарцуулахын зэрэгцээ ТА, гадаад сургалтууд зэрэг бусад санхүүжилтийн гадаад эх үүсвэрүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх болно. Тус агентлаг нь төсөл хэрэгжүүлэгч нэгжийг удирдахаас гадна үйл ажиллагааны ба санхүүжилтийн хяналт мониторингийн асуудлыг хариуцах болно. Швейцарийн хөгжлийн агентлаг нь төслийн Удирдах зөвлөлд орсны хувьд төслийн баримт бичиг, холбогдох тайлан, үнэлгээнд тусгасан ерөнхий зорилго, зорилтуудаас гадуур зөрчсөн аливаа шийдвэрт хориг тавих эрхтэй. Төслийн санхүү, бүртгэл зарцуулалтанд өөрийн баталсан аудитын газраар жил бүр хөндлөнгийн хяналтыг хийлгэж байх болно.

### *2.8 Үйл ажиллагааны зарчмууд*

Хөтөлбөр нь хөгжлийн зорилгоо хангахын тулд үйл ажиллагаандаа дараах гол зарчмуудыг баримтлах болно. Үүнд:

**Оролцоо:** төслийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт мониторинг, үнэлгээг оролцооны аргаар гүйцэтгэх болно. Бичил уурхай эрхлэгчид, малчид, орон нутгийн засаг захиргаа, албан ёсны уурхай эрхлэгчид зэрэг гол харилцагч хамтрагч талуудын оролцоотойгоор хөгжлийн гол асуудлыг бичил уурхай эрхлэгчид ба энэ салбарын байгууллагуудад чиглүүлэх болно. Төсөл нь янз бүрийн түвшинд төслийн үр ашгийг хүртэгчдийн идэвхитэй оролцоог бий болгож ялангуяа мэдээлэл ба сургалтын хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай техник технологийг турших, сонголтууд хийх, шийдвэр гаргахад идэвхтэй оролцуулах болно.

**Тэгш байдал:** төсөл нь нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулахад хувь нэмэр оруулах болно. Тухайлбал жендерийн асуудал, орон нутгийн харьяалал, хэсэг бүлгээрээ ялгавартай, тэгш бус ханддаг асуудлыг авч үзэн тэнцвэртэй байх зарчмыг нэвтрүүлэх болно. Тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд төслийн хэрэгжилтийн хугацаанд хяналт тавих болно.

Төсөл нэгэнт нийтийн эзэмшлийн нөөц (газар, ус гм)-тэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа болохоор тэгш байдлыг эрхэмлэн аль болох ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийг хамруулахад анхаарлаа хандуулах болно. Эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээ, шаардлага ялангуяа нөөц ашиглах боломж олгох, мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд анхаарлаа хандуулах болно. Төсөл нь эмзэг бүлгийн хүмүүсийн амьжиргаа дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж үр дүнд хяналт тавих болно.

**Шинэлэг байх:** төсөл нь үйл ажиллагааг шинэлэг арга барилаар илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийг зорих болно. Үүний тулд үндэсний ба донор хандивлагчдын үүсгэл санаачлагуудыг дэмжиж ололт амжилтуудаас нь хэрэглэх болно. Энд олборлолтын үйл ажиллагаанд шинэ техник технологи хэрэглэх, газрын нөхөн сэргээлт ба байгалийн нөөцийн ашиглалтын талаар шинэлэг үйл ажиллагааг нэвтрүүлэх болно. Гаднаас оруулж ирдэг үнэт эдлэлтэй өрсөлдөхүйц үнэт эдлэлийн шударга худалдаа (www.FairTrade.net)-г хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулах болно. Төслийн үндсэн шатанд энэ талаар туршилт явуулж сайн үр дүнтэй туршлагыг эрэмбэ дараатай хуримтлуулж харилцагч хамтрагч талуудыг мэдээллээр хангах болно.

**Эрх мэдэлтэй, чадвартай болгох:** төсөл нь харилцагч хамтрагч талуудыг чадавхитай болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэх болно. Ялангуяа бичил уурхай эрхлэгчид тэдний доторх эмзэг бүлгийн хүмүүст олборлолт явуулах газартай болгох, сайжруулсан техник технологи хэрэглэдэг болгох, мэдээлэлтэй болгох, ажлын нөхцлийг нь сайжруулах зорилго тавих болно. Энд бичил уурхай эрхлэгчдийн үндэсний сүлжээг бий болгон зохион байгуулалттайгаар тэдний эрх ашиг сонирхлыг гаргаж тавьдаг болно. Бичил уурхай эрхлэгчдийг чадваржуулахад юуны өмнө тэднийг мэдээлэлтэй болгох, нийгмийн үйлчилгээнд хамруулах, бизнес, техникийн шинэ мэдлэг /ноу хоу-г эзэмшүүлэхэд гол анхаарлаа хандуулах болно.

**Тогтвортой байдал:** төсөл нь бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааг сайжруулахад эдийн засаг, экологи, нийгмийн асуудлуудад тустай шийдлүүдийг гаргахад гол анхаарлаа хандуулах болно. Энд улсын/төрийн байгууллагууд хувийн салбар ба бичил уурхай эрхлэгчдийн хоорондын харилцаанд голлон анхаарах болно. Улсын үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн (нэгэнт ашигтай гэж байгаа болохоор төлбөр хураамж байнга авах үндэслэлтэй) ба хувийн үйлчилгээ, бүтээгдэхүүний (гарч буй ашиг нь шууд хувь хүмүүст хүрч байгаа болохоор тэд ч бас төлбөр төлөх ёстой) хоорондын ялгааг тодорхой гаргаж хэрэглэдэг байх хэрэгтэй. Хэрэв татаас/ төлбөр төлөх хэрэгтэй бол хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаанууд нь дараахи үзүүлэлтүүдээр тодорхой стратегитэй байх хэрэгтэй. Үүнд:

- Төлбөр хураамжийн ямар хэлбэр болох (нийлүүлэлт эсвэл эрэлт хэрэгцээний талаас)
- Нөлөөлөх хүчин зүйлс ба шалгуурууд (зардлын хүчин зүйлс, харилцагч ба үйлчлүүлэгчид борлуулалтын нийт хэмжээ гм)
- Үргэлжлэх хугацаа
- Төгсгөлийн үе (төлөвлөсөн цаг хугацаа/гарах үр дүн? төслийн санхүүжилтийн хэлбэрүүд?)

Хэдийгээр ядууралтай холбоотой асуудлаар тусламж дэмжлэг үзүүлж байгаа ч төсөл нь аль болох бэлэнчлэх сэтгэлгээнээс зайлсхийнэ.

**Мэдлэгээ хослуулах:** төсөл нь тус орны бичил уурхай эрхлэгчдийн мэдлэг туршлагад үндэслэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх болно. Түүнчлэн бичил уурхайн салбарын олон улсын мэдлэг туршлагаас дэлгэрүүлэх ялангуяа сонгосон газруудын бичил уурхай эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд хэрэглэх болно. Иймд төсөл нь бусад орнуудын бичил уурхай эрхлэх туршлагаас суралцан харилцан туршлагаа солилцон шаардлагатай сургалт, туршилтуудыг явуулж шинэ мэдлэг мэдээллийг бий болгон уламжлалт ба орчин үеийн дэвшилтэд арга үйл ажиллагааг хослуулах болно.

**Зардлаа хуваах:** төсөл холбогдох талууд (засаг захиргаа, иргэний нийгэм, хувийн салбар)-тай хамтран ажиллаж, үйл ажиллагааны зардлаа хуваалцаж, үр дүнг хариуцах болно. Төсөл хэрэгжих хугацаанд Швейцарийн хөгжлийн агентлаг ба АМГТХЭГ төслийн үйл ажиллагааны зардлыг хуваан хариуцах болно. Хамтрагч талуудыг харилцан тэгш оролцоотой байх зарчмыг баримтлана.

**Уян хатан байх:** төсөл нь өөрийн дизайн бүтэц, хамтын ажиллагааны хэлбэр, ажиллах арга барилын хувьд уян хатан байж, харилцагч хамтрагч талуудад өөрсдийн хэрэгцээ, боломждоо нийцүүлэн туршилт явуулах, суралцах боломж олгоно. Төсөл жилийн үйл ажиллагааны төлөвлөлтөө хийхдээ харилцагч хамтрагч талуудаас гарсан санал зөвлөмжүүдэд үндэслэн тусгаж байх болно. Энэ салбарт хамаарагдах талуудыг төслийн үйл ажиллагаанд оролцуулан тэдэнтэй хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх болно. Иймээс төслийн энэхүү баримт бичигт тусгасан үйл ажиллагаануудыг цаашид төслийн хэрэгжилтийн явцад улам боловсронгуй болгож өөрчлөлт оруулж болно.

**Харилцаа холбоо:** төсөл хэрэгжүүлэх багийн гишүүд нь хоорондоо нээлттэй харилцаж, хэдийгээр удирдан чиглүүлэх үүрэг хариуцлага, нас хүйс, цалингийн хувьд ялгаатай байгаа ч харилцан бие биенээ хүндэтгэн, итгэлцлийн үндсэн дээр ажил үүргээ гүйцэтгэх болно.

**Хамтын ажиллагаа:** ҮХЯ нь энэ төслийн үйл ажиллагаанд илүү их ач холбогдол өгч хэрэгжилтэнд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд бэлэн байгаа төдийгүй төслийн Удирдах зөвлөлийг удирдах болно. Түүнчлэн АМГТХЭГ-аар дамжуулан тус салбарт донор хандивлагчдыг татан оруулах зохицуулалт хийхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх болно. Түүнчлэн БУД төсөл нь бичил уурхайн салбарт хамтран ажиллах бусад донор хандивлагчидтай харилцаа холбоо сайн тогтоож чадсан бөгөөд цаашид улам бэхжүүлж, үйл ажиллагааг хамтран санхүүжүүлэх, мэдээлэл, туршлагаасаа хуваалцах болно.

## *2.9 Үйл ажиллагааны газар зүйн хамрах*

Бичил уурхайн тухай хууль ба түүний эрх зүйн зохицуулалтын орчин нь Монгол улсын хэмжээнд хэрэглэгдэх болно. Швейцарийн хөгжлийн агентлаг нь АМГТХЭГ-тай төслийг хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд тус улсын хэрэгцээ, хүсэлт шаардлагад нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ төслийн цаашдын шатанд шинэ техник технологийг турших хэрэглэх нарийвчилсан үнэлгээ хийх газраар өмнө нь сонгогдсон Баянхонгор аймаг хэвээр үлдэх болно.

Үр дүнгийн индикатор/үзүүлэлтүүдийг тогтоох үүднээс Баянхонгор аймгийн хоёр алтны орд дээр суурь судалгааг явуулсан бөгөөд цаашид төслийн үр дүнг үнэлэх оролцооны

мониторингийн үр дүнгүүдтэй харьцуулахад ашиглах болно. Бичил уурхайн дэд салбарт ололт амжилт, дэвшилтэт аргууд, технологи, сургамжуудаас шаардлагатай газруудад дэлгэрүүлж ажиллах болно. Төсөл дууссаны дараа АМГТХЭГ үйл ажиллагааг бие даан үргэлжлүүлэх тул төсөл хэрэгжих явцад төслийн зүгээс оролцох оролцоог зохицуулахад анхаарах болно.
Түүнчлэн төсөл нь бичил уурхай эрхлэлт нэлээд төвлөрсөн газруудад байгуулсан АМГТХЭГ-ын бүсийн төлөөлөгчийн газар (одоогоор Заамар, Баянхонгор аймагт тус тус байгуулагдсан)-ыг дэмжиж ажиллах болно.

## *2.10 Хөтөлбөр хэрэгжих хугацаа ба үе шат*

Төслийн дараагийн шатны үргэлжлэх хугацаа: 4 жил (2007-1 сарын 1-нээс 2010 оны 12 сарын 31)

**Хүснэгт 1: Тогтвортой бичил уурхай төслийн үе шат**

| | Хугацаа | Чухал үечлэл |
|---|---|---|
| **Одоогоор хэрэгжиж буй:** | 2007-2010 | ⇨ Жилийн ажлын төлөвлөгөөнд үндэслэн хэрэгжүүлэх үйл ажиллагаа<br>⇨ Оролцооны аргаар мониторинг ба төлөвлөлтийг явуулах<br>⇨ Жилийн ажлын тайлангуудаар дамжуулан тайлагнах |
| **Хөтөлбөрийн үндсэн шатыг хэрэгжүүлж эхлэх** | 2007 оны эхний хагас | ⇨ Төслийн оффисыг АМГТХЭГ-т шилжүүлж тохижилт хийх<br>⇨ Ажлын загварчлалыг эцэслэн боловсруулах<br>⇨ Хамтрагч байгууллагууд (бусад донор төслүүдийг оролцуулан) ба ажилтнуудтай гэрээ байгуулах<br>⇨ Тендер зарлан мэргэжлийн ТББ-уудыг үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэгчээр сонгох<br>⇨ 2007 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн батлах |
| **Хөтөлбөрийн хэрэгжилт** | 2007 оны сүүлийн хагас | ⇨ Мониторинг ба үнэлгээний удирдамжуудыг боловсруулж төслийн ажиллах дүрэм журмыг бүхэлд нь тогтоох<br>⇨ Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэгийн ээлжит хуралдааныг Монголд хуралдуулах |
| | 2008 оны эхний хагас | ⇨ Бичил уурхайгаар олборлосон ашигт малттмалаар хийсэн үнэт эдлэл, бүтээгдхүүний анхны үзэсгэлэн/шударга худалдааг зохион байгуулах |
| | 2008 оны сүүлийн хагас | ⇨ Төслийн дунд хугацааны хөндлөнгийн үнэлгээ хийлгэх<br>⇨ 2009 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж болох зарим өөрчлөлтүүд |
| | 2010 оны эхний хагас | ⇨ Төслийн хэрэгжилтийн эхний шатны үнэлгээ<br>⇨ Төслийн төгсгөлийн стратегийн төлөвлөлт хийх |
| | 2010 оны сүүлийн хагас | ⇨ Төслийн баримт бичиг ба зээлийн санал<br>⇨ АМГТХЭГ-ийн чадавхийг бий болгож тэдний үйл ажиллагааг төслийн төгсгөлийн шатны үйл ажиллагаатай бүрэн уялдуулах |
| | 2011-2012 | ⇨ Тогтвортой бичил уурхай төслийн төгсгөлийн үе шат<br>⇨ Эцсийн үнэлгээ |

## *2.11 Ерөнхий эрсдлүүд, таамаглал, эрсдлийг бууруулах стратеги*

| Эрсдлүүд | Эрсдлийг бууруулах стратегиуд |
|---|---|

| Эрсдлүүд | Эрсдлийг бууруулах стратегиуд |
|---|---|
| Бичил уурхай эрхлэгчид албан ёсны болохыг хүсэхгүй байж болно. | Бичил уурхай эрхлэгчдийг сум/аймаг орон нутгийн засаг захиргаа, АМГТХЭГ-тай нь холбож тэдний идэвхитэй оролцоо, тодорхой бүтэц зохион байгуулалтыг бий болгож өгөх нь албан бусаар ажиллаж ирсэн тэдний хувьд тустай зүйл байх болно. Гэхдээ тэд баталгаатай найдвартай лизенцитэй болох нь хамгийн чухал асуудал байна. Харин Бичил уурхайн тухай хуулийн төслөөс харахад албан бусаар үйл ажиллагаагаа явуулж буй бичил уурхай эрхлэгчдэд үүнийг нэн даруй хуульчлаад өгнө гэсэн зүйл харагдахгүй байна. |
| Бичил уурхайн үйл ажиллагааг хуульчлахад бичил уурхайн олборлолтонд олгох лизенцигүй талбай нэлээд дутагдалтай байж болно. | Төсөл албан ёсны том компаниуд бичил уурхай эрхлэгчдийн хооронд албан ёсны гэрээ хэлэлцээр хийж тэдний хооронд гардаг зөрчлийг бууруулахад туслах удирдамж гаргана. Перу улсын туршлага (албан ёсны компаниуд ба бичил уурхай эрхлэгчдийн хооронд ашиглалтын гэрээ амжилттай хийж чадсан ба одоогоор ажиллаж буй бичил уурхайн ашиг сонирхлын концессийн гэрээний 95 % орчим нь аль хэдийн гуравдагч талуудтай хийгдсэн байна) –ыг Монгол орны туршлагатай харьцуулж үзэхэд тус оронд бичил уурхай эрхлэгчид нь хүссэн газраа олж авсны дараа тэдэнд албан ёсны статусыг олгох болж байна. Иймээс эдгээр туршлага, жишээнүүдийг сайтар судалж сайн талуудыг нь авч дэлгэрүүлэх нь зүйтэй. |
| Үл ойлголцол, харилцааны буруу хэлбэр нь төслийн үр дүнг бууруулж болно. | Төслийн туршилтын шатны үйл ажиллагаанаас харахад янз бүрийн түвшинд олон талуудтай харилцаж хэрэгжих төслийн хувьд богино хугацаатай тодорхой харилцааны сувгуудыг бий болгох нь илүү үр дүнтэй байна гэж харагдсан. Үүрэг хариуцлага нь тодорхой, ил тод бүтэцтэй байж, харилцааны аргуудад суралцсан байх нь хамгийн чухал гэж үзэж байна. Гарч буй хүндэрлийг төслийн үйл ажиллагааны хороо ба зөвлөхүүдийн тусламжтайгаар зохицуулж, цаашид харилцааны чадавхийг бий болгоход анхаарч ажиллана. |
| Төсөл хэрэгжүүлэх нэгж бичил уурхайн мэдлэг/ноу хоу-аар дутмаг байж болно. | АМГТХЭГ, Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлаг нь хамтран бичил уурхайн дэд салбарт уг төслийг шинээр эхлэн хэрэгжүүлж байгаа болохоор бичил уурхайн шинэ мэдлэг/ноу хоу дутагдалтай. Иймээс төсөл нь гол асуудлаар үндэсний ба олон улсын зөвлөхүүд, бусад холбогдох төсөл хөтөлбөр, мэргэжилтнүүдтэй холбоо тогтоон тэдний дэмжлэг туслалцааг авах ажлыг зохицуулна. |
| Төр засгийн газар өөрчлөгдөх нь улс төрийн харилцааг өөрчилж улмаар бичил уурхайн салбарт баримтлаж буй бодлогыг өөрчилж болох талтай. | Хэдийгээр АМГТХЭГ-тай хамтран ажиллаж байгаа ч төсөл нь засгийн газраас ангид тусдаа байна. Улс төрийн холбоо харилцааг бий болгох нь чухал бөгөөд төсөл нь ил тод, хариуцлагатай байж харин ямар нэг улс төрийн намын харьяалалд орохгүйгээр үйл ажиллагаагаа явуулах болно. Орон нутагт бичил уурхай эрхлэгчдийн анхан шатны сүлжээг бий болгох нь тэднийг улс төрөөс хамааралгүйгээр өөрийн дуу хоолойгоо гаргадаг болоход тустай байх болно. |

| Эрсдлүүд | Эрсдлийг бууруулах стратегиуд |
|---|---|
| Бичил уурхайн тухай хуулийг батлах, эрх зүйн орчинг тогтоох явц удааширч бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсны болгох, хуульчлах ажил хойшлогдож болно. | Төсөл мэдээж бичил уурхайн техникийн, нийгмийн, байгаль орчны, бүтэц зохион байгуулалтын асуудлыг хуульчилж зохицуулахыг шаардахгүй. Одоогоор Бичил уурхайн тухай хууль батлагдаж гараагүй байгаа ч гэсэн төсөл нь үндэсний ба аймаг орон нутгийн хэмжээнд төр засгийн газруудтай хамтран ажиллах дэмжлэгийг олж, туршилтын журмаар үйл ажиллагаагаа явуулах боломжтой болсон.<br>Төсөл нь тус оронд тогтвортой, зөрчлөөс ангид бичил уурхайг хөгжүүлэх арга зам, мэдлэгийг бий болгоход туслах болно. |
| Төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрийг удирдан ажиллах чадварлаг ажилтнуудыг авч ажилуулахад хүндрэл гарч болно. | Төслийн багт орон ажиллаж буй АМГТХЭГ-ын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэхэд төсөл дэмжлэг туслалцаа үзүүлнэ. Төсөл нь өөрийн багт ажиллаж буй ажилтнууд (АМГТХЭГ ба Швейцарийн хөгжлийн агентлагийн)-ын хооронд хамтран ажиллах боломжийг бий болгож ажилтнуудыг системтэй сургах бэлтгэхэд гол анхаарлаа хандуулна. |
| Засгийн газрын мэдээлэлд үндэслэсэн ашигт малтмалын нөөцийн менежментийн эдийн засгийн төлөвлөлтийн концепци бичил уурхайн салбарт нийцэхгүй байж болно. | Дэлхий нийтийн туршлагаас харахад бичил уурхай эрхлэгчид нь хамгийн хямд өртөгтэй геологичид гэдэг нь нотлогдсон. Төсөл нь нэг талаас бичил уурхай эрхлэгчид газар (орд бүхий) хуваарилах явдлыг хэрхэн дэмжиж хүлээж авч байгаа байдал нөгөө талаас бичил уурхайн салбар хэрхэн хөгжиж байна гэдэгт мониторинг хийх болно. Монгол улсын уул уурхайн салбарын удирдлага захиргаанд бичил уурхайн салбартай холбоотой гарч болох санхүүгийн эрсдлээс сэргийлэх үүднээс үр ашигтай нарийн мэдрэмж бүхий мониторингийн тогтолцоог бий болгох болно. |
| Алт худалдаж авах хар захын үнэ өндөр байх нь алтны албан ёсны зах зээл бий болгоход саад болж болно. | Төсөл нь орон нутаг, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд уул уурхайн үйл ажиллагааны эдийн засгийн нөлөөг сайжруулахад тусламж дэмжлэг үзүүлэх болно. Бичил уурхайн макро эдийн засгийн ашгийг нэмэгдүүлэх үүднээс бичил уурхай эрхлэгчдээс алт худалдан авах албан ёсны зах зээл, өрсөлдөөнийг бий болгохдоо тэдний ашгийн татварын хагасыг нь чөлөөлөх харин томоохон хэсгийг тус улсын худалдааны албан ёсны тогтолцоогоор авдаг болох гэдгийг төр засгийн газарт санал болгож болох юм. |
| Олон улсын зөвлөгөөг орон нутгийн харилцагч талууд хүлээж авахгүй дэмжихгүй байж болно. | Олон улсын зөвлөгөөг хэрэгжүүлж байсан туршлагаас харахад зардал өндөртэй мөн зөвлөх мэргэжилтэн, тухайн орон нутгийн нөхцөл байдлын хооронд асар их зөрүү байгаагаас орон нутгийн нөөц боломж, мэдлэг туршлагыг авч үзэхгүй өнгөрөөж болно. Иймээс төсөл тодорхой шийдэлд хүрэхийн тулд дотооддоо чадавхийг бий болгоход гол анхаарлаа хандуулах болно. Өмнөд-өмнөдийн хөгжиж буй орнуудтай туршлагаа харилцан солилцох нь энэхүү зөрүүг арилгах, шинэ мэдлэгийг нэвтрүүлэхэд туслах болно. |

# 3 Төслийн бүтэц зохион байгуулалт ба менежмент




**Зураг 2: Тогтвортой бичил уурхай төслийг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалт**

## *3.1 Гэрээ хэлэлцээр*

Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлаг нь ҮХЯ ба АМГТХЭГ-тай төслийн эхний ба туршилтын шатыг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан бөгөөд цаашид төслийн үндсэн шатыг хэрэгжүүлэхэд гэрээг шинэчлэн хийх болно. Иймээс ҮХЯ-ны Зээл тусламжийн бодлого зохицуулалтын хэлтэс ба Швейцарийн хөгжлийн агентлаг Монгол, Швейцари улсын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийн хүрээнд төслийн үндсэн шатны үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурах болно. Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлаг нь төслийн Зохицуулагчийг авч ажиллуулна. Зохицуулагч нь Швейцарийн хөгжлийн агентлагийн Монгол дахь салбарын захирал ба түүний томилсон төлөөллийн удирдлага дор ажиллана.
Швейцарийн хөгжлийн агентлагийн төв удирдах газар төсөлд гэрээгээр ажиллуулах олон улсын зөвлөхүүдийг хариуцах болно.

## *3.2 Төслийн менежмент*

Төслийн менежментийн хувьд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхой зааж, шийдвэр гаргах, мониторинг хийх явцыг ил тод болгох нь гол үндэс байна. Төслийн үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх, төслийн багийг бэхжүүлэх нь чадавхийг нэмэгдүүлэх ажлын нэг хэсэг байх болно. Улс орон, ард иргэдийг өөртөө итгэлтэй болоход бүхий л түвшинд ба төслийн үйл ажиллагааны чиглэл (стратегийн, удирдлагын, техникийн санхүүгийн гм)-ээр чадавхийг бий болгох нь хамгийн чухал юм. Монгол дахь

Швейцарийн хөгжлийн агентлагийн Ёс зүйн дүрмийг дагах болно. Нэг талаас хүний нөөцийг хөгжүүлэх, үүрэг хариуцлага ба чадварыг зөв хуваарилах, нөгөө талаас хүчтэй хяналт мониторингийн механизмуудыг бий болгох нь төслийн багийн гишүүн бүрийг харилцан бие биенээсээ болон ажлын байранд суралцах боломж олгоно. Чадавхи бий болгоход туслах үүднээс Швейцарийн хөгжлийн агентлаг ба АМГТХЭГ төслийн багийг бүрдүүлэн ажилтнуудыг харилцан суралцах боломж бүрдүүлж байна.

**Тогтвортой бичил уурхай төсөл хэрэгжүүлэх нэгж**ийг төслийн Үйл ажиллагааны хорооны удирдлага дор төслийн Зохицуулагч удирдаж захиргааны ажилтны тусламжтайгаар төслийн захиргаа ба Бүрэлдэхүүн хэсгүүдийг удирдлагаар хангана. Туслах ажилтанд нягтлан бодогч, бэлэн мөнгөний ажилтан, орчуулагч/хэлмэрч, компьютер дотоод сүлжээний ажилтан, мэдээлэл харилцааны ажилтан, оффис менежмент ба бусад шаардлагатай үйлчилгээний ажилтнууд орно. **Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд гаргасан** 4 **бүрэлдэхүүн хэсэг (Зураг 2-т үзүүлсэн C1-C4)** нь тус бүрдээ багийн ахлагчтай байх бөгөөд бүрэлдэхүүн бүрийн дор хүлээгдэж буй үр дүнд хүрэхийн тулд эдгээр ахлагчид нь төслийн энэ шатанд төлөвлөсөн үйл ажиллагаа, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг тухайн хуваарилсан төсөв хөрөнгийн хэмжээнд хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллана. Түүнчлэн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой төслийн баг болон хамтрагч талуудын хооронд харилцаа холбоо, зохицуулалт хийхэд гол тэргүүлэх үүрэгтэй байна. Түүнчлэн орон нутаг дахь төлөөлөгчийн газрууд нь төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтцийн нэг хэсэг байх болно. Ер нь төсөл сум, орон нутагт байгаа одоогийн бүтэц (засаг захиргааны ажилтнууд, бичил уурхай эрхлэгчид)-д түшиглэж ажиллах ёстой. Хямд, энгийн бүтэц гэдэг нь бүтэц зохион байгуулалт, санхүүгийн хувьд тогтортой байх гэсэн үг юм. Төслийн менежментийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг хавсралт (Хавсралт 10.1) –д үзүүлсэн. Төслөөс гарах үр дүн, жилийн ажлын төлөвлөгөөнд үндэслэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг төслийн Зохицуулагч удирдан зохион байгуулна.

Сэдэвчилсэн ажлын хэсгүүдийг байгуулж багийн ахлагчдын чадавхийг бий болгох практик сургалтуудыг явуулахад туслах болно. Эдгээр сургалтуудад дараахи асуудлуудыг оруулах хэрэгтэй. Үүнд:

- Төлөвлөлт ба хэрэгжилтийн асуудлууд
- Санхүүгийн менежмент ба төсөв
- Хэрэгжүүлэгч талууд (их сургуулиуд, судалгааны байгууллагууд гм)-тай хамтран ажиллах, зохицуулалт хийх
- Донор ба бусад төслүүдтэй хамтран ажиллах зохицуулалт
- Тайлагнах, мониторинг ба үнэлгээ хийх
- Ажилтнууд ба бүс нутгийн төлөөлөгчдийн газрыг удирдан ажиллуулах

Ингэснээр багийн ахлагчид болон бусад ажилтнуудын төлөвлөлт, зохицуулалт, үйл ажиллагааны харилцан уялдаа бий болгох, хэрэгжилтэнд хяналт тавих, хамтрагч талуудыг сургах, тэдний үйл ажиллагаа баримталж буй бодлогыг төсөл ба АМГТХЭГ-ын бодлого үйл ажиллагаатай харилцан уялдуулахад гол үүрэгтэй ажиллах болно. Швейцарийн хөгжлийн агентлаг, АМГТХЭГ, зөвлөхүүд нь Тогтвортой бичил уурхай төслийн хамт олон түүний хамтрагч талуудыг чадавхижуулахад шаардлагатай сургалтуудыг явуулж үйл ажиллагаанд хяналт тавих хэрэгтэй.

**Төслийн Удирдах зөвлөл** төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ерөнхий удирдлагаар хангаж, зөвлөмж өгнө. Тус зөвлөлийг ҮХЯ удирдаж, бичил уурхайн салбарыг хөгжүүлэхэд оруулж буй үндэсний ба олон улсын үйл ажиллагаа хүчин чармайлтыг зохицуулна. Удирдах зөвлөлийн төлөөлөлд уул уурхайн бодлогын асуудал хариуцсан Засгийн газрын ажилтан (ҮХЯ-ны орлогч сайд), АМГТХЭГ (Агентлагийн дарга), Швейцарийн хөгжлийн агентлаг (Монгол дахь салбарын захирал), бичил уурхай эрхлэгчид, иргэний нийгмийн төлөөлөл болон БОЯ, НХХЯ, УМХГ-ын төлөөлөл тус тус орж жилд 2 удаа хуралдаж байх болно. Төслийн

Зохицуулагч ба бусад уригдан орж буй ажилтнууд нь ex officio. Удирдах зөвлөл нь дараахи үүрэгтэй ажиллах болно. Үүнд:

- Ерөнхий удирдлагаар хангаж стратегийн ач холбогдолтой шийдвэр гаргах (бодлогын чанартай, менежмент, зохицуулалттай холбоотой асуудлаар)
- Хөтөлбөрийн баримт бичигт заасны дагуу Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хянаж үзэн батлах
- Үйл ажиллагааны жилийн тайлангуудад үнэлэлт өгч батлах, шаардлагатай үед ерөнхий чиглэл удирдамж өгөх,
- Монголын засгийн газар ба Швейцари улс дахь Швейцарийн хөгжлийн агентлагт санал дүгнэлтээ ирүүлэх
- Үйл ажиллагааны явцад хяналт тавьж шаардлагатай зөвлөмжүүдийг өгөх
- Харилцагч хамтрагч талуудын дэмжлэг туслалцаа (санхүүжилт нөөц)-г төвлөрүүлэх
- Бусад донор хандивлагчид ба засгийн газрын хөтөлбөр, төлөвлөгөөнүүдтэй уялдуулах зохицуулалт хийх
- Зөрчлийг зохицуулах
- Үйл ажиллагаанд гадаад хяналт тавьж, гарсан үр дүнгүүдэд үнэлэлт дүгнэлт өгөх

**Төслийн Үйл ажиллагааны зөвлөл** нь төслийн Удирдах зөвлөлийн удирдлага дор ажиллах бөгөөд төслийн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах үүрэг хүлээнэ. Тус зөвлөлд АМГТХЭГ (төслийн Үндэсний захирал), Швейцарийн хөгжлийн агентлаг (Хөтөлбөрийн үндэсний ажилтан), төсөл хэрэгжүүлэх нэгж (төслийн Үндэсний Зохицуулагч, Багийн ахлагчид)-ийн төлөөлөл тус тус орж 14 хоногт нэг удаа хуралдаж байх болно.

Монгол улсад бичил уурхайн салбар сүүлийн хэдэн жилд үүсч, эрчимтэй хөгжиж байгаа ч гэсэн бичил уурхайн асуудлаар олон улсын сүлжээнд оролцох, шинэ мэдлэг/ноу хоу, техник технологи нэвтрүүлэх талаар ойлголт туршлага бага байгаа тул олон улсын зөвлөхүүдийг ажиллуулах нь чухал. Зөвлөхүүд нь бичил уурхайтай холбоотой мэргэжлийн зөвлөгөө, сургалт явуулж, чадавхийг бий болгох, технологи, шинэ мэдлэг /ноу хоу нэвтрүүлэх, төлөвлөлт хийх, тайлагнах, үнэлгээ өгөх, санхүүгийн эх үүсвэр бий болгоход дэмжлэг тусламж үзүүлэх үүрэгтэй ажиллана. Олон улсын зөвлөхүүд нь юуны өмнө бичил уурхайн олон улсын төслүүдийн туршлага, шинэ мэдлэгийг дэлгэрүүлэх, тоног төхөөрөмжийг сайжруулах, сургамжууд, байгаль орчин хүний эрүүл мэндэд учирдаг эрсдэл, хор нөлөөг бууруулах арга замуудыг суралцахад төсөлд туслах болно.

**Зохицуулах зөвлөл** нь Нэгдсэн үндэстний байгууллага, Дэлхийн банк, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, БНХГУ-ын Гео-шинжлэх ухаан, эрдэс баялагийн хүрээлэн, зэрэг донор хандивлагч олон улсын байгууллагууд болон Уул уурхайн аврах алба зэрэг үндэсний хамтрагч тал, судалгааны байгууллагууд, ТББ-ууд, Швейцарийн хөгжлийн агентлагийн бусад төслүүдийн үйл ажиллагааг хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулж, харилцан мэдээлэл солилцож хамтын ажиллагааг бий болгох нөхцөл бүрдүүлэхэд чиглэнэ.

**Зөвлөх баг** нь шаардлагатай үед байгуулагдан тодорхой асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллана.

### *3.2.1 Төслийн төгсгөлийн стратеги*

Тогтвортой бичил уурхай төсөл нь бичил уурхай эрхлэгчид ба хөдөөгийн иргэдэд туслах, ашиг тусаа хүртээх зорилготой. Төслийн төгсгөлийн стратеги бол төслийн бүрэлдэхүүн 4 хэсэг болон төслийн ерөнхий менежментийн хувьд ялгаатай байна.

**Менежмент:** төслийн төгсгөлийн стратеги нь үндсэндээ бичил уурхайн салбарын менежментийг АМГТХЭГ-ын Бичил уурхайн нэгжид шилжүүлэхэд чиглэсэн стратегийг хэлж байгаа юм. Төсөл хэрэгжиж дуусах үед Бичил уурхайн нэгж нь АМГТХЭГ-ын үйл ажиллагааны хүрээнд бичил уурхайн асуудлыг бүрэн хариуцан зохицуулж, харилцагч хамтрагч талуудын ажлыг уялдуулж, асуудлыг шийдвэрлэж чаддаг болсон чадварлаг салбар хэлтсийн нэг болсон байна. Бичил уурхайн нэгж нь орон нутгийн засаг захиргаадтай стратегийн ба үйл ажиллагааны асуудлыг хэлэлцэж, хамтран ажилладаг байх нь хамгийн чухал байна.

Төслийн эхний ба туршилтын шатанд гол харилцагч хамтрагч талуудыг тогтоон гэрээ хэлэлцээр хийж байсан бол төслийн төгсгөлийн стратегид төслийн менежментийг үндэсний оролцоотой, илүү тогтвортой явуулахад чиглэх болно. Эхний удаад хийгдэх алхам бол төслийн менежментийг хэрэгжүүлэгч Проект консалт компаниас төсөл хэрэгжүүлэгч үндэсний нэгжид шилжүүлэх болно. Түүнчлэн төслийн үндсэн шатанд Швейцарийн хөгжлийн агентлагийн удирдлага дор ажиллаж буй төслийн Зохицуулагчийн үүрэг аажимдаа буурч АМГТХЭГ-ын Бичил уурхайн нэгжийн удирдлага буюу тус агентлагаас томилогдон ажиллаж буй төслийн Дэд зохицуулагчийн үүрэг, хариуцлага нэмэгдэхийн хэрээр Бичил уурхайн нэгжийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага ч өргөжих болно. Үүний зорилго нь төслийн үндсэн шат дуусах үед төслийн үйл ажиллагааны менежмент Бичил уурхайн нэгжийн удирдлагад шилжиж төслийн төгсгөлийн шат (2 жил)-ны үйл ажиллагааг удирдан ажиллах болно. Энэ шатанд төслийн Зохицуулагч төслийн Дэд Зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх болно.

**Бүрэлдхүүн хэсэг 1**: төсөл дуусах үед бичил уурхайн хуулийн орчин бүрэн бүрдсэн байна. Тодорхой баримтаар нотлогдсон туршлагууд, сургамж, мэдлэгийн менежментээс суралцан дэлгэрүүлэх нь хөтөлбөрийг төслийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй уялдуулах боломж олгоно. АМГТХЭГ ба Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний зөвлөл нь цаашид хууль эрх зүйн хэрэгжилтэнд хяналт мониторинг тавьдаг болно.

**Бүрэлдхүүн хэсэг 2**: эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлэх ажлууд үргэлжлэн хийгдэх болно. Энэ үйл явцад голлох үүрэгтэй оролцох талууд бол Бичил уурхай эрхэгчдийн үндэсний зөвлөл ба АМГТХЭГ байх болно. Монголын бичил уурхай эрхлэгчид нь олон улсын бичил уурхайн сүлжээтэй холбоо харилцаа тогтоож шинэ мэдлэг, мэргэжлийн зөвлөгөө авч чаддаг болсон байна.

**Бүрэлдхүүн хэсэг 3**: Төсөл нь төслийн үр дүнгүүдийг хангахын тулд ТББ-ууд, үндэсний ба олон улсын мэргэжилтэн зөвлөхүүдтэй хамтран ажиллах болно. Төсөл нь гол зохицуулагчийн үүрэгтэй оролцохоос гадна олон улсын зөвлөх мэргэжилтнүүдийг авч ажиллуулах боломжгүй тохиолдолд дотоодын үндэсний мэргэжилтэн, байгууллагууд, ялангуяа бичил уурхай эрхлэгчид ба ТББ-ууд, техникийн их сургуулийн хэмжээнд чадавхийг бий болгоход гол анхаарлаа хандуулах болно. Эдгээр байгууллагууд нь бичил уурхайн техник технологийн асуудалд шинэлэг санааг дэвшүүлж, хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн тусламж дэмжлэгийг үзүүлдэг болно.

**Бүрэлдхүүн хэсэг 4**: Зөрчлийг зохицуулах сургалтыг холбогдох талууд болон хүмүүсийг оролцуулан явуулж асуудлаа шийдвэрлэх чадвартай, туршлагатай болоход чиглэнэ. Төсөл нь зөрчлийн асуудлыг зохицуулагч хүмүүсийг сонгох, нутгийн иргэдийн хөгжлийг дэмжих, хяналт явуулах зорилгоор төрийн бус ба олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллана. Эдгээр ТББ-ууд болон мэргэжлийн олон нийтийн байгууллагууд нь төсөл дууссаны дараа ч мэргэжлийн тусламж дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг байх болно.

**Стратегийн хамтын ажиллагаа ба түншлэл:** төсөл нь бусад доноруудын хэрэгжүүлж буй төслүүдийг оролцуулан үндэсний ба орон нутгийн түвшинд албан ба албан бус байгууллагуудын хамтын ажиллагаа ба түншлэлийг бий болгоход чухал

үүрэгтэй ажиллана. Төслийн хүрээнд хийгдэх туршилтын бүх ажиллагааг холбогдох талууд ялангуяа бичил уурхай эрхлэгчдийн оролцоотой хэрэгжүүлж байх болно. Төслийн үйл ажиллагааны явцад бий болсон мэдлэг, чадавхи нь цаашид бичил уурхайн салбарыг амжилттай хөгжүүлэх, шинээр туршилтууд хийхэд практик зөвлөмжийг гаргахад тустай бөгөөд энэ бүгдийг Монголчууд өөрсдөө хийдэг болно. Сургалтанд юуны өмнө бусдыг сургах чадвартай сургагч нар, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд, төслийн гол ашиг хүртэгч бичил уурхай эрхлэгчдийг хамруулах болно. Ингэснээр үр дүнд хүрнэ.

# 4 Мониторинг ба үнэлгээ

Төслийн үндсэн шатны үйл ажиллагаа нь тогтвортой уул уурхайг хөгжүүлэх, гарч буй сөрөг нөлөөллийг бууруулахад хувь нэмэр оруулахад чиглэнэ. Энэ нь байнгын мониторинг ба үнэлгээ явуулж байхыг шаардана. Төслийн эхний шатны дунд үед хийгдсэн үнэлгээ (Echavarrha and Klду 2006)-ний зөвлөмжийн дагуу төсөл нөлөөлөл/үр дүнгийн оролцооны мониторингийн тогтолцоо (жишээ нь: Germann and Gohl 1996))-г бий болгож мөрдөх болсон. Үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, мониторинг явуулахдаа юуны өмнө төсөл шууд хамтран ажилладаг хувь хүмүүс, бүлэг ба байгууллагуудыг өөрсдийн үйл ажиллагаагаа өөрсдөө зохион байгуулдаг болохоос эхлэх хэрэгтэй. Энэ нь мэдээж маш том боломж байх болно. Эхэндээ ахиц дэвшил удаан байж, эрсдэл ч гарч болно. Гэхдээ өөрсдийн хийж буй зүйлээсээ суралцах боломж өндөр байж, цаашид (дунд ба урт хугацаанд) гарах үр дүнгүүд нь илүү сайн байх болно.

Оролцооны аргаар хийгдэж буй хяналт(мониторинг)-ыг төлөвлөгөөт үйл ажиллагааны нэг хэсэг болгон авч үзэж төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зохион байгуулалтын дор гол төлөв төслийн ашиг хүртэгчид гүйцэтгэх болно. Хяналт (мониторинг) хийхдээ Швейцарийн хөгжлийн агентлаг ба АМГТХЭГ-ын цөөн хэдэн гол чухал үзүүлэлтүүдийг авч үзэх хэрэгтэй. Ялангуяа хөгжлийн зорилго (жишээ нь ажлын байр, орлого бий болгох, ядуурлыг бууруулах, амьжиргааг дээшлүүлэх)-д шууд бус нөлөө үзүүлдэг бүрэлдэхүүн хэсгүүдэд бүр эхнээс нь тодорхой тохиролцсон үзүүлэлтүүд болон, мэдээлэл хэрхэн цуглуулах талаар батласан аргачлал (ярилцлага хийх, бүлгээр нь ярилцлага хийх, судалгаа явуулах, санаандгүй байдлаар лавлагаа авах гм)–ыг бий болгох хэрэгтэй. Төсөлд өөрчилж болохуйц үзүүлэлтүүдийн багцыг өгсөн. Түүнчлэн Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлаг өөрийн хөтөлбөрүүдэд тогтоосон стандартууд ба тухайн хөтөлбөрийн баримт бичгийн дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжид мониторинг явуулах болно. Төслийн Удирдах зөвлөл нь хөтөлбөрөөс гарах үр дүнгүүдтэй харьцуулан хэрэгжилтэнд мониторинг хийх болно. Шаардлагатай бол зохицуулалт хийхийг шаардана.
Мониторинг хийхдээ тухайлбал аюулгүй ажиллагааны стандарт, алт барих хэмжээ, бохирдлын хэмжээ зэрэг техникийн үзүүлэлтүүдийг ашиглаж, бичил уурхай эрхлэгчдэд чиглэсэн практик зөвлөмжүүдийг гаргахад хэрэглэнэ. Эдгээр техник үзүүлэлтүүдэд мэргэжлийн байгууллагуудаар хяналт хийлгэх болно. Хууль эрх зүйн өнөөгийн байдалд төсөл хэрэгжүүлэх нэгж ба холбогдох бусад талууд хяналт тавих болно.

Швейцарийн хөгжлийн агентлаг нь донор байгууллагынхаа хувьд төсөл хэрэгжүүлэгч нэгж ба үйлчилгээ үзүүлэгчид (арилжааны чиглэлийн), төслөөс ашиг хүртэгчдийн хувьд бүр ач холбогдолгүй мэдээ мэдээлэл цуглуулах хэрэгцээ гарч болно. Харин хөтөлбөрт оролцогч талуудыг өөрсдийн үйл ажиллагаанд төдийлөн хамаатай бус өндөр зардалтай мэдээ мэдээлэл цуглуулах ажилд оролцуулах нь нийцэхгүй асуудал юм. Иймээс нийгмийн холбогдолтой асуудлын үзүүлэлтүүдийг тогтоох ажил хөгжлийн хөтөлбөрийн зорилго байх бөгөөд үүнтэй холбоотой гарах зардлыг тухайн донор байгууллага хариуцах болно.

2007 оны эхний хагаст мониторинг ба үнэлгээний ажлын удирдамж (гүйцэтгэгчийн ажил үүргийн хуваарийг оролцуулан)-ийг боловсруулж гаргах болно. Энэ нь үнэлгээний ажлыг ил тод, тодорхой болгох, харилцагч хамтрагч талууд гүйцэтгэх ажил, үр дүнг харилцан зөвшөөрсөн байх болно. Баянхонгор аймагт явуулсан нийгэм эдийн засгийн

үзүүлэлтийн суурь судалгааны үзүүлэлтүүд, байгаль орчны асуудлууд нь гол түлхүүр үзүүлэлтүүдийг тогтооход үндэслэл болно.

Төслийн дотоод хяналтыг 2008 онд явуулж 2009-2010 онуудын Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгаж оруулах төслийн дунд хугацааны үйл ажиллагааг тодорхойлох болно. 2010 оны эхний хагаст төслийн гадаад үнэлгээг төслийн Удирдах зөвлөл хийж хөтөлбөрийн хэрэгжилтэнд гарсан үр дүнг үнэлж төслийн төгсгөлийн шатны үйл ажиллагааны удирдамж гаргах болно. Үнэлгээний багт Удирдах зөвлөлийн төлөөлөл, Швейцарийн хөгжлийн агентлагийн төв удирдах газрын (жишээ нь тодорхой салбараас) төлөөлөл, Хариуцлагатай бичил уурхайн холбооны бичил уурхайн салбарын мэргэжилтэн эсвэл Швейцарийн хөгжлийн агентлагаас бусад оронд хэрэгжүүлж буй төслийн төлөөлөл орно. Багийн гишүүд нь Монголчууд болон гадаадын эрэгтэй, эмэгтэй хүмүүс байна.

### *4.1.1 Хөтөлбөрийн үйл ажиллагаанд мониторинг хийх шалгуурууд*

**Нийгмийн асуудал:** бичил уурхайд хууль эрх зүй зохицуулалтын орчинг бүрдүүлж, бүтэц зохион байгуулалтыг бий болгох нь бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааг дээшлүүлэх, ялангуяа тэдний үйл ажиллагаатай холбоотой гардаг зөрчлийг бууруулах, хүний эрх, жендерийн асуудал, тэгш байдал, нийгмийн үйлчилгээнд хамрагдах, аюулгүй ажиллагааг хангах боломжийг сайжруулах болно.

**Эдийн засгийн асуудал:** техник технологийг сайжруулах, орлогын олон талт хэлбэрүүдийг бий болгох нь бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааг дээшлүүлэх болно. Бичил уурхай эрхлэгчдийн санхүүгийн ба бизнесийн эрхлэх чадвар сайжрах болно.

**Тодорхой дэд бүтцийг бий болгох:** хөтөлбөр нь бичил уурхайн хүрээнд бага зэргийн тодорхой дэд бүтцийг бий болгох болно. Төслийн ашиг хүртэгчдэд тухайлбал уурхайн малталт хийх, алт барилт (жишээ нь тээрэм, реторт гм) зэрэг технологийн асуудлаар дэмжлэг туслалцаа үзүүлэх болно. Эдгээр нь “төслийн хөшөөг бий болгож” байгаа бус харин үр ашиг, үр дүн, аюулгүй ажиллагаа зэрэг асуудлуудын загвар байх болно.

**Чадваржуулах асуудал:** хууль эрх зүйн зохицуулалтын орчин, шинэ мэдлэг/ноу хоу бий болгосноор бичил уурхай эрхлэгчид нь өөрсдөө илүү итгэлтэй болно. Тэд өөрсдийн хэрэгцээ шаардлагаа илүү мэдэрч орон нутгийн холбоо, Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний зөвлөлөөр дамжуулан өөрсдийн хүсэл зорилгоо илэрхийлдэг болно. Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон ашигт малтмалаар үнэт эдлэл хийж, тусгайлан шошготойгоор яармаг худалдаа гаргах нь тэдний хувьд төдийгүй үндэсний бахархал байх болно. .
АМГТХЭГ-ын ажилтнууд ялангуяа Бичил уурхайн нэгжийн ажилтнуудын зохион байгуулах, бусдыг удирдан чиглүүлэх чадвар, мэргэжлийн ур чадвар сайжирснаар төслийн төгсгөлийн шатыг гадны зөвлөхийн тусламжтайгаар хэрэгжүүлэх чадвартай болно.
Төсөл хэрэгжүүлэхэд үндэсний оролцоо хариуцлагыг бий болгож төсөл хэрэгжүүлэх нэгж төслийн үр дүнгийн талаар тодорхой амжилтанд хүрсэн байна. Төсөл хэрэгжилтийн явцад бүхий л шатанд сайн засаглалын зарчмууд, Ёс суртахууны уриалгыг мөрдөж, ялангуяа залуучуудыг илүү дэмжих болно.

**Байгаль орчин:** Монгол орны хөрс, ургамал, амьтан эмзэг. Хөтөлбөр нь байгаль орчны доройтол үүсгэх арга техник хэрэглэхгүйгээр байгаль орчин, хөрс, ургамал, амьтанд үзүүлж буй нөлөөллийн байдалд хяналт тавих болно. Монгол орон байгаль орчны үнэлгээ хийх талаар хязгаарлагдмал бөгөөд энэ чиглэлээр ажилтнуудаа сургалтанд хамруулах шаардлагатай байгаа тул БОЯ сургалт явуулж өгөхийг Швейцарийн хөгжлийн агентлагаас хүссэн. Иймд тус агентлаг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй цөлжилтийн хөтөлбөрийн хүрээнд энэ сургалт явуулахаар төлөвлөж байна.

**Хууль эрх зүй:** Бичил уурхайн тухай хууль эрх зүй нь ижил тэнцүү, хүрэлцээтэй байж, жендерийн асуудлыг авч үзэн бичил уурхай эрхлэгчид ба холбогдох талуудад тодорхой ашиг хүртээх болно. Хууль эрх зүй, зохицуулалтын талаар сайн ойлголт бий болгож, хэрэгжилт нь үр дүнтэй, шударга байх болно.

**Олон нийтийн мэдээлэл сурталчилгаа:** олон нийт бичил уурхайн талаар тодорхой ойлголттой болж түүний хөдөөгийн тогтвортой хөгжилд гүйцэтгэх үүргийг ойлгох болно.

# 5 Хамтрагч талуудын оруулах хувь нэмэр ба төслийн төсөв хөрөнгө

## *5.1 Үндэсний нөөц ба харилцагч, хамтрагч талуудын оруулах хувь нэмэр*

Төсөл нь бичил уурхайтай холбоотой тухайлбал бичил уурхай эрхлэгчид, холбогдох байгууллагууд, АМГТХЭГ, орон нутгийн засаг захиргаад, холбогдох яамд, их сургуулиуд, хувийн компаниуд, ТББ-ууд, Швейцарийн хөгжлийн агентлаг зэрэг төрөл бүрийн байгууллагуудтай хамтран ажиллах болно.

### *5.1.1 Төрийн байгууллага*

*Хамтрагч төрийн байгууллагууд* (төв, орон нутгийн засаг захиргаад, судалгааны байгууллагууд, их сургуулиуд, хүрээлэнгүүд) нь төсөлтэй байгуулсан гэрээний дагуу хаитран ажиллаж, хүн хүчний тусламж дэмжлэг үзүүлэх болно.

**АМГТХЭГ:** төслийн хамгийн гол зохицуулагчийн үүрэг бүхий хамтрагч байгууллага бөгөөд төслийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцоно. АМГТХЭГ нь төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажлын албан байр, төслийн багт ажиллаж буй өөрийн ажилтнууд болон орон нутагт ажиллаж буй төлөөлөгчдийн цалинг санхүүжүүлж, холбогдох сургалт семинар, зөвлөлгөөн олон улсын хурал зэргийг зохион байгуулахад туслах болно. Төсөлд зөвлөхөөр ажиллах гадаадын мэргэжилтэн (2007-2008)-ийг АМГТХЭГ-т ажиллуулна. Төсөл хэрэгжүүлэх гэрээгээр АМГТХЭГ хөрөнгийн нийлүүлэлт хийхгүй харин төсөлд оруулах хувь нэмэр нь “бэлэн бусаар” хийгдэх учраас энэ нь төслийн төсөв санхүүжилтэнд тусгагдаж ороогүй. Хэдийгээр төсөл ба түүний үйл ажиллагаанд оруулах хувь нэмрийг хатуу тогтоож өгсөн ч санхүүгийн тусламж хувь хэмжээг ҮХЯ-ны жилийн төсөв хуваарилах дүрэм журмын хүрээнд баталж тогтоосон байх хэрэгтэй.

**Уул уурхайн аврах алба ба бусад төрийн байгууллагууд:** Бичил уурхайг дэмжих төслийн эхний шатанд төслийн гол хамтрагчийн нэг байж бичил уурхай эрхлэгчдэд газар дээр нь сургалт, зааварчлага өгч ажилласан. УУАА нь төслийн үйл ажиллагаанд ажилтнуудаа оролцуулна.

**Орон нутгийн засаг захиргаад ба төрийн байгууллагын ажилтнууд:** гол хамтрагч талууд нь газар зохион байгуулагчид, байгаль орчны байцаагчид байна. Төсөл нь эдгээр ажилтнуудыг сургалтанд хамруулна.

### *5.1.2 Хувийн салбар ба иргэний нийгэм*

Төслийн гол ашиг хүртэгчид нь бичил уурхай эрхлэгчид, албан бус хувийн салбарын хүмүүс байна. Эдгээр нь нийгмийн эмзэг бүлэгт ордог болохоор төсөл эдгээр хүмүүсийг бүтэц зохион байгуулалтын хувьд дэмжиж чадавхи эзэмшүүлэхэд анхаарна.. Эдгээр хүмүүст эдийн засгийн ашиг тусыг хүртээхдээ гарах зардлыг хуваана гэдгийг сайн ойлгуулах нь тэднийг бэлэнчлэх, төслийн талаар буруу ойлголт авахаас урьдчилан сэргийлэх болно.

Хариуцлагатай уурхайг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж болох ТББ-ууд (жишээ нь Азийн сан, Иргэний хөдөлгөөнүүд: Эх нутаг усаа хамгаалах эвсэл, Онги голынхон хөдөлгөөн, Хөвсгөл байгаль орчныг хамгаалах хөдөлгөөн зэрэг байгалийн нөөцийн ашиглалтаар орон нутгийн иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлдэг олон нийтийн байгууллагууд), олон

улсын хүмүүнлэгийн тусламжийн байгууллага (ADRA), Нээлттэй нийгэмлэг зэрэг байгууллагууд байна. Эдгээр талуудын оролцоотой Бичил уурхай эрхлэгчдийн холбоо, эсвэл Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний зөвлөлийг байгуулж болно. Иргэний нийгмийн байгууллагууд төслийн бүрэлдэхүүн дөрвөн хэсгийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцох болоцоотой.

### *5.1.3 Швейцарийн хөгжлийн агентлаг ба бусад донорууд*

Швейцари улсаас үзүүлж буй тусламж, дэмжлэг нь төслийн санхүүжилтээр дамжин хүрч байна. Швейцарийн хөгжлийн агентлаг нь төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулан төслийн санхүүжилтийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гаргасан төсөвт үндэслэн хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулж төслийн үйл ажиллагааны болон захиргааны зардалд зарцуулна. Швейцарийн хөгжлийн агентлаг нь төслийн олон улсын зөвлөхүүд авч ажиллуулах зардлыг санхүүжүүлэх болно. Төслийн тодорхой зарим үйл ажиллагааг бусад донор байгууллагуудтай хамтран санхүүжүүлэх асуудлыг хэлэлцэх болно. АМГТХЭГ-тай төсөл хэрэгжүүлэх талаар тохиролцсон хэдий ч хоёр тал төсвийн зарцуулалтын талаар зарим зүйлийг тохиролцох шаардлагатай байгаа.

**Зураг 3: Бичил уурхайн асуудлыг сонирхож буй зарим донор байгууллагуудын тухай товч танилцуулга**




Хөтөлбөрийн зарим үйл ажиллагааг бусад донор байгууллагуудтай зардлаа хуваах санхүүжүүлэх хэлбэрээр хамтран хэрэгжүүлэх болно. Төсөл нь тусламж дэмжлэг үзүүлэх, бэлэн бусаар хувь нэмэр оруулах, шинэ мэдлэг /ноу хоу нэвтрүүлэх зэргээр хамтран ажиллах боломжийг бусад донор байгууллагуудад нээлттэй байлгадаг. Үүний жишээгээр 2006 оны хавар Уул уурхайн үндэсний зөвлөлгөөнийг ОУХБ, ХГУ-ын ГШЭБХ, Дэлхийн банк зэрэг бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Төслийн бүрэлдэхүүн дөрвөн хэсэгтэй холбоотой ерөнхий мэдээлэл солилцох ажил хийгдэж, өөр өөр олон донор байгууллагуудтай хамтран ажиллах тодорхой гэрээнүүдийг хийж байна (Зураг 3).

Гол хамтрагч байгууллагууд бол НҮБ-ын хүн амын сан, ПАСТ ТББ-тай бичил уурхай эрхлэгчид ба эмзэг бүлгийн хүмүүсийн дунд ДОХ бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, ОУХБ-тай хүүхдийн хөдөлмөрийг бууруулах ба аюулгүй ажиллагааны асуудлаар, ХГУ-ын ГШЭБХ-тай олборлолт хийсэн газруудад нөхөн сэргээлт хийх, Монгол улсын техникийн их сургуультай хамтран ажилладаг Мари Ст ба Халифаксийн их сургуультай бичил уурхайн техник технологийг сайжруулах, Азийн сантай Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх асуудлаар тус тус хамтран ажиллах болно.

## *5.2 Хөтөлбөрийн төсөв*

Төслийн туршилтын ба эхний шат (2005–2006)-ны нийт төсөв 1,28 сая швейцари франк байснаас 1,13 швейцари франкийг Швейцарийн хөгжлийн агентлаг, 0,15 сая швейцари франкийг АМГТХЭГ тус тус санхүүжүүлсэн. Швейцарийн хөгжлийн агентлаг нь төсөл (төгсгөлийн шатыг оруулан)-ийг хэрэгжүүлэхэд нийт 8 сая швейцари франк зарцуулахаар төлөвлөсөн.

**Хүснэгт 1: Тогтвортой бичил уурхай төслийн 2007-2010 төсвийн товчоо**

| НИЙТ ТӨСӨВ | 2007 | 2008 | 2009 | 2010 | НИЙТ ТӨСӨВ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | SDC [CHF] | SDC [CHF] | SDC [CHF] | SDC [CHF] | SDC [CHF] | MRPAM [CHF] | TOTAL [CHF] |
| **Бүрэлдхүүн хэсэг 1:** | | | | | | | |
| 1.1 | 27,778 | 5,556 | 55,556 | 11,111 | 100,000 | - | 100,000 |
| 1.2 | 27,778 | 22,222 | 27,778 | 22,222 | 100,000 | - | 100,000 |
| 1.3 | 27,778 | 19,444 | 18,333 | 17,500 | 83,056 | - | 83,056 |
| | 81,000 | 40,833 | 75,742 | 52,395 | 249,970 | 26,895 | 276,866 |
| **Нийт** | 164,333 | 88,056 | 177,408 | 103,229 | **533,026** | **26,895** | **559,921** |
| **Бүрэлдхүүн хэсэг 2:** | | | | | | | |
| 2.1 | 27,778 | 38,889 | 16,667 | 16,667 | 100,000 | - | 100,000 |
| 2.2 | 47,778 | 81,111 | 47,778 | 36,667 | 213,333 | - | 213,333 |
| 2.3 | 75,556 | 20,000 | 17,778 | 26,667 | 140,000 | 13,333 | 153,333 |
| | 90,963 | 78,281 | 95,336 | 82,873 | 347,454 | 23,533 | 370,988 |
| **Total** | 242,074 | 218,281 | 177,559 | 162,873 | **800,788** | **36,867** | **837,654** |
| **Бүрэлдхүүн хэсэг 3:** | | | | | | | |
| 3.1 | 27,778 | 53,333 | 33,333 | 33,333 | 147,778 | - | 147,778 |
| 3.2 | 22,222 | 44,444 | 22,222 | 22,222 | 111,111 | - | 111,111 |
| 3.3 | 38,889 | 44,444 | 50,000 | 61,111 | 194,444 | - | 194,444 |
| 3.4 | 16,667 | 16,667 | 16,667 | 16,667 | 66,667 | - | 66,667 |
| | 61,333 | 63,467 | 99,040 | 79,170 | 303,010 | 90,200 | 393,210 |
| **Нийт** | 166,889 | 222,356 | 221,262 | 212,503 | **823,010** | **90,200** | **913,210** |
| **Бүрэлдхүүн хэсэг 4:** | | | | | | | |
| 4.1 | 38,889 | 38,889 | 27,778 | 22,222 | 127,778 | - | 127,778 |
| 4.2 | 38,889 | 72,222 | 72,222 | 72,222 | 255,556 | - | 255,556 |
| 4.3 | 55,556 | 50,000 | 44,444 | 66,667 | 216,667 | - | 216,667 |
| 4.4 | 38,889 | 72,222 | 61,111 | 61,111 | 233,333 | - | 233,333 |
| | 113,000 | 131,467 | 120,107 | 108,929 | 473,502 | 26,895 | 500,397 |
| **Нийт** | 285,222 | 364,800 | 325,662 | 331,151 | **1,306,835** | **26,895** | **1,333,731** |
| **Төслийн ерөнхий хэрэгжилт** | | | | | | | |
| Delivering Outputs | 4,444 | 2,778 | 4,444 | 1,111 | 12,778 | - | 12,778 |
| Manag. Human & F | 212,333 | 164,894 | 164,473 | 171,085 | 712,785 | 100,910 | 813,696 |
| Managing Relation: | 112,444 | 124,111 | 129,361 | 139,318 | 505,235 | - | 505,235 |
| Knowledge Manag. | 6,667 | 46,667 | 6,667 | 66,667 | 126,667 | - | 126,667 |
| **Нийт** | 335,889 | 338,450 | 304,945 | 378,181 | **1,357,464** | **100,910** | **1,458,375** |
| | | | | | | | |
| **БҮГД** | **1,194,407** | **1,231,943** | **1,206,836** | **1,187,937** | **4,821,123** | **281,767** | **5,102,890** |

Тогтвортой бичил уурхай төслийн батлагдсан нийт зээлийн хэмжээ 8 сая швейцари франк бөгөөд үүний 1,1 сая швейцари франкийг төслийн эхний шатанд зарцуулсан. Төслийн үндсэн шатанд Швейцарийн хөгжлийн агентлаг нь 4,82 сая швейцари франк зарцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд үүнийг 1) хөтөлбөрийн хэрэгжилт, 2) төслийн бүрэлдхүүн 4 хэсэг, 3) техникийн тусламж (олон улсын зөвлөх ажиллуулах) 4) эцсийн үнэлгээ хийх гэсэн үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөж байна. Үйл ажиллагааны тайлан ба жилийн ажлын төлөвлөгөөнд үндэслэн төсвийг жил жилээр хуваарилах болно. Жилийн төлөвлөгөөг төслийн Удирдах зөвлөл ба Швейцарийн хөгжлийн агентлаг батлах болно. АМГТХЭГ зүгээс зарцуулах 0,28 сая швейцари франктай нийлээд үндсэн шатны 4 жилийн нийт төсөв 5,1 сая швейцари франк болж байна. Швейцарийн Дэлхийн байгаль орчны хөтөлбөрийн дэмжлэгээр хэрэгждэг төслүүд дээр Швейцарийн хөгжлийн агентлаг өөрийн зөвлөх мэргэжилтнээ ажиллуулдаг бөгөөд нэг зөвлөх байгалийн нөөцийн асуудлаар төслийн үндсэн шатанд 4 сарын хугацаатай ажиллана. Энэ зөвлөх нь тус агентлагаас хэрэгжүүлэх цөлжилтийн төсөл дээр давхар ажиллах болно. Төсвийн задаргаанд төслийн ерөнхий хэрэгжилт ба төслийн Бүрэлдхүүн хэсэг бүрт гарах гол зардлуудыг тус бүр харуулсан болно. Төслийн төгсгөлийн шатанд 2 сая швейцари франк зарцуулахаар төлөвлөж байна.

АМГТХЭГ нь бэлэн бусаар тухайлбал хүний нөөц, мэргэжлийн ажилтнууд, албан ажлын байр, унаа, хурал семинар зохион байгуулах зэрэгт тусламж, дэмжлэг үзүүлэх болно. Төсөвт зөвхөн АМГТХЭГ-ын тооцоолсноор тусгасан болно. Төсөл хэрэгжүүлэхэд Швейцарийн хөгжлийн агентлагийн зарцуулсан санхүүжилтэнд хөндлөнгийн хяналтыг Швейцарийн хөгжлийн агентлаг мэргэжлийн хяналтын байгууллагаар жил бүр хийлгэнэ. Харин АМГТХЭГ-ын төлөвлөж буй санхүүжилтийн хэсэгт бие даасан тусгай хяналтыг хийлгэх болно.

### *5.3 Үндэсний ба олон улсын зөвлөхүүдийг урьж ажиллуулах*

Төслийн эхний ба туршилтын шатанд үйл ажиллагаанд оролцож харилцаа холбоо тогтоон хамтарч ажиллаж ирсэн талууд төслийн дараагийн шатанд мөн оролцож хамтран ажиллах болно. Төсөл хэрэгжүүлэгч Швейцарийн хөгжлийн агентлаг, АМГТХЭГ-ын аль алины нь хувьд бичил уурхайн чиглэлээр ажиллаж ирсэн туршлага (мэргэжлийн боловсон хүчин, ажлын туршлага) бага учраас үндэсний ба олон улсын зөвлөх, мэргэжилтнүүдийг ажиллуулах шаардлагатай. Гэхдээ АМГТХЭГ энэ чиглэлээр зөвхөн төслийн хүрээнд мөн агентлагийн ерөнхий ажлын хэмжээнд олон улсын зөвлөхийг авч ажиллуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Төслийн хэрэгцээг үндэслэн олон улсын зөвлөхүүдийг үр дүнтэй ажиллуулах ямар боломжууд байгааг АМГТХЭГ судлах хэрэгтэй.

#### *5.3.1 Олон улсын зөвлөхүүдийг ажиллуулах зорилго*

Төсөлд ажиллах олон улсын зөвлөхүүд нь бусад орнуудад хэрэгжиж буй бичил уурхай төслүүдийн олон улсын туршлага, шинэ мэдлэг /ноу хоу, сургамж ба байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч буй эрсдэл, хор хохирлыг бууруулах арга хэмжээ, туршлага дэлгэрүүлж зорилготой ажиллах болно. Төсөл нь олон улсын зөвлөхийг Проект консалт компани, бусад холбогдох байгууллагууд ба Швейцарийн хөгжлийн агентлагийн мэргэжилтэн зөвлөхүүдийг авч ажиллуулж дараах асуудлуудад гол анхаарлаа хандуулах болно. Үүнд:

**Мэргэжлийн зөвлөгөө өгөх**: төслийн ерөнхий стратеги, техникийн туслалцааг төслийн зорилтот бүлэг ба төслийн хамтрагч талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүргэх, мэргэжлийн/техникийн ба зохион байгуулалтын тусламж дэмжлэгийг ялангуяа төслийн Бүрэлдэхүүн хэсгийн ахлагч нарт хөтөлбөрт тусгасан үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр зөвөлгөөн өгөх болно. Төсөл хэрэгжиж буй газруудад очиж ажиллахаас гадна техникийн холбогдолтой баримт бичгүүд (жижиг төслийн саналууд гм)-тэй уншиж танилцан, тодорхой техникийн асуудлаар санал солилцох бичгүүдийг гаргана. Түүнчлэн зөвлөхүүд нь төслийн төгсгөлийн стратегид тусгасны дагуу төслийн хамтрагч талуудын мэргэжлийн чадварыг дээшлүүлж тэдний чадавхийг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулах болно. Мэргэжлийн асуудлуудад: алтны геологи, бичил уурхайгаар олборлох гол бүтээгдэхүүн, ордын үнэлгээ, олборлолт ба ашигт малтмалын баяжуулалтын технологи, уул уурхай дахь байгаль орчны асуудлууд, эрх зүй, зохицуулалтын асуудлууд, бичил уурхайн үйл ажиллагааг хуульчлан албан ёсны болгох, зөрчлийг шийдэх арга замууд, бичил уурхайн бүтээгдэхүүний зах зээл, мэргэжлийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, уул уурхайтай холбоотой гарч буй хор хохирол, нөхөрлөл, холбоо ба бусад шүхэр байгууллагууд зэрэг бичил уурхайн бүтэц зохион байгуулалтын асуудал, бичил уурхайн үйл ажиллагааг санхүүжүүлэх, бичил уурхай эрхлэгчдэд бүх талын шаардлагатай үйлчилгээ бий болгох, үйлчилгээ үзүүлэгчдийг сургаж бэлтгэх, төр, засгийн газрын хэмжээнд бичил уурхайн удирдлагын төвлөрлийг сааруулах зэрэг асуудлууд орно.

**Сургалт ба чадавхийг бий болгох:** сургалтын арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, заавар удирдамж гаргах, тэргүүн/сайн туршлагын жишээнүүд, ашиглах материалуудыг бэлтгэх болно. Түүнчлэн шаардлагатай сургалтуудыг явуулахад оролцож дэмжлэг тусламж үзүүлэхээс гадна бичил уурхайн олон улсын

туршлага, жишээ нь: Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэг, бусад орнуудад хэрэгжиж буй бичил уурхайн төслүүдийн туршлагаас танилцуулж, олон улсын сүлжээнд нэгдэхэд дэмжлэг үзүүлнэ. Швейцарийн хөгжлийн агентлаг байгалийн нөөцийн асуудлаар нэг зөвлөх авч ажиллуулж, төсөл хэрэгжүүлэх техникийн асуудлаар агентлагт туслах болно. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэгч үндэсний байгууллагуудын дунд төслийн менежмент, баг бүрдүүлэх, харилцаа холбоо, тайлагнах асуудлаар сургалт зохион байгуулахад туслана.

**Технологи ба шинэ мэдлэг/ноу хоу нэвтрүүлэх:** бусад орнуудад хэрэгжүүлж буй төслүүдийн жишээ, шинэ технологи, тоног төхөөрөмж (ашиглалт, эрдэсийн баяжуулалт, байгаль орчны нөхөн сэргээлт)-ийг дэлгэрүүлэхэд холбогдох загвар, зургуудаар тусалж мэргэжлийн ур чадвар мэдлэгийг дээшлүүлнэ.

**Төлөвлөх ба тайлагнах ажлууд:** стратегийн төлөвлөлтөнд хувь нэмэр оруулах техникийн ба байнгын тайлангуудыг гаргахад тусламж дэмжлэг үзүүлнэ.

**Үнэлгээ:** төсөл хэрэгжих хугацаанд бичил уурхайн тодорхой асуудлаар өөрсдөө мониторинг явуулах, оролцооны аргаар төслийн мониторинг ба үнэлгээ явуулахад туслах болно.

### *5.3.2 Бүрэдхүүн хэсэг бүрээр олон улсын зөвлөхүүдийн авч үзэх асуудлууд*

Олон улсын зөвлөхүүд нь Монголын холбогдох мэргэжлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, төслийн стратегийн төлөвлөлт хийх ба бичил уурхайн бусад орнууд ялангуяа Швейцарийн хөгжлийн агентлагийн хэрэгжүүлдэг төслүүдийн туршлагууд, хөгжлийн ижил асуудалтай хөрш зэргэлдээ орнуудын туршлагатай уялдуулахад гол анхаарлаа хандуулах болно.

**Хүснэгт 2: Төслийн Бүрэлдэхүүн хэсэг бүрээр олон улсын зөвлөхүүдийн ажиллах асуудлууд**

| | Ажиллах өдөр | Төсөв [швейцари франк] |
|---|---|---|
| Бүрэлдхүүн хэсэг 1: | | |
| Бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсны болгож хуульчлах хамгийн нийцтэй хэрэгжүүлж болохуйц дүрэм журам боловсруулах олон улсын туршлагаас танилцуулж туслах | 30 | 33000 |
| Бичил уурхайн олон улсын сүлжээтэй холбоо тогтооход туслах | 15 | 16500 |
| Бичил уурхайгаар олборлосон алтыг албан ёсоор худалдах орчинг бүрдүүлэх талаар холбогдох талуудад зөвлөгөө өгөх | 30 | 33000 |
| Бүрэлдхүүн хэсэг 2 | 0 | 0 |
| Бичил уурхайн үр ашигтай менежментийг хэрэгжүүлэх үүднээс уул уурхайн удирдлагын төвлөрлийг сааруулахад туслах | 40 | 44000 |
| Бичил уурхайн мэдээллийн сангийн бүтэц дизайн бий болгох, түүний үнэлгээний асуудалд туслах | 20 | 22000 |
| 2007 оны сүүлээр Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэг (CASM)-ийн ээлжит хуралдааныг Монгол улсад зохион байгуулах, бэлтгэл ажилд туслах | 20 | 22000 |
| Бүрэлдхүүн хэсэг 3 | 0 | 0 |
| Уул уурхайн асуудал (эрдэсийн баяжуулалт, нөхөн сэргээлтийн арга техникүүд, шинэ технологи нэвтрүүлэх гм)-уудад техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, шинэ технологи, | 80 | 88000 |

| | | |
|---|---|---|
| шинэлэг шийдлүүдийг дэлгэрүүлэх | | |
| Сургалтын материалууд бэлтгэх боловсруулах, сургалтын арга хэмжээнүүдэд туслах | 20 | 22000 |
| Бүрэлдхүүн хэсэг 4 | 0 | 0 |
| Зөрчлийг зохицуулах, шийдэх талаар хийгдэх сургалтууд | 25 | 27500 |
| Бичил уурхай оролцооны мониторингийн тогтолцоог бий болгох асуудлаар зөвлөх | 15 | 16500 |
| Бичил уурхайн байгаль орчинтой холбоотой асуудлаар чадавхийг бэхжүүлэх, үүнд хямд өртөг бүхий нөхөн сэргээлтийн технологи, хорт бодисын хэрэглээг бууруулах зэрэг асуудлуудыг оруулах | 50 | 55000 |
| Төслийн ерөнхий менежментийн асуудлаар өгөх зөвлөгөөө | 0 | 0 |
| Жижиг төслүүд ба туршилтын арга хэмжээнүүдийг төлөвлөх хэрэгжилтэнд хяналт тавихад туслах | 22 | 24200 |
| Багаар ажиллах, менежментийн ба техникийн дэмжлэг үзүүлэх (Швейцарийн хөгжлийн агентлагийн зөвлөх) | 480 | 396000 |
| Нийт | 847 | 799700 |

Төсөлд олон улсын зөвлөх, мэргэжилтнүүдийг ажиллуулахад дунджаар нэг өдөрт 1111 швейцари франк, Швейцарийн хөгжлийн агентлагийн зөвлөх өдөрт 825 швейцари франкийн зардалтай гэж тооцсон. Ямар үйлчилгээ, тусламж хүргэж байгаагаасаа хамаарч мэргэжилтэн зөвлөхүүдэд өөр өөр үнэ тариф мөрддөг мөн хөдөө орон нутагт ажиллах үед унааны зардал ба өдрийн томилолт зэрэг нь дээрх дунджаар бодсон зардалд багтаж орсон байдгийг төсөл сайн мэддэг. Гэхдээ Парисын тунхаглалын шаардлагыг үндэслэн төсөл зөвлөх ажиллуулахдаа дор хаяж нийт төлөвлөсөн ажлын 25 %-д бичил уурхайн дэд салбарт бусад донор байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

## *5.4 Бичил уурхай салбарт хамтарч ажиллах гол байгууллагууд ба хамтран ажиллах боломжууд*

### *5.4.1 ОУХБ “Хүүхдийн хүнд хөдөлмөрийг устгах үндэсний дэд хөтөлбөрийг дэмжих” төсөл*

ОУХБ/АЙПЕК нь Монгол улсад 1999 оноос хойш ажиллаж өөрийн төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлж байна. Гол үйл ажиллагаа Монгол улсын Хүүхдийн хөдөлмөрийг устгах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг тусламж үзүүлэхэд чиглэдэг. Хэрэгжүүлж буй төслийнхээ хүрээнд 5-17 насны хүүхдүүдийг зохисгүй хөдөлмөр эрхлэхээс сэргийлж хүүхдийн хөдөлмөрийг устгах зорилт тавьж ажиллахаар төлөвлөж байна. Төсөл нь албан бус уул уурхайд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн асуудалд нэлээд анхаарлаа хандуулж ийм үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн газруудад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Төслийн үйл ажиллагаагаа чиглүүлж буй газрын нэг нь Баянхонгор аймаг юм. Тогтвортой бичил уурхай төсөл нь ОУХБ/АЙПЕК-ийн энэ төсөлтэй хүүхдийн хөдөлмөрийн асуудал мөн хүүхдүүдийн боловсролын асуудал, сургууль завсардалтыг бууруулах, хүүхэд эцэг эхчүүдэд сургалт явуулах талаар хамтарч ажиллахаар тохиролцоод байна. Бодлого, зохицуулалтын орчин бүрдүүлэх талаар хамтын ажиллагааг бий болгосон бөгөөд цаашид олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтийн мэдээлэл сурталчилгааг бий болгоход хамтран ажиллах болно.

### 5.4.2 НҮБ-ын хүн амын сангаас хэрэгжүүлж буй “Хот суурин газрын орчмын ба албан бус уурхай эрхлэгчдийн нийгэм эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах”

НҮБ-ын хүн амын сан нь Монгол улсын засгийн газар (Эрүүл мэнд, Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яамдууд)-тай маш ойр хамтран ажилладаг ялангуяа хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх, ДОХ бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх асуудлаар хамтран ажилладаг. НҮБ-ын хүн амын сан нь хөндөж буй асуудлууд ба хэрэгжүүлж буй үр дүнтэй үйл ажиллагаагаараа үндэсний хэмжээнд харилцагч хамтрагч талуудынхаа итгэлийг нэлээд сайн олсон байдаг. НҮБ-ын хүн амын сан нь 2007 оноос эхлэн албан бусаар уурхайд ажилладаг хүмүүс, бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх төслийг хэрэгжүүлэх гэж байна. Тогтвортой бичил уурхай төсөл нь тус төсөлтэй хамтран уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй газруудад эрүүл мэндийн явуулын үйлчилгээ ба мэдээллийн төв байгуулж ажиллуулах, сургалтын материалууд хийж тараахаар тохиролцоод байна.

### 5.4.3 Дэлхийн банк

Дэлхийн банк нь Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран Уул уурхайн үндэсний зөвлөлгөөнийг хамтран зохион байгуулсан. Тус үндэсний зөвлөлгөөнд төрөл бүрийн байгууллагуудын 300 гаруй төлөөлөгчид оролцож уул уурхай түүний дотор бичил уурхайн салбарын асуудал, хөгжлийн асуудлаар зөвлөлдсөн. 2007 онд төсөл Дэлхийн банктай хамтран Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэгийн ээлжит хуралдааныг Монгол улсад зохион байгуулахаар төлөвлөж байна.
Дэлхийн банк нь байгалийн нөөцтэй холбоотой асуудлаар маш идэвхитэй ажиллаж сүүлийн жилүүдэд судалгаа, дүн шинжилгээний ажлуудыг нэлээд хийсний дотор байгаль орчин ба уул уурхайн тайланг гаргасан юм.

### 5.4.4 ХГУ-ын Гео-шинжлэх ухаан, эрдэс баялагийн хүрээлэн (BGR)

ХГУ-ын Гео-шинжлэх ухаан ба эрдэс баялгийн хүрээлэн нь „Уул уурхай дахь байгаль орчны хамгаалал“ төслийг 2005-2010 онд хэрэгжүүлж байна. Төсөл нь уул уурхай дахь байгаль орчны хамгааллын асуудлаар байгаль орчны байцаагчдын чадавхийг бий болгох, хөгжүүлэх, шинэ дэвшилтэт арга, технологи хэрэглэх нөхөн сэргээлтийн асуудлаар сургалт явуулах, уул уурхайтай холбоотой хууль, дүрэм журмын хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна. Тогтвортой бичил уурхай төсөл нь энэ төсөлтэй хууль, дүрэм журам боловсруулах чиглэлээр хамтран ажилласан бөгөөд цаашид 4 дэх Бүрэлдхүүн хэсгийн хүрээнд хамтран ажиллах болно.

### 5.4.5 Төрийн бус байгууллагууд

#### 5.4.5.1 Нээлттэй нийгэмлэг форум

Нээлттэй нийгэмлэг форум нь Монгол улсад өмнө ажиллаж байсан “Соросын санг” үйл ажиллагаагаа дуусгах үед байгуулагдсан ТББ юм. Тус форум нь ихэнхидээ олон нийтийн дунд мэдээлэл сурталчилгаа, нийгмийн асуудлаар харилцан ярилцлага мэтгэлцээн явуулдаг. Форум нь уул уурхай ба ил тод уул уурхайн асуудлаар жилд үндэсний зөвлөлгөөн зохион байгуулах боломжийг хайж болно. Төслийн хувьд хамтран ажиллах өөр нэг боломж бол бичил уурхай эрхлэгчдийн үндэсний холбоо/ ассоциаци байгуулах санаачлага (Бүрэлдхүүн хэсэг 2), нийгмийн асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг ба зөрчлийг бууруулах асуудал (Бүрэлдхүүн хэсэг 4) –аар сургалтууд явуулах боломжтой.

#### 5.4.5.2 Азийн сан

Энэхүү олон улсын ТББ нь холбогдох талуудын дунд уул уурхайн асуудлаар идэвхитэй ярилцлага хэлэлцүүлгийг явуулдаг. Түүнчлэн уул уурхайн албан ёсны том компаниуд ба бичил уурхай эрхлэгчид (Бүрэлдхүүн хэсэг 4)-ийн хоорондын зөрчлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж чадах орон нутгийн хөдөлгөөнүүдийн хооронд сайн сүлжээ бий

болгож чадсан. Монгол улсад “хариуцлагатай” уул уурхайг тодорхойлж гаргахад оролцож төсөлтэй хамтарч ажиллах боломжтой.

*5.4.5.3 Орон нутгийн олон нийтийн хөдөлгөөнүүд*

Орон нутгийн малчдын дуу хоолойг төлөөлж идэвхийтэй ажилладаг Онги голынхон, Эх нутгийн дуудлага зэрэг олон нийтийн хөдөлгөөнүүд байдаг. Ялангуяа уул уурхай дахь хариуцлагагүй байдалтай нэлээд тэмцэж, уул уурхайн албан ёсны том компаниудыг байгаль орчноо хамгаалах арга хэмжээ авах, уул уурхайгаас олох ашиг тусаас орон нутагт шудрага хуваах зэрэг шаардлагуудыг тавьдаг.

### 5.4.6 Хувийн салбар

*5.4.6.1 Проект консалт*

Проект консалт нь өмнөд Америк, Африк, Азийн орнуудад бичил уурхайн асуудлаар төсөл хэрэгжүүлж нэлээд өргөн туршлагатай болсон компани юм. Компанийн дэд захирал Майкл Прийстер нь бичил уурхайн асуудлаар олон улсын хэмжээнд ажилладаг мэргэжилтэн бөгөөд Монгол улсад Бичил уурхайг дэмжих төслийн эхний ба туршилтын шатыг амжилттай эхлүүлж хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Ялангуяа бичил уурхайн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгаль орчны бохирдлыг бууруулах, бичил уурхайн олон улсын сүлжээ, холбоотой харилцаа тогтоох зэрэгт нэлээд туршлагатай учраас түүний бичил уурхайн мэргэжлийн ур чадвар Тогтвортой бичил уурхай төслийн үндсэн шатны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах болно.

*5.4.6.2 Экосфера*

Экосфера нь байгаль орчны зөвлөх компани бөгөөд Баянхонгор аймаг дахь төслийн сонгосон хоёр газруудад байгаль орчны суурь судалгааг хийсэн. Энэ судалгаагаар байгаль орчны суурь үзүүлэлтүүдийг харуулах олон чухал мэдээ баримт үр дүнгүүдийг цуглуулсан. Тус компани нь байгаль орчны нөөцтэй холбоотой төслүүдийн үнэлгээний ажлаар БОЯ болон НҮБХХ, Дэлхийн банктай зэрэг донор байгууллагуудтай хамтран ажилладаг.

*5.4.6.3 Гео консалтинг компани*

Энэ нь геологийн асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хувийн жижиг компани. Тус компанийг геологич байгаль хамгаалагч н. Түмэнбаяр удирддаг. Тэр уул уурхайн салбар ялангуяа мөнгөн ус ба түүний хэрэглээг эрдэс (алт) баяжуулалтанд бууруулах талаар нэлээд их судалгаа хийсэн, туршлагатай чадварлаг мэргэжилтэн. Түмэнбаяр ба түүний компани нь судалгааны үр дүнгээсээ хуваалцан төсөлтэй ойр ажилладаг ба үндэсний зөвлөлгөөний ажлын хэсэгт оролцож мөнгөн усны бохирдлын талаар хийсэн судалгааны үр дүнгээ танилцуулсан. Судлаач эрдэмтэн ба түүний компани нь ЖАЙКА, ДБ, Канадын сан зэрэг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр бичил уурхай ба мөнгөн ус хэд хэдэн төслүүд дээр ажилласан.

## 6 Ашигласан материал

Ц. Адъясүрэн ба үнэлгээний баг (2006). Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Шинэжинст сум дахь бичил уурхайн үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийн үнэлгээ Экосфера Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба консалтинг компани.

Ичаварриа К. А. Клэй (2006). Монгол улс. Бичил уурхайг дэмжих төсөл. Төслийн үндсэн шатны бэлтгэл ажлын үнэлгээ. Хариуцлагатай уурхайн холбоо, Хөгжилж ба байгаль орчныг дэмжих төв х 67.

Германн Д. И. Гохл (1996). Гарах үр дүнд хэсэг бүлгээр үнэлэлт өгөх, Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг

Швейцарийн хөгжлийн агентлаг (2000). Швейцарийн хөгжлийн агентлагийн стратеги 2010: х 16.

Швейцарийн хөгжлийн агентлаг (2006). Энх тайвныг эрхэмлэх SDC: х. 28.

Дэлхийн банк (2006). "Монгол улс: Ядуурлын байдалд хийсэн үнэлгээ"

## 7 Товчилсан үгийн тайлбар ба зарим нэр томъёоны тайлбар

АМГТХЭГ Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар

АНУ-ын ОУХА

Америкийн нэгдсэн улсын Олон усын хөгжлийн агентлаг /US Agency for International Development/

БОЯ Байгаль орчны яам

БУН Бичил уурхайн нэгж

БУЭ Бичил уурхай эрхлэгчид гэдэг нь тухайн орон нутагт тогтвортой суурьшин амьдарч цаашдаа ч амьдрах сонирхолтой 10 ба түүнээс дээш тооны хүмүүс (гэр бүлээрээ ба албан бус нэгдсэн хүмүүс) нэгдэн ашигт малтмал олборлож буй хүмүүсийг хэлнэ. Эдгээр бүлэг хүмүүсийн дунд олборлолтын бус үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс ч ордог.

БУЭҮЗ Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний зөвлөл (санал болгож буй байгууллага)

БУДОУН

Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэг (Communities and Small-Scale Mining CASM (platform hosted by World Bank))

ГАМА Gestion Ambiental an la Minerнa Artesanal GAMA (SDC supported ASM project in Peru)

ГТХАН Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг

ДБ Дэлхийн банк

ЖДҮ Жижиг дунд үйлдвэрлэл

МАОЭХ Монголын ажил олгогч эздийн холбоо

МЭДМИН Medio Ambiente y Minerнa MEDMIN (SDC supported ASM project in Bolivia)

НХХЯ Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам

НҮБ-ын ХАС

Нэгдсэн үндэстний байгууллагын хүн амын сан

ОУХБ Олон улсын хөдөлмөрийн байгууллага (Женева)

SDC Швейцарийн хөгжлийн агентлаг

PMSC Proyecto Minerнa Sin Contaminaciуn PMSC (SDC supported ASM project in Ecuador)

ТББ Төрийн бус байгууллага

ТУЗ Төслийн удирдах зөвлөл

УМХГ Улсын мэргэжлийн хяналтын газар

УУАА Уул уурхайн аврах алба

ҮХЯ Үйлдвэр худалдааны яам

ХУУА Хариуцлагатай уул уурхайн ассоциаци www.communitymining.org

ХГУ-ын ГШУЭБХ

Холбооны Герман улсын Гео-шинжлэх ухаан, эрдэс баялагийн хүрээлэн (Bundesanstalt fьr Geowissenschaften und Rohstoffe / Hannover BGR (German Geological Survey))

ХХУОУХ
Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр International programme for the Elimination of Child Labour /IPEC/

ШУТИС Шинжлэх ухаан, технологийн их сургууль

ШДБОХ
Швейцарийн Дэлхийн байгаль орчны хөтөлбөр (GEP Global Environment Program)

**Хариуцлагатай уул уурхайн ассоциаци:** нь хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд итгэл найдвар, ил тод байдал, хууль ёсыг бий болгож чадах олон улсын төрөл бүрийн байгууллагуудын оролцоог бий болгосон дэлхий нийтийн бие даасан, шинэлэг санаачлага бүхий байгууллага юм. Ассоциацийн гол зорилго нь ашигт малтмал олборлож буй хүмүүсийн нийгэм, байгаль орчин, засаглал, экосистемийн нөхөн сэргээлтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн урамшуулал бүхий шинэлэг арга барилд үндэслэн тэдний дунд тэгш байдал, сайн сайхныг бий болгоход чиглэнэ. Бичил уурхай эрхлэгчдээс алт худалдаж авах шудрага худалдааг хөгжүүлэх тэг стандартыг бий болгож, санал солилцон, туршиж олон нийтэд танилцуулж санал бодлоо солилцох энэ стратегийн гол хэсэг байна (www.communitymining.org)

**Шудрага худалдаа:** нь олон улсын худалдаанд эрх тэгш оролцох ярилцлага, ил тод байдал, харилцан хүндлэлд үндэслэсэн худалдааны хамтын ажиллагаа юм. Ялангуяа Өмнөдийн хөгжиж буй орнуудын эмзэг ядуу бүлгийн үйлдвэрлэгчдийг өөрсдийн олборлосон бүтээгдхүүнээ зах зээлд нийлүүлж, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад тусламж дэмжлэг үзүүлнэ. Шудрага худалдааны байгууллагууд (хэрэглэгчдийн) нь үйлдвэрлэгчдээ дэмжин олон улсын худалдааны дүрэм журмын талаар мэдээлэл бий болгож, мөрдөж буй дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулахад идэвхитэй оролцох болно (www.FairTrade.net).

# 8 Хавсралтууд

## *8.1 Төслийн үйл ажиллагааны биелэлтийг хэмжих хүснэгт*

| Үр дүнгүүд | Менежментийн үр дүн (2012 он гэхэд) | Үзүүлэлтүүд/ Үнэлгээ | Үр дүнгүүдийг нотлох баримтууд |
|---|---|---|---|
| **Хөгжлийн үр дүнгүүд** | Төслийн тодорхой үр дүнгүүд гарсан байна. | 70% | Төслийн баримт бичиг, тайлангууд |
| | Үйл ажиллагааг төслөөс гарах үр дүнтэй нийцүүлж, өөрчлөлт гарсан, үл нийцэх хэсгүүдийг тогтоож | Төслийн үндсэн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах | Жилийн төлөвлөгөөнүүд |
| | Үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ орон нутагт АМГТХЭГ-тай зэрэгцэх зохицуулалт бүхий бүтэц зохион байгуулалт бий болгохоос зайлсхий, үйл ажиллагааг уялдаатай үр дүнтэй хэрэгжүүлэх бүтцийг бий болгох | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба зохицуулах гэрээ хэлэлцээрүүд<br>Бусад донорууд ба засгийн газартай зохицуулалт хийх | National and local implementation units efficiency and effectiveness assessment |
| | Чадавхийг бий болгох асуудал зохицуулагдсан байна. | Чадавхийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа хамтрагч бусад талуудтай зохицуулж нийт ажлын 50% хэрэгжсэн байна. | Үйл ажиллагааны ба санхүүгийн тайлангууд |
| | Жендер, засаглалын асуудлаар тодорхой бодитой үр дүнгүүд гарсан байх | Гол асуудлууд Бүрэлдэхүүн хэсгүүдэд тусгагдсан байна.<br>Холбогдох тодорхой үр дүнгүүд гарсан байна. | Жендерийн асуудлын үнэлгээ Гол/ түлхүүр асуудлууд бүхий жагсаалтууд гарсан байна. |
| | | | |
| **Хүний ба санхүүгийн нөөцийн асуудал** | Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ажилтнуудын хүлээх хариуцлага чадварыг бий болгох | Үйл ажиллагааны тайлангууд ба төлөвлөгөөнүүд нь Швейцарийн хөгжлийн агентлаг ба АМГТХЭГ-ын стандартуудад нийцсэн байна.<br>Ажилтнуудыг холбогдох сургалтуудад хамруулж чадварыг дээшлүүлсэн байна. | Швейцарийн хөгжлийн агентлаг ба АМГТХЭГ-аас өгсөн санал дүгнэлтүүд<br>Сургалтанд хамрагдсан тухай тайлангууд |
| | Ажилтнуудыг чадваржуулах | Үүрэг хариуцлагыг тодорхой болгож, нөөцийг хуваарилсан байх | Ажил байдлын тодорхойлолт ба ажил үүргийн гүйцэтгэлд хяналт |

| Үр дүнгүүд | Менежментийн үр дүн (2012 он гэхэд) | Үзүүлэлтүүд/ Үнэлгээ | Үр дүнгүүдийг нотлох баримтууд |
|---|---|---|---|
| | | Ажилдаа хандах хандлага нь >90% байвал эерэг үзүүлэлтэй байна гэж үзэх, | мониторинг хийсэн байна.<br>Ажилтнуудаас санал дүгнэлтийг нь авсан байна. |
| | Төслийн шаардлагын дагуу төслийн баг, ажилтнуудыг бүрдүүлэх | Төслийн Бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагааг шаардлагын хэмжээнд хэрэгжүүлэх чадвартай болсон байх | Гэрээт ажлын хугацаанд |
| | Төслийн төсвийг тогтоосон стандарт, дотоод дүрэм журмын дагуу үр ашигтай зарцуулсан байх | Жилийн төлөвлөгөөнүүдэд тусгасны дагуу төсвийг зарцуулах (нэмэх/хасах 10%)<br>Өгөөж (үр дүнгүүд) нь өндөр байх | Аудитын тайлан<br>Жилийн төсөв ба санхүүжилтын хуваарилалт |
| | Ажиллах нөхцлийг тэнцвэржүүлсэн байх | Ажлаас чөлөөлөгдсөн байх боломж жилд < 10%<br>Өвчний улмаас ажлаас чөлөөлөгдсөн байх өдрийн тоо нэг ажилтанд < 5 | Судалгаа ба ирцийн бүртгэл |
| | Хамтрагч талуудаас санхүүжилт, дэмжлэг тусламжийг төвлөрүүлэх | Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтийн наад зах нь 50% (үйл ажиллагаар хэрэгжүүлэх зардлыг оруулахгүйгээр) –ийг хамтрагч талуудаас зарцуулсан байна. | Төсөв ба санхүүгийн тайлангууд |
| | | | |
| **Харилцаа холбоо (гадаад ба дотоод)** | Швейцарийн хөгжлийн агентлаг нь бичил уурхайтай холбоотой асуудалд тэргүүлэх үүрэгтэй оролцдог байгууллага болсон байх | Бичил уурхайтай холбоотой асуудлаар доноруудын хооронд зохицуулах уулзалт ярилцлагууд хийж тодорхой үр дүнгүүдийг харуулсан байх | Швейцарийн хөгжлийн агентлагийн үйл ажиллагааг бусад донорууд үнэлсэн байна. |
| | Швейцарийн хөгжлийн агентлагийн бусад төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж үр дүнг сайжруулж, зардлыг бууруулсан байх | Хамтын ажиллагааны санаачлагууд ба гэрээ хэлэлцээрүүд | Хамтарсан тайлангууд<br>Зардлуудыг хэмнэсэн байна. |
| | Швейцарийн хөгжлийн агентлагийн бусад төсөл хөтөлбөрүүдтэй хамтран үнэлгээний ажлууд хийх | Хамтарсан ажлын 40% | Тайлангууд (зохиогчийн эрх, санхүүгийн тайлангууд) |
| | Бусад донорууд ба үндэсний байгууллагуудтай хамтран дүн шинжилгээний ажлууд хийх | Нийт хийх дүн шинжилгээний ажлуудын 60% | Тайлангууд (зохиогчийн эрх, санхүүгийн тайлангууд) |
| | Харилцааны үр ашигтай тогтолцоо чиглэлийг бий болгож мэдээлэл солилцох (Швейцарийн | Швейцарийн хөгжлийн агентлаг, АМГТХЭГ-ийн | Швейцарийн хөгжлийн агентлаг, АМГТХЭГ, үндэсний бусад |

| Үр дүнгүүд | Менежментийн үр дүн (2012 он гэхэд) | Үзүүлэлтүүд/ Үнэлгээ | Үр дүнгүүдийг нотлох баримтууд |
|---|---|---|---|
| | хөгжлийн агентлаг, АМГТХЭГ, SC, MF УХЯ зэрэг эрх бүхий байгууллагууд) | хооронд өөрчлөлт (сөрөг) гараагүй байна. | байгууллагуудаас санал дүгнэлтүүдийг авсан байна. |
| | Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дотор үр дүнтэй харилцаа тогтсон байна. | Төслийн нэгжийн дотор харилцаа холбоонд өөрчлөлт гараагүй байх | Төсөл хэрэгжүүлэх нэгжээс АМГТХЭГ ба Швейцарийн хөгжлийн агентлагт санал дүгнэлтээ илгээсэн байна. |
| | | | |
| **Мэдлэгийн менежмент** | Жил бүр дор хаяж 8 чухал ололт амжилт (сайн туршлага, үр дүн, арга хэрэгсэл гм)-г үзүүлж Швейцарийн хөгжлийн агентлагийн сонин (Onsite Insights)-оордамжуулж бусад холбогдох талуудад хүргэсэн байх | Contributions to Onsite Insights<br>Товч мэдээ мэдээлэл ба кино зэргээр баримтжуулсан байх | Awareness of the project among Хамтрагч, оролцогч талууд (судалгаа хийж, олон нийтийн хэрэгслээр дамжуулсан байх) |
| | Швейцарийн хөгжлийн агентлагийн хөтөлбөрүүд ба хөгжлийн асуудлаар хамтрагч талуудын талаарх мэдээллийн бий болгож харилцан солилцож үйл ажиллагаандаа ашигладаг байх (жишээ нь өмнөд-өмнөдийн хөгжиж буй орнуудын хооронд туршлага солилцох) | Холбогдох мэдээлэл, тэргүүн/ сайн туршлагууд, арга хэрэгслүүд | Тодорхой үйл ажиллагаа (томилолтын ажил, танилцах аялал, бага хурал, сургалт семинарууд гм) |
| | Бичил уурхайг зохион байгуулалттай болгох талаар хөгжлийн гол асуудлаар үндэсний зөвлөлгөөн, семинар зохион байгуулагдсан байх | Оролцсон байдал (чанарын ба тооны), бодлогын талаар гаргасан зөвлөмжүүд ба дүгнэлтүүд | Санал дүгнэлтүүд гарч олон нийтэд хүрсэн байх |
| | Сайн туршлага, сургамжууд, бусад холбогдох сэдвүүдээр харилцан санал бодлоо солилцсон байх | 14 хоногт нэг удаа хийх уулзалт ярилцлагаууд, танилцуулга мэдээлэл хийсэн, тусгай асуудлуудыг авч үзсэн хурал, уулзалтууд | Төсөлтэй холбоотой асуудлууд ба хөгжлийн асуудлаар мэдээлэл бий болсон байна. |

## 8.2 *“Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн гол хамтрагч харилцагч талуудад хийсэн дүн шинжилгээ*

Бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой хамтрагч, харилцагч талуудын ололттой сайн ба сул талууд, төслийн үйл ажиллагаанд оролцох боломжийг авч үзвэл:

| Хамтрагч, харилцагч талууд | Асуудалд хэрхэн оролцож, ямар нөлөө үзүүлж чадах вэ? | Асуудлыг шийдэхэд оролцох чадвар/хүсэл эрмэлзлэл | Бусад талуудтай тогтоосон харилцаа холбоо (жишээ нь: хамтын ажиллагаа ба зөрчил гм) | Үйл ажиллаганы холбогдох чиглэлүүд | Зорилго |
|---|---|---|---|---|---|
| **Үйлдвэр худалдааны яам (ҮХЯ)** | Уул уурхай нь аж үйлдвэрийн салбарын нэг учраас тус яаманд харъяапагддаг. | Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулалтанд оруулах хэрэгтэй гэж үздэг.<br>Бичил уурхайн тухай хуулийн төслийг боловсруулахад оролцсон.<br>Яамны сайд бичил уурхайн үйл ажиллагаатай холбогдсон “туршилт явуулах тухай” тушаал гаргасан.<br>Уул уурхайн мэргэжилтнүүд дутагдалтай байдаг | Хэдийгээр АМГТХЭГ нь ҮХЯ-д харъяалагддаг ч тэдгээрийн хооронд холбоо харилцаа сул байна. | ҮХЯ нь Монгол улсын уул уурхайн салбарыг хариуцдаг ганц яам юм. | Тус яам нь худалдаа, үйлдвэрийн хөгжлийн бодлогыг боловсруулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих |
| **Байгаль орчны яам (БОЯ)** | Байгаль орчныг доройтуулж, хор учруулдаг уул уурхайн олборлолтын эсрэг байр суурьтай байдаг.<br>Алтны олборлолтонд мөнгөн ус хэрэглэх (хатуу хяналтын дор ч)-ийг хүлээн зөвшөөрдөггүй | Бичил уурхайн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх ба мөнгөн усны хор нөлөөг бууруулах талаар төсөлтэй хамтын ажиллагаагаа эхлүүлээд байна. | Уул уурхайн байгаль орчны стандартууд, дүрэм журмын талаар хамтран ажилладаг. | Эрдсийн бус байгалийн баялагийг ашиглалт ба хортой бодис хэрэглэх зөвшөөрлийг олгодог. | Байгаль орчны бодлогыг боловсруулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих |
| **Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам (НХХЯ)** | Бичил уурхай эрхлэгчдийн дунд нийгмийн олон хүндрэлтэй асуудлууд байдаг гэдгийг ойлгодог. | Төсөлтэй хамтран ажиллахад бэлэн.<br>Яамны сайд болон бусад албан тушаалтнууд төслийн үйл ажиллагааны талаар сайн ойлголттой | ОУХБ/ХХУОУХ ба МАОЭХ-той ойр хамтран ажилладаг. | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлогыг боловсруулдаг<br>Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг боловсруулж |

| **Хамтрагч, харилцагч талууд** | **Асуудалд хэрхэн оролцож, ямар нөлөө үзүүлж чадах вэ?** | **Асуудлыг шийдэхэд оролцох чадвар/хүсэл эрмэлзлэл** | **Бусад талуудтай тогтоосон харилцаа холбоо (жишээ нь: хамтын ажиллагаа ба зөрчил гм)** | **Үйл ажиллаганы холбогдох чиглэлүүд** | **Зорилго** |
|---|---|---|---|---|---|
| | | байдаг. | | | батлуулсан. |
| **Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ)** | Төслийн гол хамтрагч тал. Бичил уурхайн нэгжийг байгуулж төслийн бүтцийн дор ажиллуулж байна. | Бичил уурхайн асуудлыг зохицуулж шийдвэрлэх байр суурийг бүрэн дэмждэг<br>Уул уурхайн мэргэжлийн чадварлаг ажилтнууд дутаг | Уул уурхай ба бичил уурхайд доноруудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг зохицуулахад тэргүүлэх үүрэгтэй оролцоход бэлэн байдаг. | АМГТХЭГ нь уул уурхайн үйлдвэрлэл, газрын тос, геологийн судалгаа, уул уурхайн мэдээллийн сан, уул уурхайн кадастрын салбарын бодлогыг тодорхойлж үйл ажиллагааг зохицуулдаг засгийн газрын тохируулагч агентлаг юм. | Монгол улс дахь бичиил уурхайн үйл ажиллагааг хуульчлах, зохицуулах |
| **Уул уурхайн аврах алба (УУАА)** | Аюулгүй ажиллагаа ба сургалтын явуулын үйлчилгээг бий болгож сургалт мэдээллийн нэгжийг бий болгож аюулгүй ажиллагааны стандарт, хэрэгцээний талаар шинэ мэдлэг/ ноу хоуг бий болгоно. | УУАА цаашид явуулын үйлчилгээ хүргэхэд оролцох болно. | Төслийн туршилтын шатны хугацаанд УУАА нь бичил уурхай бүхий газруудад очиж сургалт, заавар зөвлөгөөг өгч тэдний итгэлийг олж чадсан.<br>Албан ёсны том уурхайн холбогдох талуудтай сайн харилцаа тогтоосон. | Түлш эрчим хүчний яаманд харъяалагддаг ба уул уурхайн хөдөлмөр хамгаалал ба аюулгүй ажиллагааны асуудлаар ажилладаг.<br>Үйлчилгээг хөгжүүлэхэд мэргэжлийн ажилтнууд, материаллаг нөөц шаардлагатай. (УБ хотын Налайх дүүрэгт төвтэй 4 салбарт нийт 50 орчим мэргэжлийн хүмүүстэй үйл ажиллагаагаа явуулж байна. | Уул уурхайн аюулгүй ажиллагаа, аврах үйлчилгээ, тусламж үзүүлэх |
| **Улсын мэргэжлийн хяналтын газар (УМХГ)** | Мөнгөн усны хэрэглээг хориглодог | Төсөлтэй мөнгөн усны хэрэглээг бууруулах улмаар арилгах, байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудлаар хамтран ажиллах сонирхолтой. | УМХГ нь ХГУ-ын ГШЭБХ-ын төсөл (байгаль орчны менежмент)-ийн гол хамтрагч байгууллага. | Ерөнхий сайдын дэргэд ажилладаг. УМХГ нь бүх аймаг, сумдад ажилладаг байгаль орчны байцаагчдыг удирддаг. | Байгаль орчны асуудлууд, байгаль орчинтой холбоотой аливаа үйл ажиллагаанд хяналт шалшалтаа тавьдаг. |

| **Хамтрагч, харилцагч талууд** | **Асуудалд хэрхэн оролцож, ямар нөлөө үзүүлж чадах вэ?** | **Асуудлыг шийдэхэд оролцох чадвар/хүсэл эрмэлзлэл** | **Бусад талуудтай тогтоосон харилцаа холбоо (жишээ нь: хамтын ажиллагаа ба зөрчил гм)** | **Үйл ажиллаганы холбогдох чиглэлүүд** | **Зорилго** |
|---|---|---|---|---|---|
| | | Ялангуяа орон нутгийн ажилтнууд нь хэрэглэж буй технологид хяналт тавихад чухал үүрэгтэй. | | | |
| **Байгаль орчны байцаагчид** | Бичил уурхай эрхлэгчдийн асуудлыг олон суманд сайн ойлголттой байж тусалдаг. | Байгаль орчны байцаагчид бүх сумдад байдаг. Бичил уурхайн нөхцөл байдлын талаар ойлголт мэдээлэл сайн боловч бичил уурхайн техникийн мэдлэг, ур чадвар дутагдалтай. | Сумын түвшинд ажиллах гол хамтрагч тал. | Байгаль орчны байцаагчид нь УМХГ-ын удирдлага дор ажилладаг | Байгаль орчны асуудлууд, байгаль орчинтой холбоотой аливаа үйл ажиллагаанд хяналт шалшалтаа тавьдаг |
| **Монголын уул уурхайн ассиацаци (МУУА)** | Албан ёсны том компаниудын ашиг сонирхлыг илэрхийлдэг ч бичил уурхай эрхлэгчидтэй байнга зөрчилд ордог. | Бичил уурхай эрхлэгчидтэй хамтран ажиллахдаа гарч буй зөрчлийг бууруулахтай холбогдон гарах зардлыг бууруулах боломжоос эхлэх хүсэлтэй. | 2002 онд бичил уурхайн тухай анхны хурлыг зохион байгуулсан.<br>ОУХБ-МАОЭХ-ны хэрэгжүүлдэг хүүхдийн хөдөлмөр төсөлтэй хамтран ажилладаг. | Албан ёсны уурхайн шүхэр байгууллага<br>130 компаны 60 орчим гишүүнтэй. | Албан ёсны уул уурхайн компаниудын эрх ашгийг хамгаалах,<br>Уул уурхайн салбарын бодлогын асуудалд онцгой анхаарал хандуулдаг |
| **Монголын ажил олгогч эздийн холбоо (МАОЭХ)** | Бичил уурхайн тухай хууль эрх зүйн орчин тогтооход нэлээд дэмжлэг үзүүлдэг | Төсөлтэй хамтран ажиллах бүрэн боломжтой | ОУХБ/ОУХХУ төсөлтэй хамтран ажилладаг | Ажил олгогч эздийн шүхэр байгууллага<br>Хувийн ба улсын үйлдвэрийн 8,000 гишүүнтэй. | Ажил олгогч эздийн эрх ашгийг хамгаалах |
| **Аймгийн засаг захиргаа** | Бичил уурхай эрхлэгчид нь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг.<br>Зарим аймгууд бичил | Хэд хэдэн аймгуудын засаг захиргаа бичил уурхайтай холбоотой асуудлуудыг нэн даруй шийдвэрлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. | Зарим аймгуудын засаг захирганы ажилтнууд/ удирдлагууд бичил уурхайн асуудлаар төсөлтэй хамтран | Аймгийн хэмжээнп төрийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилладаг.<br>Бичил уурхайн асуудлаар аймгийн хэмжээнд | Аймгийнхаа нийгэм эдийн засгийг хөгжүүлэх гол зорилготой. |

| Хамтрагч, харилцагч талууд | Асуудалд хэрхэн оролцож, ямар нөлөө үзүүлж чадах вэ? | Асуудлыг шийдэхэд оролцох чадвар/хүсэл эрмэлзэл | Бусад талуудтай тогтоосон харилцаа холбоо (жишээ нь: хамтын ажиллагаа ба зөрчил гм) | Үйл ажиллаганы холбогдох чиглэлүүд | Зорилго |
|---|---|---|---|---|---|
| | уурхайн үйл ажиллагааг зохицуулах талаар зарим арга хэмжээ авсан. | Аймаг орон нутгийн хэмжээнд удирдлага менежментийн төвлөрлийг сааруулах, чадварлаг ажилтнуудыг ажиллуулах талаар дутагдалтай. | ажилладаг. | ажиллах гол хамтрагч тал мөн. | |
| **Сумын засаг захиргаа** | Бичилд уурхай эрхлэгчид нь сумдын нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг. | Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах чадвар, эрх мэдэл маш бага хязгаарлагдмал.<br>Зарим сумдууд бичил уурхайн талаар нэлээд сөрөг ойлголттой байхад нөгөө хэсэг нь бичил уурхайтай холбоотой гардаг нийгэм, эрх зүйн зөрчлүүдийг бууруулахыг зорьдог. | Албан ёсны том уурхайнууд орон нутгийн засаг захиргаанаас зөвшөөрөл авах ёстой гэсэн хууль эрх зүйн зохицуулалт байдаг болохоор сумдууд нь гол чухал үүрэгтэй байна. | Одоогоор 100 орчим сум (360 сумаас)-нд бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж байна.<br>Орон нутгийн хэмжээнд бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулахад гол харилцагч хамтрагч тал байна. | Сумынхаа нийгэм-эдийн засгийг хөгжлүүлэх гол зорилготой. |
| **Бичил уурхай эрхлэгчид (БУЭ)** | Байгаль орчинд учруулсан хор хохирлын гол буруутан болдог.<br>Нийгмийн үйлчилгээ авах боломж дутагдалтай.<br>Орон нутгийн эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг.<br>Тогвор суурьшилгүй, байнгын шилжилт хөдөлгөөнтэй | Нөөц бүхий газруудыг авч албан ёсны үйл ажиллагаа эрхлэх ба өндөр татвар төлөх хүсэлгүй,<br>Бичил уурхай эрхлэгчид нь зохион байгуулалт (холбоо/ ассоциаци, лобби бүлгүүд, шүхэр байгуулагууд гм) –гүй. | Олборлолтоо ямар ч зөвшөөрөл лизенцигүй явуулдаг болохоор лизенци эзэмшигчидтэй зөрчилд ордог.<br>Малчид зэрэг эрдсийн бус байгалийн нөөц ашиглагчидтай байгаль орчны доройтлын асуудлаар зөрчилд ордог. | Улс хэмжээнд 100,000 орчим бичил уурхай эрхлэгчид (бараг нутаг дэвсгэрийн хэмжээнд) үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Төслийн зорилтот бүлэг. | Амьжиргааны баталгаа,<br>Хүнсний аюулгүй байдал |
| **Албан ёсны уул** | - Зарим газруудын | - Бичил уурхай | - Олонхи нь бичил | Үйл ажиллагаагаа явуулж | Ашигт малтмал |

| Хамтрагч, харилцагч талууд | Асуудалд хэрхэн оролцож, ямар нөлөө үзүүлж чадах вэ? | Асуудлыг шийдэхэд оролцох чадвар/хүсэл эрмэлзлэл | Бусад талуудтай тогтоосон харилцаа холбоо (жишээ нь: хамтын ажиллагаа ба зөрчил гм) | Үйл ажиллаганы холбогдох чиглэлүүд | Зорилго |
|---|---|---|---|---|---|
| **уурхайн компаниууд** | шороон орд бүхий газруудад хоцрогдсон технологи хэрэглэдэг нь байгаль орчинд хор хохирол их учруулдаг. Иймд хаягдал овоолгыг бичил уурхай эрхлэгчдээр дахин ашиглуулдаг. | эрхлэгчидтэй хамтран ажиллахдаа гарч буй зөрчлийг бууруулахтай холбогдон гарах зардлыг бууруулах боломжоос эхлэх хүсэлтэй.<br>- шинээр бий болгосон зарим уурхайнууд технологи ба байгаль орчны стандартуудыг гаднаас оруулж ирж байна. | уурхай эрхлэгчидтэй зөрчилд ордог.<br>- Зарим нь бичил уурхай эрхлэгчидтэй хамтран ажиллах гэрээг хоёр талын ашгийг үндэслэн байгуулсан. | буй 130 компаниуд байна.<br>Одоогоор эдгээр компаниуд нь хайгуул ба ашиглалтын албан ёсны лизенци (газар нутгийн барag 50 %-д) эзэмшигчид байна. | олборлох |
| **Бичил уурхайн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч хувийн компаниуд** | Бичил уурхайд ашиглагддаг тоног төхөөрөмж багаж хэрэгслийг үйлдвэрлэдэг. | Чанартай, аюулгүй ажиллагаа бүхий тоног төхөөрөмж үйлдвэрлэх чадвар, мэдлэг одоогоор байхгүй байна. | | Тодорхой чадвартай болсноор бичил уурхай эрхлэгчдийн гол харилцагч хамтрагч талууд болно. | Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл үйлдвэрлэх |
| **Шинжлэх ухаан техникийн их сургуулийн Уул уурхайн их сургууль (ШУТИС-ийн УУИС)** | Бичил уурхайн тухай хуулийн төсөл боловсруулахад оролцсон. | Туршлагатай судлаачид эрдэмтэд, профессорууд байдаг ч хөрөнгө санхүү дутагдалтай | Бичил уурхай эрхлэгчдийн дунд техникийн ба удирдан зохион байгуулах чадавхийг бий болгох талаар Сайнт Мэри (Халифакс)-гийн их сургуультай хамтарч ажилладаг. | ШУТИС нь Монгол орны уул уурхайн салбарын мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэдэг ганц их сургууль. | Сургалт/ боловсролын ба судалгааны ажлууд явуулдаг, |
| **Civil Movements** | Албан ёсны ба албан бус олборлолтын явцад бий болсон байгаль орчны бохирдол, хор хохирлын эсрэг тэмцдэг байгууллагууд. | Байгаль орчин ба нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх чин эрмэлзэлтэй.<br>Хөрөнгө санхүүжилт | Зарим хэсэг нь гарч буй зөрчлийг аль болох тайван замаар шийдэх эрмэлзэлтэй байхад нөгөө хэсэг нь уул уурхайн үйл | Олон нийтийн дэмжлэг бүхий орон нутгийн анхан шатны хөдөлгөөн<br>Төр засгийн газарт асуудлыг хүргэдэг ба зарим хэсэг нь гадны | Эх нутаг усаа хамгаалах олон нийтийн хөдөлгөөнүүд нь байгалийн нөөцийн ашиглалтыэ асуудлаар нутгийн |

| **Хамтрагч, харилцагч талууд** | **Асуудалд хэрхэн оролцож, ямар нөлөө үзүүлж чадах вэ?** | **Асуудлыг шийдэхэд оролцох чадвар/хүсэл эрмэлзлэл** | **Бусад талуудтай тогтоосон харилцаа холбоо (жишээ нь: хамтын ажиллагаа ба зөрчил гм)** | **Үйл ажиллаганы холбогдох чиглэлүүд** | **Зорилго** |
|---|---|---|---|---|---|
| | | дутагдалтай | ажиллагааны сөрөг үйл ажиллагааны эсрэг тэмцэх зорилготой байгууллагдсан байдаг. | донор байгууллагуудын дэмжлэгтэй үйл ажиллагаагаа явуулдаг | иргэдийн эрх ашгийг хамгаалах тусгах зорилготой үйл ажиллагаагаа явуулдаг. |
| **Малчид зэрэг олборлолт эрхэлдэггүй орон нутгийн хүмүүс** | Зарим газрууд уул уурхай, бичил уурхайн үйл ажиллагаанд илүү их өртөж байгаль орчинд өөрчлөлт (гол ус ширгэж алга болох, усны бохирдолт, тоосжилт гм) гарч байна. | Нэгдмэл биш, шилжилт хөдөлгөөн ихтэй, зохион байгуулалтгүй, дуу хоолойгоо гаргадаггүй.<br>Бичил уурхай эрхлэгчидтэй гардаг зөрчлийг бууруулах түүнтэй холбоотой зардлыг бууруулах боломжуудоос эхлэх хүсэл эрмэлзэлтэй.<br>Бичил уурхай эрхлэгчдийн олонхи нь өмнө малчид байсан хүмүүс байдаг. | Уул уурхайн албан ёсны компаниуд болон бичил уурхай эрхлэгчидтэй зөрчилд ордог. | Улс орны хэмжээнд 170,000 орчим малчид байдаг.<br>Малчид нь олон зууны туршид бэлчээр газар нутгаа уламжлалт аргаар ашиглаж ирсэн. | Амьжиргааны баталгаа,<br>Хүнсний аюулгүй байдал |
| **НҮБ-ийн хүн амын сан, ХГУ-ын ГШУЭБХ, Дэлхийн банк, ОУХБ зэрэг донор хандивлагчид** | Донорууд бичил уурхайтай холбоотой асуудлуудыг илүү сайн ойлгож дэмждэг болж байна.<br>Бичил уурхайн асуудлуудаар зарим төслүүд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. | Төсөлтэй хамтран ажиллахад бэлэн,<br>Донор байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг тал гарч ирнэ гэж хүлээдэг. | | Харилцан уялдсан, сайн зохион байгуулалттай байж бичил уурхай эрхлэгчдэд үр дүнтэй дэмжлэг үзүүлж дорвитой өөрчлөлтүүдийг гаргах бололцоотой. | Оролцооны аргаар бичил уурхай ба уул уурхайтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх |
| **Судалгаа,** | Бичил уурхайн салбарт | Нөхцөл байдал, бололцоог | Заримдаа прагматик/ | Үнэлгээний аргачлал, | Байгаа боломж |

| **Хамтрагч, харилцагч талууд** | **Асуудалд хэрхэн оролцож, ямар нөлөө үзүүлж чадах вэ?** | **Асуудлыг шийдэхэд оролцох чадвар/хүсэл эрмэлзлэл** | **Бусад талуудтай тогтоосон харилцаа холбоо (жишээ нь: хамтын ажиллагаа ба зөрчил гм)** | **Үйл ажиллаганы холбогдох чиглэлүүд** | **Зорилго** |
|---|---|---|---|---|---|
| **шинжилгээний байгууллагууд** | тодорхой үнэлэлт дүгнэлт гаргах үүднээс холбоо харилцаа тогтоож байна. | тогтоох, харьцуулах ба хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах чадавхи хангалтгүй. | хэрэглээ тал нь хоцрогддог, улсын байгууллагууд нухацтай авч үздэггүй. | технологи, бодит байдалд дүн шинжилгээ хийх, оруулах хувь нэмэр, боломж чадавхийг тогтоож өгдөг. | нөхцөлд дүн шинжилгээ өгч, хөгжлийн арга замыг тогтоох |

## *8.3 “Тогтвортой бичил уурхай” төслийн баг ба төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь*



| Ажлын байр | Үйл ажиллагааны үндсэн чиглэл ба гүйцэтгэх үүргүүд |
|---|---|
| **Steering** | |
| Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлагийн Захирал | Төслийн үйл ажиллагааг тус улс дахь Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулж, Швейцарийн Берн хот дахь төв удирдах газартай холбож, төслийн Захирал ба үндэсний холбогдох талуудтай улс төр ба стратегийн түвшинд харилцан төслийн Удирдах зөвлөлд Швейцарийн хөгжлийн агентлагийг төлөөлж, тус агентлагийн санхүүжилтээр хэрэгждэг төслүүдийн ажилтнуудтай гэрээ хийж, тэдний ажлыг үнэлэх үүрэгтэй ажиллана. Төслийн өмнө хүлээсэн үүргийнхээ холбогдох зарим хэсгийг хөгжлийн агентлагийн Хөтөлбөрийн үндэсний ажилтанд шилжүүлж болно. |
| Төслийн үндэсний захирал | АМГТХЭГ-ыг төлөөлж төслийн ерөнхий үр дүнг хариуцан, төслийн үйл ажиллагааг удирдан хэрэгжүүлэх үндэсний эрхийг төлөөлж, төслийн үйл ажиллагааны үр дүнг Монголын засгийн газрын бодлогын орчинтой уялдуулж, бичил уурхайн салбарт донор байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад тэргүүлэх үүрэгтэй оролцоно. |
| Хөтөлбөрийн үндэсний ажилтан SDC | Швейцарийн хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны хэлтсийг төлөөлж Швейцарийн хөгжлийн агентлагаас төсөлд оруулж буй хувь нэмэр, дэмжлэг туслалцааны зарцуулалтанд хяналт тавьж, төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн зарцуулалтанд хяналт тавьж үйл ажиллагааны хэрэгжилт ба нөөцийн ашиглалтанд хяналт тавина. |
| SDC –ийн төв удирдах газрын ажилтан | Төслийн үйл ажиллагааг Швейцарийн хөгжлийн агентлагийн Дэлхийн байгаль орчны хөтөлбөртэй уялдуулж, Ази-2 ба Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлагийн захирлын хооронд зохицуулах үүрэгтэй ажиллана. Удирдах төв газрын ажилтан нь төслийн үйл ажиллагааны хэрэгжилт ба явцад хяналт тавьж дараахи үүрэгтэй оролцоно. Үүнд:<br>• Гэрээний дагуу санхүүжилтийг олгох<br>• Төсвийн өөрчлөлтийг баталж, эргэн төлөгдөх зардлуудыг дахин хуваарилах, техник зөвлөх багийн өөрчлөлтийг батлах<br>• Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлагтай зохицуулалт хийж төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд үнэлгээ хийх хөндлөнгийн үнэлгээний багийг томилох |
| **Мэргэжилтэн** | |
| Төслийн багийн ахлагч нарын хүлээх ерөнхий үүрэг хариуцлага | Төслийн багийн ахлагчид үйл ажиллагааны ерөнхий чиглэл ба жилийн ажлын төлөвлөгөөний дагуу хариуцсан хэсгийнхээ үйл ажиллагааны хэрэгжилтийг бүрэн хариуцана. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц дизайныг гаргаж, төлөвлөх (зорилт, хамтрагч талууд, аргачлал, хэрэгжүүлэх арга зам, хугацаа, биелэлт зэргийг тогтоох), төлөвлөсөн төсвийн хүрээнд нөөцийн хуваарилалт хийх (төслийн үндсэн шатны хугацаанд ба тодорхой төлөвлөлтийэн хугацаанд), хүний ба материалын нөөцийг хуваарилах, төсөл хэрэгжүүлэгч талуудтай гэрээ байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилтнд мониторинг үнэлгээ явуулах, гарсан үр дүнгүүдийг баримтжуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ авна. Түүнчлэн ахлагч нар нь Бүрэлдхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахаас гадна төслийн менежментэд идэвхитэй оролцон төслийн бусад үйл ажиллагаатай уялдуулж ажиллах |

| Ажлын байр | Үйл ажиллагааны үндсэн чиглэл ба гүйцэтгэх үүргүүд |
|---|---|
| | үүрэг хүлээнэ. Бүрэлдхүүн хэсгийн ахлагчид нь өөрсдийн төдийгүй төслийн багийн бусад гишүүдийн мэргэжлийн чадавхи ба хувь хүмүүсийн хөгжлийг бий болгоход анхаарч ажиллана. Үйл ажиллагааны явцын талаар төслийн менежментийн баг ба Үйл ажиллагааны зөвлөлд тайлагнах журмын дагуу амаар болон бичгээр танилцуулж байх болно. |
| Төслийн менежер ба Бодлого, харилцаа холбооны сүлжээ Project manager, head of policy and networking unit | Төслийн менежер нь нэг талаас Швейцарийн хөгжлийн агентлагийн дүрэм журам, төслийн үндсэн баримт бичиг, Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, төсөв, төслийн Удирдах зөвлөлөөс өгсөн санал дүгнэлтийн дагуу төслийн ерөнхий удирдлага менежментийг хангаж ажиллана. Нөгөө талаас төслийн 4 Бүрэлдхүүн хэсгийн уялдаа холбоо, зохицуулалтыг хангахаас гадна Бүрэлдхүүн хэсэг 1-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хариуцана. Үүнд:<br>▪ Төслийн үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар АМГТХЭГ, төслийн Үндэсний захирал ба SDC-ийн хамтын ажиллагааны хэлтэст тайлагнах,<br>▪ Төслийн Бүрэлдхүүн хэсэг 1-ийг хариуцах,<br>▪ Бичил уурхайн салбартай холбогдох бусад төслүүдийн үйл ажиллагааг төслийн үйл ажиллагаатай уялдуулсан стратегийг боловсруулахад АМГТХЭГ-тай хамтран ажиллах,<br>▪ Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтийг тус агентлагийн дүрэм журмын дагуу захиран зарцуулах,<br>▪ Төлөвлөсөн төсөв, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу төслийн Бүрэлдхүүн хэсгүүдийн дор хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг хуваарилах<br>▪ Төслийн хэрэгжих явцад төслийн менежментийн багийн хүрээнд концепци боловсруулах ажлыг удирдах<br>▪ АМГТХЭГ ба Швейцарийн хөгжлийн агентлагтай хэлэлцэн төслийн төлөвлөлт (жилийн ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны хуваарь, төсвийн зарцуулалт)-ийг эцэслэн боловсруулж, хамтын ажиллагааны сүлжээ бий болгож, төслийн Удирдах зөвлөлөөр төслийн ерөнхий дэд бүтцийг батлуулах,<br>▪ Төслийн ерөнхий дэд бүтцийн менежментийг хариуцах<br>▪ Төслийн багийн гишүүд, ажилтнуудыг удирдлага менежментээр хангаж ажиллана. |
| Бүтэц зохион байгуулалтын багийн ахлагч | Бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх багийн ахлагч нь төсөл ба АМГТХЭГ-ын хооронд гол холбох үүрэгтэй ажиллана. Түүнчлэн төслийн Бүрэлдхүүн хэсэг 2-ийн хэрэгжилтийг хариуцаж ажиллана.  Төслийн менежментийн баг ба төслийн үндэсний захиралд илтгэнэ.  Үүнд:<br>▪ АМГТХЭГ-ын бусад хэлтэс салбартэй холбоо харилцаа тогтоож, төслийн үр  дүн, үр дүн, ололт амжилт, туршлагыг байгууллага бүтцийн хэмжээнд нэвтрүүлэх,<br>▪ Бичил уурхайтай холбогдох бусад төслүүдийн үйл ажиллагааг төслийн үйл ажиллагаатай уялдуулсан стратегийг боловсруулахад АМГТХЭГ-тай хамтран ажиллах,<br>▪ Төслийн үндэсний Менежертэй хамт төслийн үйл ажиллагааны талаар тайлнагнах үүрэгтэй ажиллана. |
| Ашигтай ба хариуцлагатай бичил уурхай | ▪ Бүрэлдхүүн хэсэг 3-ийг хариуцан аюулгүй ажиллагаа, технологийн асуудлыг авч үзэн аюулгүй ажиллагааны стандартыг гаргах, турших, санхүүжилтийг төлөвлөсөн үйл ажиллагааны дагуу  зарцуулж, үйл ажиллагаан  явц, үр дүнгийн талаар төслийн үндэсний Зохицуулагч ба Захирал  Швейцарийн хөгжлийн агентлагт тайлагнана. |

| Ажлын байр | Үйл ажиллагааны үндсэн чиглэл ба гүйцэтгэх үүргүүд |
|---|---|
| багийн ахлагч | |
| Нийгэм экологийн менежмент ба чадваржуулах багийн ахлагч | ▪ Бүрэлдхүүн хэсэг 3-ийн хэрэгжилтийг хариуцаж аюулгүй ажиллагаа, технологийн асуудлаар төсөл боловсруулж хэрэгжүүлэх ба байгаль орчны мониторингийн үзүүлэлтүүд ба технологийг боловсруулж хэрэгжүүлэн, төлөвлөсөн төсвийг зөв зохистой зарцуулж, үйл ажиллагааны явц үр дүнгийн талаар төслийн үндэсний Зохицуулагч ба Захирал Швейцарийн хөгжлийн агентлагт тайлагнана. |
| Нийгмийн ажилтан | ▪ Нийгэм экологийн менежмент ба чадваржуулах Бүрэлдхүүн хэсгийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багийн ахлагчид туслан ажиллах<br>▪ Хөдөө орон нутагт ажиллах, үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажилд оролцох<br>▪ Мониторинг ба үнэлгээ |
| Харилцаа холбоо/ мэдээллийн менежер | ▪ Төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бүтэц зохион байгуулалтын багт туслан ажиллах<br>▪ Бүтэц зохион байгуулалтын багийн ахлагчид тайланг нарийвчлан боловсруулахад туслах<br>▪ Жилийн, хагас жил, улирлын ажлын төлөвлөгөөг боловсруулахад туслах,<br>▪ Төслийн орчлын менежментийг зөв тодорхойлж хэрэгжүүлэхэд төслийн үндэсний менежерт туслах<br>▪ Төслийн жилийн төсөв, төсвийн өөрчлөлт хийх бэлтгэл ажилд туслах<br>▪ Төслийн аймаг, сумдын төлөөлөгчидтэй холбоо тогтоож, тэдний үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах,<br>▪ Төслийн баг (аймаг сумын хэмжээнд ажиллаж байгаа төслийн болон АМГТХЭГ-ийн орон нутгийн төлөөлөгчдийг оролуулан)-ийн хүрээнд үр ашигтай өргөн харилцаа холбооны тогтолцоог бий болгож, чухал мэдээллийн сувгийг бий болгох. |
| **Үндэсний зөвлөхүүд** | |
| Богино хугацааны үндэсний зөвлөхүүд | ▪ Судалгаа ба хөгжил, судалгаа, сургалт ба сургалтын материалууд, зөвлөгөө өгөх зэрэг ехникийн ба техникийн бус тодорхой асуудлаар мэргэжлийн тусламж дэмжлэгийг үйлчилгээ хүргэх Ажил үүргийн хуваарийн дагуу үзүүлэх |
| **Олон улсын зөвлөх** | |
| Төслийн олон улсын зөвлөх | Монгол ба Швейцари улсын дэмжлэгтэй хэрэгжүүлэх энэ төслийн стратеги ба хэрэгжилттэй холбоотой асуудлаар төсөл ба түүний багт олон улсын зөвлөх баг туслах үүрэгтэй ажиллана. Олон улсын зөвлөхүүд ба богино хугацаагаар ажиллах мэргэжилтнүүд нь Швейцарийн хөгжлийн агентлагтай удирдах төв газартай гэрээ хийж ажиллах бөгөөд тэдний үйл ажиллагаанд Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлаг ба АМГТХЭГ хяналт тавина. Дараахи үүрэгтэй |

| Ажлын байр | Үйл ажиллагааны үндсэн чиглэл ба гүйцэтгэх үүргүүд |
|---|---|
| | ажиллана. Үүнд:<br>▪ Олон улсын зөвлөх нь сургалт, чадавхийг бий болгох, технологи, шинэ мэдлэг/ ноу хоу нэвтрүүлэх, төлөвлөлт, тайлагнах, үнэлгээ хийх хөрөнгө санхүүжилт бүрдүүлэх зэрэгт мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллана. Мэргэжлийн зөвлөгөөг төсөл хэрэгжиж буй газарт биечлэн ирж өгөхөөс гадна өөрийн эх орон (Герман)-оос өгнө.<br>▪ Удирдах зөвлөлийн хуралд оролцож бичил уурхайг хөгжүүлэх асуудлаар зөвлөх,<br>▪ Төслийн гол асуудлаар санал солилцох материал бэлтгэж, мэргэжилтнүүдтэй хэлэлцэх<br>▪ Төлөвлөлтөнд хяналт тавьж, зөвлөмжүүд гаргах<br>▪ Төслийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд туслах<br>▪ Төслийн менежментийн баг, Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлаг ба түүний төв удирдах газарт хөгжлийн ба төслийн гол үр дүнгүүдийн талаар тайлагнаж байх. |
| Олон улсын богино хугацааны мэргэжилтнүүд | ▪ Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалын бүтээгдхүүний зах зээл, хууль эрх зүй ба албан ёсны болгох, жижиг төслийн асуудлууд, бүтэц зохион байгуулалттай болгох, мэргэжлийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа зэрэг техникийн ба техникийн бус асуудлаар мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх.<br>▪ |
| **Захиргааны ажилтнууд:** | |
| Нягтлан бодогч / Захиргааны туслах | ▪ Төлөвлөсөн төсөв, дүрэм журам, санхүүжилтийг хуваарилсны дагуу зарцуулалтын төлөвлөх,<br>▪ Банкны ба бэлэн мөнгөний шилжүүлгийг хийж гүйцэтгэх,<br>▪ Төслийн менежмент ба багуудын ахлагч нарт санхүү, холбогдох ажилтнууд, жилийн аудит хяналт шалгалтын талаар байнга мэдээлж байх,<br>▪ Төсөв, санхүүжилтийн зарцуулалтын талаар Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлагийн Үндэсний хөтөлбөрийн ажилтанд холбогдох мэдээллийг цаг тухайд нь өгч байх,<br>▪ Оффис ба ажилтнуудын менежмент (ажлын гэрээ, ээлжийн амралт, чөлөө зэрэгт хяналт тавьж, ажилтнуудын ирцийн бүртгэлийг хөтөлж цалингийн тооцог гаргаж байх)<br>▪ Татварын алба, нийгмийн даатгалын гэзэр зэрэг үндэсний олбогдох байгууллагталуудтай холбоо харилцан хууль дүрэм журмын дагуу ажиллах,<br>▪ Төслийн нэгж ба багт шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл, ерөнхий дэмжлэг туслалцааг бий болгоход туслах үүрэгтэй ажиллана. |
| Орчуулагч/ мөнгөний нярав/ нарийн бичиг | ▪ Төслийн үндэсний менежер, багийн ахлагчид болон бусад ажилтнуудад туслах, уулзалтуудын цаг товлох, утсанд хариулах, илгээмж захидлыг бүртгэх, шаардлагатай албан захидал бичгийг бичих, нэг формат хэлбэрт оруулах, бичиг тэмдэглэл хөтлөх, албан бичиг, материалыг эмх цэгцтэй байрлуулах, ажилтнуудын ирц, амралтын байдалд хяналт тавих зэрэг нарийн бичгийн үүрэгт ажлуудыг гүйцэтгэх,<br>▪ Төслийн ажилтнуудын хурал, уулзалтуудыг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, |

| Ажлын байр | Үйл ажиллагааны үндсэн чиглэл ба гүйцэтгэх үүргүүд |
|---|---|
| | ▪ Холбогдох баримт бичгүүдийг Монгол-Англи-Монгол хэлнээ орчуулах,<br>▪ Төслийн бэлэн мөнгөний зарлагыг хариуцах |
| Хэлмэрч | ▪ Төсөлд богино хугацаагаар ажиллаж буй гадаадын мэргэжилтнүүдэд аман орчуулга хийх (тухайн үед нь) |
| Мэдээлэл техникийн ажилтан | ▪ Компьютрийн дотоод сүлжээний хэвийн ажиллагааг хариуцах,<br>▪ Төслийн нэгжид шаардлагатай програмын авч шинэчлэн, ажилтнуудад шаардлагатай сургалтыг явуулах,<br>▪ Төслийн ажилтнуудад гарын авлага, товхимол зэрэг хэвлэл мэдээллийн материалын эх бэлтгэхэд туслах |
| Үйлчилгээ | ▪ Ажлын байрыг цэвэр байлгаж, ажилтнууд болон бусад шаардлагатай ажилд нь туслах |
| Жолооч нар | ▪ Төслийн машин тэргийг хариуцаж ажиллах<br>▪ Унаа машин тэргэний бүрэн бүтэн байдлыг харицах<br>▪ Хөдөө орон нутагт ажиллахдаа ажилтнуудад үйлчилгээний ажилд нь туслаж хамтран ажиллах (жишээ нь худалдан авалт хийх гм)<br>▪ Улаанбаатар хот дотор албан бичиг, захидал тараах, авах зэрэг төслийн ажилд туслах |
| **Орон нутгийн төлөөлөгчид:** | |
| Баянхонгор | ▪ Бүс нутгийн хэмжээнд АМГТХЭГ ба төслийн орон нутгийн төлөөлөгчдийн үйл ажиллагааг харилцан уялдаатай зохистой хүргэх,<br>▪ АМГТХЭГ ба Швейцарийн хөгжлийн агентлагаас оруулж буй хувь нэмрийн хүрээнд хамтарсан ажлын төлөвлөгөө боловсруулах,<br>▪ Бичил уурхайтай холбоотой асуудлаар аймгийн засаг захиргаатай холбоо харилцаа тогтоох, холбогдох талуудын дунд мэдээллийн суваг бий болгох,<br>▪ Гол чухал хөгжлийн асуудлаар төсөлд мэдээлэл хийх,<br>▪ Бичил уурхайн гол хөгжлийн асуудлаар төсөл ба АМГТХЭГ-т мэдээлэл хийж тайлагнах,<br>▪ Харилцан хамтын ажиллагааг бий болгох<br>▪ Холбогдох асуудлаар дэлгэрэнгүй судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх<br>▪ Төслийн багийн гишүүдийг хөдөө орон нутагт ажиллахад үед дэмжлэг тусламж үзүүлж байх,<br>▪ Нөөц ашиглагчдын хооронд гардаг зөрчлийг бууруулахад орон нутгийн хөдөлгөөнүүдтэй хамтран ажиллах,<br>▪ Бичил уурхай эрхлэгчидтэй ойр ажиллаж, тэдний дуу хоолой, ашиг сонирхлыг төсөлд хүргэхэд туслах,<br>▪ Жижиг төслүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж, тэдний үр дүнгийн талаар төсөлд мэдээлж байх үүрэгтэй. |
| Өвөрхангай ба эсвэл өөр сонгосон аймаг | ▪ Тус бүс нутаг Тогтвортой бичил уурхай төслийг төлөөлөх<br>▪ Бичил уурхайтай холбоотой асуудлаар аймгийн засаг захиргаатай холбоо харилцаа тогтоох, холбогдох талуудын дунд мэдээллийн суваг бий болгох,<br>▪ Бичил уурхайн гол хөгжлийн асуудлаар мэдээлэл байнга хийж байх, |

| Ажлын байр | Үйл ажиллагааны үндсэн чиглэл ба гүйцэтгэх үүргүүд |
|---|---|
| | ▪ Холбогдох асуудлаар дэлгэрэнгүй судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх<br>▪ Төслийн багийн гишүүдийг хөдөө орон нутагт ажиллахад үед дэмжлэг тусламж үзүүлж байх, |
| Шинэжинст | ▪ Орон нутагт Тогтвортой бичил уурхай төслийг төлөөлөх<br>▪ Бичил уурхайтай холбоотой асуудлаар сумын засаг захиргаатай холбоо харилцаа тогтоох, холбогдох талуудын дунд мэдээллийн суваг бий болгох,<br>▪ Гол чухал хөгжлийн асуудлаар төсөлд мэдээлэл хийх,<br>▪ Сургалт, судалгааг явуулахад дэмжлэг үзүүлдэг байх,<br>▪ Туршилтын журмаар төслөөс хүлээлгэн өгсөн нөөц (жишээ нь: Мэдээлэл соёлын төв ба бусад тоног төхөөрөмж)-ийг тогтвортой зохистой ашиглах нөхцөл бүрдүүлэх,<br>▪ Төслийн багийн гишүүдийг хөдөө орон нутагт ажиллахад үед дэмжлэг тусламж үзүүлж байна. |
| Бөмбөгөр | ▪ Орон нутагт Тогтвортой бичил уурхай төслийг төлөөлөх<br>▪ Бичил уурхайтай холбоотой асуудлаар сумын засаг захиргаатай холбоо харилцаа тогтоох, холбогдох талуудын дунд мэдээллийн суваг бий болгох,<br>▪ Гол чухал хөгжлийн асуудлаар төсөлд мэдээлэл хийх,<br>▪ Сургалт, судалгааг явуулахад дэмжлэг үзүүлдэг байх,<br>▪ Туршилтын журмаар төслөөс хүлээлгэн өгсөн нөөц (жишээ нь: Мэдээлэл соёлын төв ба бусад тоног төхөөрөмж)-ийг тогтвортой зохистой ашиглах нөхцөл бүрдүүлэх,<br>▪ Төслийн багийн гишүүдийг хөдөө орон нутагт ажиллахад үед дэмжлэг тусламж үзүүлж байна. |
| Заамар | ▪ АМТХЭГ-ийг орон нутагт төлөөлөх<br>▪ Бичил уурхайн асуудлаар орон нутгийн засаг захиргаа, хамтрагч талуудын дунд харилцаа холбоо бий болгох,<br>▪ Орон нутгийн хөгжлийн асуудлаар төсөлд мэдээлэл хийх,<br>▪ Төслийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд, дэлгэрүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх,<br>▪ Төслийн багийг орон нутгийн оролцогч талуудтай холбоотой ажиллахад туслана. |
| Уянга | ▪ АМТХЭГ-ийг орон нутагт төлөөлөх<br>▪ Бичил уурхайн асуудлаар орон нутгийн засаг захиргаа, хамтрагч талуудын дунд харилцаа холбоо бий болгох,<br>▪ Орон нутгийн хөгжлийн асуудлаар төсөлд мэдээлэл хийх,<br>▪ Төслийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд, дэлгэрүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх,<br>▪ Төслийн багийг орон нутгийн оролцогч талуудтай холбоотой ажиллахад туслана. |

## 8.4 *Донорууд ба тэдгээрийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслүүд, хамтын ажиллагааг хөгжүүлж болох салбарууд*

| **Донорууд ба төсөл хөтөлбөрүүд** | **Зорилго, гол чиглэл** | **Хамтын ажиллагааг хөгжүүлж болох салбар/ чиглэл** |
|---|---|---|
| **Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлдэг бусад төслүүд** | Нөөцийн тогтвортой цогц менежмент | Монголын баруун бүсд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг уялдуулах,<br>Бэлчээрийн экосистемийн менежмент хөтөлбөртэй орхигдсон талбайг нөхөн сэргээх талаар хамтран ажиллах,<br>Орлого бүрдүүлэх ба цөлжилтийн төслүүдтэй орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах. |
| **Дэлхийн банк** | Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэг (CASM) нь Дэлхийн банкны төвд байрладаг.<br>Монголын уул уурхайн салбарын тайланг гаргасан, Уул уурхай, эрх зүй, байгаль орчин үндэсний зөвлөлгөөнд оролцсон. | Монгол улсад Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэгийн ээлжит хуралдааныг зохион байгуулахад хамтрах,<br>Уул уурхай, эрх зүй, байгаль орчин үндэсний зөвлөлгөөн зохион байгуулахад хамтрах |
| **АНУ-ын элчин сайдын яам / АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг** | АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг нь уул уурхайн салбарт үнэлгээ хийж, магадгүй уул уурхайн шинэ төсөл хэрэгжүүлэх зорилгоор хийж болох юм. | Үнэлгээний үр дүнгээс хамаарна. |
| **ОУХБ/ Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр**<br>*“Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах” үндэсний дэд хөтөлбөрийг дэмжих.*<br>**Төслийн хугацаа:** 09/05-12/09 | *Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах* үндэсний дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх | Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон нийтийн мэдээлэл сурталчилгааг бий болгох замаар Хүүхдийн хөдөлмөрийг устгах төсөлтэй хамтран ажиллах, сургуулийн насны хүүхдүүдэд сургалтууд зохион байгуулах,<br>Бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах ба бодлого хууль эрх зүйн асуудлуудаар хамтран ажиллах |

| Донорууд ба төсөл хөтөлбөрүүд | Зорилго, гол чиглэл | Хамтын ажиллагааг хөгжүүлж болох салбар/ чиглэл |
|---|---|---|
| **НҮБ-ын хүн амын сан (UNFPA)**<br>*Хот орчмын ба албан бус олборлолт явуулж буй газруудын нийгэм эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах төсөл*<br>**Төслийн хугацаа:** 07/06-12/07 | Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст нийгмийн наад захын үйлчилгээ (нөхөн үржихүйн эрүүл мэнд) –г хүргэхэд тусламж дэмжлэг үзүүлэх | Бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээ ба ажлын эрүүл ахуйн талаар явуулын үйлчиилгээ үзүүлэх нэгжүүдийг бий болгох,<br>Бичил уурхай эрхлэгчддэд хөгжлийн сургалтууд ба зан харилцааны талаар ДОХ/ДХХШ-ээс сэргийлэх сургалт мэдээллийн материалууд гаргах<br>Бичил уурхайн тухай хуулийг сурталчилах |
| **ПАСТ**<br>*ДОХ/ ДХХШ-ээс сэргийлэх төсөл*<br><br>**Төслийн хугацаа:**<br>Туршилтын шат: 03/2007 - 06/2007,<br>Үндсэн шат: 07/2007 - 06/2012 | ДОХ/ДХХШ ба бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх ба өндөр эрсдэл бүхий нийгмийн бүлгүүд (бичил уурхай эрхлэгчид) –дэд чиглэж үйл ажиллагаагаа явуулах | Бичил уурхай эрхлэгчдэд ДОХ/ДХХШ ба бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх талаар сургалт явуулах,<br>Эрүүл мэндийн явуулын нэгжүүдийг бий болгох, анхны тусламж хүргэх хичээл заах, сайн дурын зөвлөгөө өгөх, шинжилгээ өгөх, бэлгэвч тараах,<br>Сургалт, харилцаа мэдээллийн материал бичил уурхай эрхлэгчдэд зориулж бэлтгэх, тараах |
| **Нээлттэй нийгэмлэг форум** | Бодлогын судалгаа, дүн шинжилгээ, ба олон нийтийн мэдээлэл авах боломжуудыг олгодог, Бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд мониторинг хийхэд тусалдаг, Ашигт малтмалын тухай хууль ба бодлого нь форумын гол анхаарлын төвд байдаг, Олборлох үйлдвэрүүдийн ил тод байдал үүсгэл санаачлагыг дэмждэг. | Хамтрагч, харилцагч талуудын сургалтууд, харилцан ярилцлага хийх<br>Бичил уурхайн бодлогын асуудлууд ба Уул уурхай, эрх зүй, байгаль орчин үндэсний зөвлөлгөөн зохион байгуулахад хамтрах |
| **Азийн сан**<br>*Байгаль орчны хөтөлбөр* | Хүний эрүүл мэнд ба байгаль орчны эрүүл ахуй хамгаалах үүднээс нөөцийн хариуцлагатай ашиглалтыг дэмжих | Бичил уурхай эрхлэгчдийн ассосиацийг байгуулж бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх<br>Бичил уурхай эрхлэгчид, албан ёсны компаниуд, малчид, ба орон нутгийн иргэдийн хоорон гардаг зөрчлийг бууруулах үүднээс оролцогч хамтрагч талуудын уулзалтыг зохион байгуулах |

| **Донорууд ба төсөл хөтөлбөрүүд** | **Зорилго, гол чиглэл** | **Хамтын ажиллагааг хөгжүүлж болох салбар/ чиглэл** |
|---|---|---|
| **Монгол дахь Адвентист хөгжил туслалцааны агентлаг (ADRA)**<br>**Төсөл:** *Бичил бизнесийг дэмжье,өөртөө туслах бүлэг хөтөлбөр*<br>**Төслийн хугацаа:** 01/06 – 09/07 (3-5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр төлөвлөж байна)<br>**Project:** Баянхонгор өрхийн тариалангийн санаачлага<br>**Төслийн хугацаа:** 01/05-12/07 | Өөртөө туслах бүлгүүдээр дамжуулан ядуу хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх,<br>Банк санхүүгийн байгууллагуудыг ядуу хүмүүст үйлчилгээгээ хүргэдэг болгох боломжийн талаар судлах.<br>Баянхонгор аймгийн хөдөөгийн ядуу иргэдийн хүнсний ба орлогын баталгааг дээшлүүлэх | Өөртөө туслах бүлэг хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбон тусламж үзүүлэх техникийн тусламж ба сургуултууд явуулах, бичил уурхай эрхлэгчдэд банкны үйлчилгээ, хадгаламж, бичил бизнесийг эхлүүлэхэд туслах<br>Албан ёсны салбарын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй гарааны мөнгөний зохицуулалт хийх<br>Бичил уурхай эрхлэж буй газруудад хөдөө аж ахуй эрхлэх арга техникийн сургалтууд явуулах<br>Бичил уурхайчдын дунд хөдөө аж ахуйн хоршоолол байгуулах техникийн тусламж, дэмжлэг үзүүлэх |
| **Гео-шинжлэх ухаан эрдэс баялагийн хүрээлэн (BGR)**<br>*Уул уурхай дахь байгаль орчны хамгаалал (EPM)*<br>**Төслийн хугацаа:** эхний шат: 10/2005-10/2008, төслийн төлөвлөж буй хугацаа: 2005-2010 | Уул уурхай дахь байгаль орчны хамгаалал, шинэ арга, технологийг хэрэгжүүлэх талаар байгаль орчны байцаагчдыг чадавхи бий болгох, нөхөн сэргээлтийн аргуудаар сургалт явуулах, уул уурхайн хууль, дүрэм журмын хэрэгжилтийг дэмжих | Байгаль орчны байцаагчдад сургалт явуулж, чадавхийг бий болгох ажлын хүрээнд бичил уурхай эрхэлж буй газруудын байгаль орчны хамгааллын асуудлаар хамтран ажиллах, хууль эрх зүй, дүрэм журмын талаар мэдлэг ойлголтыг сайжруулах, Уул уурхайн сайн туршлагаас сэдэвт хамтарсан сургалт семинарыг зохион байгуулах, Уул уурхай, эрх зүй, байгаль орчин үндэсний зөвлөлгөөн зохион байгуулахад хамтрах |
| **Ст. Мэригийн их сургууль, Халифакс (CIDA)**<br>*Байгаль орчны боловсрол::Монгол улс дахь уул уурхай*<br>**Төслийн хугацаа:** until June 2010 | ШТУИС-тай хамтран бичил уурхай эрхлэгчдийн дунд техникийн ба удирдан зохион байгуулах чадавхийг бий болгох, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд тогтвортой үйл ажиллагааг эрхэлдэг болгох | Бичил уурхай эрхлэгчдийн дунд газрын доройтлыг бууруулах, газрын нөхөн сэргээлтийг үр дүнтэй явуулах сургалтыг хамтран явуулах.<br>ШТУИС-ийн оюутнуудад судалгааны ажил хийх, төслийн үйл ажиллагаанд оролцуулах боломж олгох |
| **Касселын их сургууль (Germany)**<br>*Усны нөөцийн цогц менежтент төсөл*<br>**Төслийн хугацаа:** 08/2006-07/2009 | МУИС ба Касселийн их сургуулиудын хооронд Хойд Ази, Монголд уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөө судалгааны төсөл хамтран хэрэгжүүлэх | Бичил уурхайн салбар дахь усны нөөцийн менежмент судалгааг хамтран явуулах |

| **Донорууд ба төсөл хөтөлбөрүүд** | **Зорилго, гол чиглэл** | **Хамтын ажиллагааг хөгжүүлж болох салбар/ чиглэл** |
|---|---|---|
| **Дани ба Грийландын геологийн судалгаа (GEUS)**<br>*Ази, Африкийн бичил уурхай* | Төлөвлөж буй үйл ажиллагаа:<br>Эмч, бичил уурхай эрхлэгч нарт зориулсан сургалт (мөнгөн усны асуудлаар)-ын хөтөлбөр, Бороо голын хэсэг дэхь хаясан мөнгөн усны цэвэрлэгээ | Мөнгөн усны асуудлаар бичил уурхай эрхлэгчид ба эмнэлгийн ажилтнуудад сургалт явуулах, сонгосон газруудын мөнгөн усны бохирдлыг цэвэрлэх талаар хамтран ажиллах боломжтой. |